

**Эрүүл мэндийн яамны 2023 оны  
гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд  
хийсэн хяналт-шинжилгээний дүн**

***Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго***

Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн, хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэхийг нягтлах, арга хэмжээ тус бүрийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай санал, зөвлөмжийг боловсруулах, шийдвэр гаргагч нарт холбогдох мэдээлэл өгөх зорилгоор хяналт-шинжилгээг хийж гүйцэтгэсэн болно.

***Хоёр. Хяналт-шинжилгээ үнэлгээний арга зүй***

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4.4 дүгээр заалт, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Аргачлал, загвар батлах тухай” 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу тус яамны Төрийн захиргааны удирдлагын газар нь байгууллагын үйл ажиллагааны тайланг нэгтгэж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлсэн болно. Журмын 6.2.1, 6.2.2 болон 6.7 дугаар заалтуудыг үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Эрүүл мэндийн яамны 2023 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэсэн болно. Үнэлгээг бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хувийг тодорхойлох аргачлалаар тооцон гаргасан болно.

***Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн***


Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 207 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс гадна “Төсвийн тухай хууль”-ийн 69 дүгээр зүйлийг дагуу Дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөнд 17 ажлыг тусад нь төлөвлөж хэрэгжүүлдэг. Тайлант онд төлөвлөсөн ажлаас 104 ажил буюу нийт ажлын 50%-нь 100 хувийн хэрэгжилттэй; 10 ажил буюу 4.8%-нь 90 хувийн хэрэгжилттэй; 26 ажил буюу 12.6%-нь 70 хувийн хэрэгжилттэй; 22 ажил буюу 10.6%-нь 50 хувийн хэрэгжилттэй; 23 ажил буюу 11.6%-нь 30 хувийн хэрэгжилттэй; 22 ажил буюу 10.6%-нь 0 хувийн хэрэгжилттэй байгаа ба ЭМЯ-ны

2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 71.7% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэв.

Хүснэгт 1 . Хяналт-шинжилгээний чанарын үзүүлэлт

| Үнэлгээ  | Арга хэмжээ |            |
|--|-------------|------------|
|  | Тоо         | Эзлэх хувь |
| <b>100 хувь</b> буюу “бүрэн хэрэгжсэн”   | 104         | 50         |
| <b>90 хувь</b> буюу “зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүнд нь гарч эхэлж байгаа”   | 10          | 4.8        |
| <b>70 хувь</b> буюу “тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа”            | 26          | 12.5       |
| <b>50 хувь</b> буюу “тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн”  | 22          | 10.6       |
| <b>30 хувь</b> буюу “тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа”   | 23          | 11.5       |
| <b>0 хувь</b> буюу “тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй” | 22          | 10.6       |
| Нийт   | 207         | 100.0%     |
| Дундаж   | 71.7%       |            |


Зураг 1. Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн эзлэх хувь



Хүснэгт 2. 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт (хариуцсан нэгжээр)

| № | Газар  | 2023 онд төлөвлөсөн нийт ажил | Төлөвлөгөөний хэрэгжилт, хувь |           |           |           |           |           |
|---|--------|-------------------------------|-------------------------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
|   |        |                               | 100%                          | 90%       | 70%       | 50%       | 30%       | 0%        |
| 1 | БТГ    | 36                            | 11                            | 2         | 5         | 9         | 6         | 3         |
| 2 | НЭМГ   | 45                            | 18                            | 2         | 8         | 5         | 5         | 7         |
| 3 | ЭТҮГ   | 30                            | 13                            | -         | 4         | 2         | 6         | 5         |
| 4 | СЭЗГ   | 21                            | 11                            | 1         | 4         | -         | 3         | 2         |
| 5 | ТЗУГ   | 40                            | 30                            | 2         | 4         | 3         | -         | 1         |
| 6 | ХШҮДАГ | 21                            | 16                            | 2         | -         | 1         | -         | 2         |
| 7 | СХГ    | 14                            | 5                             | 1         | 1         | 2         | 3         | 2         |
|   |        | <b>207</b>                    | <b>104</b>                    | <b>10</b> | <b>26</b> | <b>22</b> | <b>23</b> | <b>22</b> |

Зураг 2. Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн хувь (хариуцсан нэгжээр)



## ***Дөрөв. Дүгнэлт***

- ❖ Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 71.7 хувийн хэрэгжилттэй байна. Төлөвлөгөөнд 207 ажил батлагдсанаас 104 ажил буюу нийт ажлын 50% нь бүрэн хэрэгжсэн байна. 10 ажил буюу 4.8%-нь 90 хувийн хэрэгжилттэй; 26 ажил буюу 12.6%-нь 70 хувийн хэрэгжилттэй; 22 ажил буюу 10.6%-нь 50 хувийн хэрэгжилттэй; 23 ажил буюу 11.6%-нь 30 хувийн хэрэгжилттэй; 22 ажил буюу 10.6%-нь хэрэгжээгүй байна. 0-30% буюу үр дүнгүй 45 ажлыг дурдвал:
  - 0 буюу хэрэгжээгүй 22 ажил байна:
    1. ЭТҮГ-5 ажил (20,119,130,132,133)
    2. НЭМГ-7 ажил (5, 7, 41, 44, 51, 55, 56)
    3. СХГ-2 ажил (198, 207)
    4. СЭЗГ-2 ажил (23,105)
    5. БТГ-3 ажил (59, 70, 99)
    6. ХШҮДАГ-2 ажил (185, 186)
    7. ТЗУГ-1 ажил (117)
  - 30% буюу “тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа” 23 ажил байна:
    1. ЭТҮГ-6 ажил (32, 42, 125, 129, 131, 135)
    2. НЭМГ-5 ажил (1, 19, 38, 48, 53)
    3. СХГ-3 ажил (195, 196, 206)
    4. СЭЗГ-3 ажил (27, 28, 116)
    5. БТГ-6 ажил (57, 58, 60, 61, 71, 83)
- ❖ Эрүүл мэндийн яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт хагас жилээр 57.4% буюу “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн бол жилийн эцсийн гүйцэтгэл 72.0% байгаа нь “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэв.
- ❖ Төлөвлөлт оновчгүй буруу томъёолох асуудал байсаар байна. Тухайлбал, ЭМЯ-ны төлөвлөгөөний 81 дугаарт “Тусгай сангийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулж, тайлагнана” (СЭЗГ-СДХ) Хөрөнгө зарцуулна гэж төлөвлөхгүй бөгөөд хуулийн хүрээнд ямар үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг бичнэ. ЭМЯ-ны төлөвлөгөөний 36 дугаарт “Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх” ажил төлөвлөгдөж, шалгуур үзүүлэлт нь “тайланг хүлээн авсан байна” гэж тусгажээ. (НЭМГ-УСХЗХ) Өөрөөр хэлбэл

бусад байгууллагын тайланг хүлээж авснаар уг төлөвлөгөө хэрэгжсэн байх боломжгүй бөгөөд, тайланг хүлээн авсны дүнд нь ямар арга хэмжээ хэрэгжүүлэхийг төлөвлөнө.

- ❖ Төлөвлөлтөөс гадна тайлагналт оновчгүй, тодорхойгүй байна. Тухайлбал, ЭМЯ-ны төлөвлөгөөний 113 дугаарт “Шуурхай удирдлагын нэгж байгуулах” (НЭМГ-ХӨХ) ажлын хүрээнд ДЭМБ-ын санхүүжилтээр тоног төхөөрөмж хуваарилсан тухай тайлан бичжээ. Тоног төхөөрөмжөөр хангах нь нэгж байгуулахад дэмжлэг үзүүлж байгаа ажлын нэг хэсэг юм. “Шуурхай удирдлагын нэгж байгуулах” ажлын хүрээнд удирдлага, зохион байгуулалтын ямар үйл ажиллагаа хэрэгжүүлснийг бичнэ.
- ❖ Эрүүл мэндийн яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан газар, хэлтсүүдийн төлөвлөгөөг хүний нөөцтэй нь харьцуулахад харилцан адилгүй төлөвлөгдсөн буюу ажлын ачаалал жигд бус байгааг харуулж байна.
- ❖ Хэрэгжилт хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай үйл ажиллагаануудын тодорхой хувийг тухайн ажлын байр хүнгүй байгаагаас шалтгаалсан байна.

### **Тав. Зөвлөмж**

1. Эрүүл мэндийн яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийцүүлэн оновчтой зөв тодорхойлох
2. Дээрх бодлогын баримт бичиг, хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг яамны болон газар хэлтсийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, улмаар тусгасан эсэхэд газар хэлтсийн дарга нар хяналт тавьж ажиллах
3. Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хяналт-шинжилгээний дүнгээр хэрэгжээгүй буюу хэрэгжилт хангалтгүй 45 ажлаас 11 ажил ЗГҮАХ-т, 6 ажил ЗГҮАХ болон МУХЖТ-нд тус тус тусгагдсан тул ЭМЯ-ны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилд тусгаж, үйл ажиллагааг эрчимжүүлэх
4. Тайлагналтыг оновчтой, шалгуур үзүүлэлтийн дагуу товч, тодорхой тайлагнаж хэвших
5. Хэрэгжилт хангалтгүй, эрчимжүүлэх шаардлагатай үйл ажиллагаануудын тодорхой хувийг тухайн ажлын байр хүнгүй байгаагаас шалтгаалсан байх тул

ЭМЯ-ны дэргэдэх ТАСЗ хүний нөөцийн сул орон тоог нөхөж, яамны хэвийн үйл ажиллагааг хангах

Эрүүл мэндийн яам  
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ 2023 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин                       | Зорилтот түвшин   | Хариуца х нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|--|--|-----------------|---|------------------------------------|---|----------------|--|----------------|
| НЭГ. "КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ" БОДЛОГЫН ХҮРЭЭНД:  |  |                 |   |                                    |   |                |  |                |
| 1.1 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээ |  |                 |   |                                    |   |                |  |                |
| 1.   | ЗГҮАХ 1.1.1.5<br>Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх | -               | Мэдээлэл, сурталчилгаа-ны тоо, төрөл, хандалтын тоо   | -                                  | Мэдээлэл, сурталчилгааг тогтмол хийж, сургалт зохион байгуулсан байна.  | НЭМГ-УСХЗХ     | ДЭМБ-ын 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуультай хамтран "Барилгын салбарын ажил олгогч, удирдлагуудад зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй"-н сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 19, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий ойлголт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд мөрдөх хууль, дүрэм, журам, стандарт, байгууллагын ХАБЭА-н удирдлага, зохион байгуулалт, дүрэм, журам, ажлын байрны эрсдэлийг илрүүлэх, үнэлэх арга, урьдчилан сэргийлэлтийн зарчим, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг илрүүлэх, үнэлэх арга, урьдчилан сэргийлэлтийн зарчим зэрэг сэдвийн хүрээнд барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч, захирал, ерөнхий менежер зэрэг 60 удирдах ажилтныг хамруулж, кредиттэй сертификат олгосон. | 30             |
| 2.   | ЗГҮАХ 1.1.2.4<br>Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулна.  | 8,000.0         | Вакцинжуулал-тад хамрагдалтын хувь  | Вакцинжуулалтын хувь 98.4% байсан. | Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн 80%-аас доошгүй хувийг улирлын томуугийн вакцинжуулалт ад бүрэн хамруулсан байна.   | НЭМГ-ХӨХ       | Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд хамруулахаар 300,000 хүн/тун вакциныг НҮБ-ын Хүүхдийн санд захиалж, 5.5 тэрбум төгрөгийг шилжүүлэн 2023 оны 10 дугаар сард нийлүүлэгдсэн. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/358 дугаар тушаалын дагуу зорилтот бүлгийн хүн амд буюу 2-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, 65-аас дээш насныхан, эрүүл мэндийн болон бусад холбогдох байгууллагын ажил мэргэжлийн хүмүүсийг улирлын томуугийн вакцинд хамруулсан. 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн байдлаар томуугийн вакцинжуулалт улсын хэмжээнд 90.5% (271,615) байна.  | 70             |
| 3.   | ЗГҮАХ 1.1.2.7<br>Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотой судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг батлуулах, судалгааны ажил болон санхүүжилтийг шийдвэрлүүлж, үр дүнг хүлээж авна.  | 600.0           | Холбогдох чиглэлээр шинээр хийж эхэлсэн болон 2023 онд үр дүнг нь хүлээн авсан судалгааны тоо |                                    | Эрсдэлт бүлгийн хүн амд суурилсан SARS CoV-2-ийн халдварын тандалт судалгаа болон КОВИД-19-ийн эсрэг хэрэгжүүлж буй нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, эрүүл | БТГ-СТХ        | АҮЭЗХХ-ны хурлаар (КОВИД-19)-ийн ШУТС-аас санхүүжилттэй, ЭМЯ-ны захиалгат болон ЭМЯ-наас санхүүжилттэй нийт 9 судалгааны төсөлт ажлын судалгааны үр дүнг хүлээн авсан. Төслүүдийн үр дүнгүүд олон улсын сэтгүүлд эрдэм шинжилгээний 7 өгүүлэл хэвлэгдсэн. Эрсдэлт бүлгийн хүн амд суурилсан SARS CoV-2-ийн халдварын тандалт судалгаа болон КОВИД-19-ын эсрэг хэрэгжүүлж буй нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, эрүүл мэндийн байгууллага, иргэдийн бэлэн байдал, орчин үеийн мэдээллийн технологийн судалгааны нийт 8 өгүүлэл гадаадын Web of Science scopus-д бүртгэлтэй сэтгүүлүүдэд 2023 онд хэвлэгдэн гарсан. "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн туршлага, сургамж" салбар дундын Эрдэм шинжилгээний хурлыг  | 100            |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|--|--|--|---------------|---|----------------|
|     |   |                 |  |  | мэндийн байгууллага, иргэдийн бэлэн байдал, орчин үеийн мэдээллийн технологийн судалгаа хийнэ. |               | 5 дугаар сард зохион байгуулж, Илтгэлийн хураангуйн эмхэтгэл (242 илтгэлийн хураангуйг багтаасан) номыг 2000 хувь хэвлэн олны хүртээл болгосон.   |                |
| 4.  | ЗГҮАХ 1.1.3.1<br>КОВИД-19 цар тахлын халдвартай тэмцэх хариу арга хэмжээнд олон улсын дэмжлэг, туслалцаа авах, эм, эмнэлгийн болон хувийн хамгаалах хэрэгслийн нөөцийг бүрдүүлнэ. |                 | Бүрдүүлсэн нөөцийн хэмжээ.                                 | -  | Салбарын хариу арга хэмжээнд шаардлагатай нөөцийг гадаад эх үүсвэрээс нэмэгдүүлсэн байна.      | ТЗУГ-ГХХ      | 2023 оны жилийн эцсийн байдлаар гадаад хамтын ажиллагааны хүрээнд КОВИД-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцөд нийт <b>4,04 тэрбум</b> төгрөгийн үнэ бүхий эм, эмнэлгийн хэрэгслийг НҮБХС, Японы ЗГ, АНУ-ын ОУ-ын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр бүрдүүлсэн. Үүнд:<br>- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан-1,8 тэрбум төгрөг<br>- Япон Улсын Засгийн газар-1,9 тэрбум төгрөг<br>- АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн буцалтгүй тусламж - 174,7 сая төгрөг<br>Эдгээр эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийн нөөцийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/03, А/04, А/08, А/185, А/211 тушаалуудаар эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгосон байна.   | 100            |
| 5.  | ЗГҮАХ 1.1.3.2<br>МУХТЖҮЧ 2.2.1<br>МУХТ 1.1.3<br>ЭМССТ 1.17<br>Шаардлагатай аймгуудад ЗӨСТ, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулах  | 15,000.0        | Байгуулсан ЗӨСТ болон хилийн боомтын тандалтын нэгжийн тоо | 3 аймагт ЗӨСТ, хилийн 12 боомтод тандалтын нэгж байгуулах тооцоо судалгаа хийгдсэн.  | 3 аймагт ЗӨСТ, хил 10 боомтод тандалтын нэгж байгуулсан байна.                                 | НЭМГ-ХӨХ      | Уг ажлын хүрээнд 4 аймагт шинээр ЗӨСТ байгуулах, 5 аймгийн ЗӨСТ-ийн барилгыг шинээр баруулах, 12 хилийн боомтод тандалтын нэгж байгуулах тооцоо судалгааг хийсэн. Зоонозын өвчин судлалын төв хоёрыг байгуулахад 550.0 сая төгрөг, тандалтын 1 нэгж байгуулахад 1.2 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоог хийсэн. Тооцоолол үндэслэл, эдийн засаг хөрөнгө оруулалтын тооцоолол, төсвийн хүрээний мэдэгдлийг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. АХБ-ны санхүүжилттэй “Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах эрүүл мэндийн тогтолцооны чадавхийг бэхжүүлэх” буцалтгүй тусламжийн МОН-9218 төслийн хүрээнд “Хилийн боомтуудад тандалтын нэгж байгуулах” шаардлагатай 5 багц тоног төхөөрөмжийн тендерийг зарлаж, 4 багцад гэрээ байгуулагдаж, нийт 411,8 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. 1 багцын гэрээ байгуулагдах шатандаа явж байна. | 0              |
| 6.  | ЗГҮАХ 1.1.3.3<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах   | 100.0           | Мэдээлэл, сургалт, сурталчилгаа-ны тоо                     | Халдварт өвчнөөс сэргийлэх чиглэлээр 460 инфографик, 35 хөдөлгөөнт шторк, 40 цуврал контент, 260 текстэн зөвлөгөө бэлтгэн Эрүүл мэндийн яамны фэйсбүүк | Төлөвлөгөөт сургалт сурталчилгаа бүрэн хийгдсэн байна.   | НЭМГ-ХӨХ      | “Шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчний мэдээлэл, сурталчилгааны ажлын 2023 оны нэгдсэн төлөвлөгөөгөө”-г Эрүүл мэндийн дэд сайдаар 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2023 оны 11 дүгээр сард томуу, томуу төст өвчин, галзуу, хумхаа, менингит, газар хөдлөлт, дархлаажуулалт бүхий халдварт өвчин, угаарын хийн хордлого, агаарын бохирдлын чиглэлээр МСС хийхээр төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжүүлж байна. Галзуу өвчинтэй тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд 14 төрлийн постер, 3 видео шторк, бэтэг өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 төрөл, салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1 төрлийн постер, томуу, томуу төст өвчний   | 100            |



| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж                             | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                                       | Суурь түвшин  | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж                    | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|--|---|--|----------------------------------|--|----------------|
|     |   |                 |  | хуудсанд байршуулан давхардсан тоогоор 100 сая иргэдэд мэдээлэл хүргэсэн.     |  |                                  | чиглэлээр 4 төрлийн постер бэлтгэн олон нийтийн сүлжээнд байршуулжээ. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/243 дугаар тушаалаар Үер, усны аюул, осол гэмтэл, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудад үүрэг, даалгавар өгөгдсөн. 2023 оны 06-08 дугаар сард гэдэсний халдварт өвчин, зоонозын өвчин болох тарваган тахал, боом, галзуу, хумхаа, менингит, томуу, томуу төст өвчин, дархлаажуулалт бүхий халдварт өвчний чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны ажлыг хэрэгжүүлсэн.Халдварт өвчний нөхцөл байдал цаг үеийн асуудлаар мэдээлэл постер цахим орчинд байршуулж, 5,068 хүнд хүрчээ. Эрүүл мэндийн яам, ОБЕГ, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, өрх, сумын эрүүл мэндийн төв, хэвлэл мэдээллийн байгууллагуудад цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой 81 төрлийн инфографик, постерыг хүргүүлж, хамтран ажиллаж байна. |                |
| 7.  | ЗГҮАХ 1.1.3.5 МУХТЖҮЧ 2.2.1 ЭМССТ 1.3 Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна.                                 | 500.0           | Засгийн газрын хуралдааны шийдвэр                      | -   | Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулагдаж үйл ажиллагаа жигдэрсэн байна. | НЭМГ                             | Нийгмийн эрүүл мэндийн тухай анхдагч хуулийн төсөлтэй холбогдуулан Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулах талаар үндэслэл тооцооллыг дахин боловсруулах зорилгоор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад нөхцөл байдлын дүн шинжилгээ хийв. Дүн шинжилгээгээр орон нутгийн эрүүл мэндийн газар, нийгмийн эрүүл мэндийн төв, дүүргийн эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг дахин нягталж үндэсний түвшинд Өвчний хяналт сэргийлэлтийн төв, аймаг, дүүргийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах бүтэц, зохион байгуулалтын бодлогын хувилбарууд боловсруулсан. Бодлогын хувилбарыг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон  | 0              |
| 8.  | ЗГҮАХ 1.1.3.6 Шинэ коронавирусын халдварыг тодорхойлох оношлуурыг дотооддоо бүтээн туршиж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | -               | 2023 онд оношилгоонд ашигласан дотоодын оношлуурын тоо | 2022 оны байдлаар дотооддоо "SARS-CoV2 илрүүлэх" 3 төрлийн оношлуур бүтээсэн. | Оношлуурын бүрдлийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.                            | БТГ-СТХ                          | Коронавирусийн халдварыг тодорхойлох оношлуур бүтээх 3 баг тус тусдаа оношлуурыг бүтээж, 2 багийн бүтээгдэхүүнийг ХӨСҮТ, НЭМГ, интермэд эрүүл мэндийн байгууллагууд хэрэглээнд нэвтрүүлж, эмнэлгийн практикт туршсан. "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль"-ийн үйлчлэх хугацаа дууссантай холбоотой оношлуурын хэрэгцээ эмнэлгийн практикт багассан. Оношлуур бүтээгч ААН-үүд ТХААГ-ын "Ерөнхий гэрээ байгуулах журам"-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (цахим дэлгүүр)-д бүтээгдэхүүнээ байршуулан эрүүл мэндийн байгууллагууд өөрсдийн хэрэгцээ шаардлагын хүрээнд худалдан авалт хийж эмчилгээ оношилгоонд хэрэглэж байна.   | 100            |
| 9.  | ЗГҮАХ 1.1.4.1 Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл,                 | -               | Засгийн газрын тогтоол                                 | Засгийн газрын 2009 оны 335 дугаар тогтоол хүчин төгөлдөр байна.              | Шинэчилсэн жагсаалтын дагуу татвараас чөлөөлөгдөж, хариу арга                | БТГ-СУХ<br>ЭТҮГ-ЭТЧАБХ<br>АБЛШТХ | Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахад шаардлагатай эрүүл мэндийн салбарын нөөцийн жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны "Жагсаалт батлах тухай" А/211 дугаар тушаалаар батлуулсан.   | 70             |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж                                     | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                               | Суурь түвшин  | Зорилтот түвшин                                    | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|--|---|-----------------|--|---|--|---------------|--|----------------|
|  | тэдгээрийн түүхий эд, оношлуур, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын жагсаалтыг шинэчлэн боловсруулах. |                 |  |   | хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.         | НЭМГ-УЗХЗХ    | Жагсаалтаар Эрүүл мэндийн яамны түвшинд бүрдүүлэх (1 сарын) нөөц, Эрүүл мэндийн байгууллагуудын түвшинд бүрдүүлэх (3 сарын) нөөц гэсэн байдлаар гарган нөөц бүрдүүлэхэд шаардлагатай зардал 3,0 тэрбум төгрөг 2024 оны төсөвт батлагдсан.<br>Засгийн газрын 2009 оны “Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” 335 дугаар тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд дээрх жагсаалтад орсон 13 нэрийн эмнэлгийн хэрэгсэл, 5 нэрийн оношлуур, 12 нэрийн тоног төхөөрөмж, 4 нэрийн ариутгалын бодис гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөж байна.  |                |
| <b>ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>  |   |                 |  |   |  |               |  |                |
| 2.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. |   |                 |  |   |  |               |  |                |
| 10.  | МУХТЖҮЧ 2.2.2 Хүн амын зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах.              | -               | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүний амын хувь | Хүн амын 23.1 хувийг эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамруулсан. | Эрт илрүүлэг үзлэгт хүн амын 40 хувийг хамруулсан. | НЭМГ-ХБӨХ     | 2023 оны 12 сарын 07-ны өдрийн байдлаар эрт илрүүлэг үзлэгт улсын хэмжээнд 1.268.909 хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүн амын 37.7 хувийг эзэлж байна. Үзлэгт хамрагдсан нийт хүний 657,384 буюу 52.1 хувь нь 0-17 насны хүүхэд, 605,246 буюу 47.9 хувь нь 18-аас дээш насныхан байна.<br>1. 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоог эрчимжүүлэх чиглэлээр дэмжлэгт хяналт хийх” ажлын удирдамжийг батлуулан хэрэгжүүлсэн.<br>2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт эрт илрүүлэг, үзлэг шинжилгээ, оношилгоог эрчимжүүлж ажиллах тухай 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1а/1425 дугаар албан бичгийг хүргүүлсэн.<br>3. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн “Эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог эрчимжүүлэх тухай” А/256 дугаар тушаалыг батлуулан Аймаг, нийслэлийн Засаг дарга, ЭМГ-ын дарга нарт 16/3345 албан тоот хүргүүлэн 16 аймагт төрөлжсөн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтний бүрэлдэхүүнтэй явуулын баг ажиллаад нийт 10732 иргэнийг эрт илрүүлэгт хамруулсан.<br>4. Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн “Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай” А/273, А/314 дүгээр хамтарсан тушаалыг батлуулан Аймгийн Засаг дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, эрүүл мэндийн газрын дарга нарт 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 1а/3532 дугаар албан бичгээр хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>5. Эрүүл мэндийн сайдын 2022 оны урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдах тухай А/139 дүгээр тушаалыг шинэчлэн боловсруулаад 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн “Журам батлах тухай” А/379 дүгээр тушаалаар батлуулсан.<br>6. Улаан хоолой, ходоодны уян дурангийн аппаратыг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 28- | 90             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                                  | Суурь түвшин  | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|---|---|---|---------------|---|----------------|
|     |   |                 |   |   |   |               | ны өдрийн “Эмнэлгийн тоног төхөөрөмжийг орлогоо авч, хувиарлах, үндсэн хөрөнгөд бүртгэх тухай” тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагын “Эрүүл мэндийг дэмжих төв”-үүдэд нийт 1,000,184,000.0 тэрбум төгрөгийн 28 ширхэг ходоодны уян дуранг хуваарьласан байна.   |                |
| 11. | ЗГҮАХ 2.1.1.1<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>ЭМССТ 1.4<br>“Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлэх.   | 500.0           | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь       | Арга хэмжээний хэрэгжилт 38.4 хувьд хүрсэн.         | Арга хэмжээний хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна.                       | НЭМГ-УСХЗХ    | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/780 дугаар тушаалаар “Эрүүл, идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан. Арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 77 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 51.0% хувьтай байна.  | 100            |
| 12. | ЗГҮАХ 2.1.1.2<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 1.3.1<br>ЭМССТ 1.14<br>“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх.   | 19,870.0        | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь       | 2022 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан. | Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.                       | НЭМГ-ХӨХ      | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар баталсан “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөөнд 2023 онд нийт 163 арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжилт 75.0% байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• 1-р Зорилт 74%,</li> <li>• 2-р Зорилт 79%,</li> <li>• 3-р Зорилт 86%,</li> <li>• 4-р Зорилт 91%,</li> <li>• 5-р Зорилт 76%,</li> <li>• 6-р Зорилт 49%,</li> <li>• 7-р Зорилт 60%,</li> <li>• 8-р Зорилт 88% хэрэгжилттэй байна.</li> </ul> Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар “Халдварт өвчний өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал”-ыг хэлэлцүүлж, гарсан шийдвэрт тусгагдсан нийт 7 заалтын дагуу хариу арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлийг 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 6/2360 тоот албан бичгээр холбогдох газруудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100            |
| 13. | ЗГҮАХ 2.1.1.3<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 1.3.1<br>ЭМССТ 1.8<br>“Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх.   | 3,000.0         | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь       | Арга хэмжээний хэрэгжилт 35.8 хувьд хүрсэн.         | Арга хэмжээний хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна.                       | НЭМГ-ХБӨХ     | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан. Арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2023 оны эхний 11 сарын байдлаар 56.5 хувьтай байна. Энэ нь 2023 оны зорилтот түвшинд хүрсэн байна.  | 100            |
| 14. | ЗГҮАХ 2.1.1.4<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 1.3.1<br>ЭМССТ 1.5<br>“Хавдрын эсрэг” арга хэмжээг эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах. | 700.0           | Хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамралтын хувь | 2021 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан. | Хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамралтыг 60 хувьд хүргэсэн байна. | НЭМГ-ХБӨХ     | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаалаар “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан. Арга хэмжээний төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 61 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар эрт илрүүлэг үзлэгт улсын хэмжээнд 1,262,630 хүн хамрагдсан байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдалт улсын хэмжээнд хүн амын 37.5 хувь байна. Энэ нь зорилтот түвшний 62.5 хувьд хүрсэн байна. ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар “Хавдрын эсрэг” арга  | 50             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                            | Суурь түвшин  | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|---|---|---|---------------|---|----------------|
|     |   |                 |   |   |   |               | хэмжээний төлөвлөгөөний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг хэлэлцэж, төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх шийдвэр гарсан байна.   |                |
| 15. | УИХ-ын 23 дугаар тогтоолын 2.2.1 ЗГҮАХ 2.1.1.5 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.15 “Элэг бүтэн Монгол” арга хэмжээ хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулах. | 10,000.0        | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2022 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан. | “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна. | ЭТҮГ-АЛШТХ    | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 дугаар тушаалаар батлагдсан “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. 2023 оны эхний хагас жилд арга хэмжээний хэрэгжилт 40 хувьтай байсан ба ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар “Элэг бүтэн Монгол” арга хэмжээний төлөвлөгөөний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг хэлэлцэж, төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх шийдвэр гарсан байна. Гэвч 2023 оны 12 сарын байдлаар арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 54.3 хувьтай байна. Энэ нь зорилтот түвшний 77.5 хувьд хүрсэн байна.  | 70             |
| 16. | ЗГҮАХ 2.1.1.6 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.6 “Харшлаас сэргийлэх” арга хэмжээг хэрэгжүүлэх.   | 200.0           | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээний хэрэгжилт 50.3 хувьд хүрсэн.         | Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.                     | НЭМГ-ХБӨХ     | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 45 хувьтай. Төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Тухайлбал:<br>– “Харшлын өвчний оношилгоо, эмчилгээг сайжруулахад чиглэсэн бодлого, эрхзүйн орчин бүрдүүлж сайжруулах Харшлын арьсан дотор тарих сорил”-ын аргачлалын стандартыг эрдэмтдийн зөвлөлийн 2023.03.24-ий өдрийн хурлын тэмдэглэл, арьсан дотор тарих сорил, аргачлалын стандартын төслийг хэлэлцүүлж батлуулахаар ЭТҮГ-д, Чонон хөрвөс болон хавьтал харшлын дерматитын эмнэл зүйн зааврыг боловсруулж Арьсны өвчин судлалын үндэсний төвийн эрдэмтдийн зөвлөл, ЭМЯ-ны дэргэдэх арьс судлалын салбар зөвлөлөөр хэлэлцүүлсэн.<br>– Эмнэлзүйн заавар батлуулах журам батлах тухай ЭМС-ын 2022 оны 09 сарын 09 өдрийн А/457 тушаалын хоёрдугаар хавсралтад заасан загварын дагуу арьс, харшлын өвчний оношилгоо эмчилгээний эмнэл зүйн зааврын шинэчлэн боловсруулж батлуулсан.<br>– Харшлын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулж, хүн амын мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд орон нутгийн 11 аймгийн 26 хүний бүрэлдэхүүнтэй хамтарсан ажлын хэсэг байгуулж орон нутгийн харшил төрүүлэгч ургамлын шинжилгээг хийж, агаар дахь тоосжилтын хуанлийг шинэчилж, өдөр тутмын цаг уурын мэдээнд оруулж, 04 сараас 09 саруудад <a href="http://www.aqaar.mn">www.aqaar.mn</a> сайтад байршуулсан. | 70             |
| 17. | ЗГҮАХ 2.1.1.7 МУХТЖҮЧ 2.2.2 ЭМССТ 1.7 “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлэх.   | 500.0           | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээний хэрэгжилт 35.8 хувьд хүрсэн.         | Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.                     | НЭМГ-ХБӨХ     | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаалаар “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан. Арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 46 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ 2023 оны 12 сарын байдлаар 50.6 хувьтай байна. Энэ нь зорилтот түвшний 72.3 хувьд хүрсэн байна.   | 70             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт           | Суурь түвшин   | Зорилтот түвшин   | Хариуца х нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|----------------------------|--|---|----------------|--|----------------|
| 18. | ЭМССТ 1.11<br>“Орчны эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлэх.                            | -               | -                          | Арга хэмжээний хэрэгжилт 30.0 хувьд хүрсэн.                    | Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна.                               | НЭМГ-УСХЗХ     | “Орчны эрүүл мэнд” хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/349 дүгээр тушаалаар батлан, 2021-2024 онд нийт 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан. 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Биелэлт ирүүлэх тухай 6/1630 албан тоотыг аймаг нийслэлийн эрүүл мэндийн газарт салбар хоорондын байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажилласан. 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдөр уг арга хэмжээний хэрэгжилтийн явцыг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах шийдвэр гарсны дагуу Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 5/3974 албан тоотоор уг хурлын шийдвэрийг хүргүүлсэн. 2023 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 60%-тай байна.   | 70             |
| 19. | ЭМССТ 1.12<br>Хүн амын хоол тэжээлийн VI судалгаа үндэсний түвшинд зохион байгуулах.  | -               | Судалгааны ажлын тайлан    | 2017 онд хүн амын хоол тэжээлийн үндэсний судалгаа хийгдсэн. V | Хүн амын хоол тэжээлийн VI судалгааг зохион байгуулж, үр дүнг гаргасан байна. | НЭМГ-УСХЗХ     | “Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн байдал” үндэсний VI судалгаанд “хүнсний баталгаат бус байдал”, “хоол тэжээлийн хомсдол”-ын тархалтыг судлах үзүүлэлт нэмэгдсэний улмаас судалгааны аргачлалыг дахин боловсруулж, НЭМҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хэлэлцүүлж батлуулсан. Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж судалгааг 2023-2024 онд багтаан хийж гүйцэтгэхийг зөвшөөрсөн. Хоол тэжээлийн VI судалгаанд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн 4 бүс (21 аймаг)-ийн 112 сум, Улаанбаатар хотын 8 дүүргийн 40 хорооны нийт 16064 хүнийг хамруулахаар төлөвлөсөн. Судалгааны багт дата мэдээлэл цуглуулж ажиллах судлаачдыг бэлтгэх 5 хоногийн сургалтыг 2023 оны 9 дүгээр сарын 11-15-ны өдрүүдэд зохион байгуулж, Улаанбаатар хотын 8 дүүрэг, орон нутгийн 4 бүсэд нийт 12 судалгааны багт 60 судлаачдыг томилон ажиллуулсан. Судалгааны багт дэмжлэг үзүүлэх тухай 6/4017 дугаар албан бичгийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн. Судалгааны дата мэдээлэл цуглуулах ажил Улаанбаатар хотод 2023 оны 09 дүгээр сарын 25-наас, орон нутагт 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 10 хүртэл явагдсан. НЭМҮТ, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 2023 оны 10 дугаар сарын 30-наас 11 дүгээр сарын 05-ны өдрүүдэд орон нутагт явагдаж буй судалгааны мэдээлэл цуглуулах ажлын явцад хяналт тавьж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Судалгааны мэдээллийн баазыг “EpiData 3.0” програмд үүсгэж НЭМҮТ 7 төрлийн асуулгын шивэлтийг хийж мэдээлэл тайлан боловсруулж байна. | 30             |
| 20. | ЗГҮАХ 2.1.2.2<br>Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна.                            | 3,000.0         | Эмчилгээнд хамрагдсан хувь | -  | Эмчилгээнд хамрагдах хувийг 40 хувьд хүргэсэн байна.                          | ЭТҮГ-АЛШТХ     | - “Элэгний В, Д вирустэй тэмцэгчид” ТББ-тай хамтран элэгний Дельта вирустэй хүмүүсийн үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж, 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 1,000 гаруй иргэдийг оролцуулав. Тус үндэсний зөвлөлдөх уулзалтаар Дельта вирусын эмчилгээг нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудлыг хэлэлцсэн. Уг зөвлөлдөх уулзалтын зөвлөмжийн дагуу, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/99 дугаар тушаалаар “Гепатитын Дельта вирусийн   | 0              |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт      | Суурь түвшин       | Зорилтот түвшин                                 | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|-----------------------|--------------------|---|---------------|--|----------------|
|     |   |                 |                       |                    |   |               | <p>оношилгоо, эмчилгээ, хяналт хийхэд тулгамдаж буй асуудлыг судалж шийдвэрлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн"-ийг баталсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>– Эрүүл мэндийн сайдын 2023 оны 10 дугаар сарын “Гепатитын В, Д вирусийн халдвартай иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай” А/363, А/362 дугаар тушаалаар ХӨСҮТ, ЭМДЕГ, ЭЭХХЗГ, НЭМҮТ, Аймаг нийслэлийн ЭМГ-т гепатитын В, Д вирусийн халдварыг илрүүлэх, оношилгооны чадавхыг нэмэгдүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, оношилгоо, эмчилгээний зааврыг шинэчлэн батлуулах, гепатитын В, Д вирусийн халдвартай иргэдийн хөнгөлөлттэй эм, вирусийн эсрэг эмчилгээний асуудлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг үүрэг болгосон. Түүнчлэн Монгол Улсын иргэдийг гепатитын Д вирусийн эсрэг эмчилгээнд ОХУ-д очиж хамрагдах, Мерклюдекс эмийг худалдан авах нөхцөлийг судлах зорилгоор ОХУ-аас Монгол Улсад суугаа ОББЭЭС Евсиковтой уулзалж судалж байна.</li> <li>– Гепатитын Дельта вирусийг эмчлэх HepTulex эмийг үйлдвэрлэгч АНУ-ын Gilead Science компанийн Азийг хариуцсан захирал 2023 оны 10 дугаар сард Эрүүл мэндийн сайдтай уулзах үедээ 30 сарын тун бүхий “Hepcludex® (Bulevirtide) эмийг хүлээлгэн өгсөн, цаашид хамгийн хямд, боломжит үнээр нийлүүлэх тухай мэдэгдсэн.</li> <li>– HepTulex эмийг 11 дүгээр сард Монгол улсын Өнчин эмийн жагсаалтад бүртгэсэн. HepTulex эмийг “Гепатитын В, С, Д вирусийн халдварын илрүүлэг, тандалт, оношилгоо, эмчилгээний” шинэчлэн боловсруулсан зааварт тусгасан, энэхүү заавар ЭМЯ-ны газрын дарга нараас санал авах шатандаа явж байна.</li> <li>– Гепатитын В вирусийн халдвартай иргэдийг ПЭГ-Интерферон эмчилгээнд хамруулах, эмийг худалдан авах үйл ажиллагаа ХӨСҮТ-с зохион байгуулж байна. Тус эмчилгээнд 900 гаруй хүн хамрагдаж 100% хувийн төлбөрийн хөнгөлөлт эдэлнэ, 48 долоо хоногийн турш эмч нарын хяналт дор эмчилгээ хийлгэнэ.</li> </ul> |                |
| 21. | ЗГҮАХ 2.1.3.1 Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулна.                                 | -               | Батлагдсан санхүүжилт | Санхүүжилт байхгүй | Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлсэн байна | СЭЗГ-ХОХ      | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын Эрүүл мэндийн сайдын багцын хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/” төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь 140.0 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 42.0 тэрбум төгрөгөөр батлагдсан.   | 100            |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт           | Суурь түвшин       | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|----------------------------|--------------------|---|---------------|---|----------------|
| 22. | ЗГҮАХ 2.1.3.2<br>Зүрх судасны төв байгуулна.  |                 | Батлагдсан санхүүжилт      | Санхүүжилт байхгүй | Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, гэрээ байгуулсан байна.  | СЭЗГ-ХОХ      | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хоёрдугаар хавсралтын Эрүүл мэндийн сайдын багцын хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад “Зүрх, судасны үндэсний төвийн барилгын гадна инженерийн шугам, сүлжээ /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 5 дугаар хороо/” төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь 2.3 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 1.1 тэрбум төгрөгөөр батлагдсан.  | 100            |
| 23. | ЗГҮАХ 2.1.3.3<br>Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна.                        |                 | Барилгын гүйцэтгэлийн хувь | -                  | Худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. | СЭЗГ-ХОХ      | ТХААГ-аас ХАА-г зохион байгуулж, “Хар Чонот” ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж ирүүлсэн. Тус компани нь Сангийн сайдын 2021 оны тушаалаар “Хар жагсаалт” буюу тендэрт оролцох эрхгүй ААНБ-ын жагсаалтад орсон тул гэрээ байгуулах боломжгүй тухай албан бичгийг ТХААГ-т хүргүүлсэн. ХАА-г дахин зарласан боловч “Хар Чонот” ХХК шүүхэд гомдол гарган 3 шатны шүүхээр захиалагч Эрүүл мэндийн яамны талд шийдвэрлэгдсэн. ТХААГ-аас ХАА-г дахин зохион байгуулахаар ажиллаж байна. Мөн “Халдварт өвчин судлалын үндэсний төв-2”-ийн төлөвлөлтөд 60 ортой Сүрьеэгийн тасаг байгуулахаар төлөвлөсөн бөгөөд Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд “Халдварт өвчин судлалын үндэсний төв-2”-ийн гадна инженерийн шугам, сүлжээ /Төв, Сэргэлэн сум/ байгуулахаар төсөвт өртөг нь 13.3 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 4.0 тэрбум төгрөгөөр батлагдсан | 0              |
| 24. | ЗГҮАХ 2.1.3.4<br>Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.     | 5,600.0         | Барилгын гүйцэтгэлийн хувь | -                  | Эмнэлэг ашиглалтад орсон байна.   | СЭЗГ-ХОХ      | Барилга угсралтын ажлын зураг төсөл, төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нь нэмэгдсэн. Төсөвт өртгийн нэмэгдлийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2022, 2023 оны төсвийн тухай хуульд тусгуулахаар Улсын Их Хурал, Сангийн яаманд хүргүүлсэн боловч хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй. Иймд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа “Сэргээн засах төвийн барилга, 36 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/-ын ажлыг дуусган Геронтологийн төв болгон ашиглахаар төлөвлөж байна. Тус ажлын гүйцэтгэл 90 хувьтай бөгөөд 2023 оны 12 дугаар сард багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.   | 70             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт           | Суурь түвшин | Зорилтот түвшин                     | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|----------------------------|--------------|-------------------------------------|---------------|---|----------------|
| 25. | ЗГҮАХ 2.1.3.5 Түлэнхийн төвийн барилгыг ашиглалтад оруулна.                           | -               | Барилгын гүйцэтгэлийн хувь | -            | Барилгыг ашиглалтад оруулсан байна. | СЭЗГ-ХОХ      | Түлэнхийн төвийн А блокын барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр ажиллаж, үйл ажиллагааг нь 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр эхлүүлсэн.<br>Б блокын барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр ажиллаж, 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Кувейтын сантай хамтран албан ёсны нээлт хийж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн.   | 100            |
| 26. | ЗГҮАХ 2.1.3.6 Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна.  | -               | Батлагдсан ТЭЗҮ            | -            | Зураг төсөв, ТЭЗҮ хийгдсэн байна.   | СЭЗГ-ХОХ      | Ажлын зураг төсөл, төсөв нь Барилгын хөгжлийн төвийн "Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлтийн нэгтгэл"-ээр баталгаажиж, 277.0 тэрбум төгрөг шаардлагатай гэсэн тооцоолол гарсан. Төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд тусгуулахаар Эрүүл мэндийн сайдын 2023 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 1а/3709, 1а/3710 дугаартай албан бичгээр Улсын Их Хурал, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 1а/3785 дугаартай албан бичгээр Аудитын Ерөнхий газарт хүргүүлсэн. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Халдварт өвчин судлалын үндэсний төв-2"-ийн гадна инженерийн шугам, сүлжээ /Төв, Сэргэлэн сум/ байгуулахаар төсөвт өртөг нь 13.3 тэрбум төгрөг, санхүүжих дүн нь 4.0 тэрбум төгрөгөөр батлагдсан. | 100            |



| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                 | Суурь түвшин   | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|----------------------------------|--|---|---------------|---|----------------|
| 27. | ЗГҮАХ 2.1.3.7<br>Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна.   | -               | Батлагдсан ТЭЗҮ                  | -  | Зураг төсөв, ТЭЗҮ хийгдсэн байна.   | СЭЗГ-ХОХ      | Барилгын ажлын зураг төсөл, төсвийг боловсруулахад шаардлагатай хөрөнгийг Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Барилга, хот байгуулалтын сайдын багцад батлагдсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/" төсөл, арга хэмжээнээс шийдвэрлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчээр "Хот Төлөвлөлтийн Хүрээлэн" ХХК шалгаран 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 996.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан.<br>Барилга, хот байгуулалтын яам болон Эрүүл мэндийн яам хамтран 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдөр баталсан шинээр барих "Хавдар судлалын үндэсний төвийн салбар эмнэлэг 2"-ын барилгын зураг төслийн даалгаврын дагуу гүйцэтгэгч нь загвар зургийг боловсруулан батлуулсан.<br>Гэвч Барилга, хот байгуулалтын яам, Эрүүл мэндийн яам, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч "Барилгын хөгжлийн төв" ТӨААТҮГ, гүйцэтгэгч "Хот Төлөвлөлтийн Хүрээлэн" ХХК хамтран гэрээний хэрэгжилтийг дүгнэсний үндсэн дээр гэрээг цуцлахаар тогтоод байна. | 30             |
| 28. | ЗГҮАХ 2.1.3.8<br>Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барьна.   | -               | Батлагдсан ТЭЗҮ                  | -  | Зураг төсөв ТЭЗҮ хийгдсэн байна.  | СЭЗГ-ХОХ      | Газрын асуудыг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Засаг даргад 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 2/4900 дугаартай албан бичиг хүргүүлэн "Нийслэлийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-нд тусгуулсан. Үр дүнд нь газрын асуудал шийдвэрлэгдэн Баянзүрх дүүргийн 34 дүгээр хороонд газар чөлөөлөлт хийсэн. Ажлын зураг төслийн гүйцэтгэгчээр "Татах Хүч" ХХК шалгаран гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 70 хувьтай.   | 30             |
| 29. | ЗГҮАХ 2.1.12.1<br>ЗГҮАХ 2.1.12.3<br>ЗГҮАХ 2.1.12.4<br>Эрүүл мэндийн салбарын шилжих 86 төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд барилга угсралтын ажлыг үргэлжлүүлнэ. /2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XV.1.1-XV.1.86/ | 146,692.9       | Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь | Барилга угсралтын ажил эхлээгүй 6 төсөл, арга хэмжээ, 20-25% гүйцэтгэлтэй 22 барилга, 30-89% гүйцэтгэлтэй 30 барилга, 90-100% гүйцэтгэлтэй 28 барилга байна. | Батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлж, барилга угсралтын ажлыг ашиглалтад оруулсан байна | СЭЗГ-ХОХ      | Эрүүл мэндийн салбарын Барилга байгууламжийн шилжих 86 төсөл, арга хэмжээний 146.7 тэрбум төгрөгөөс 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 101.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгоод байна. Тайлант оны эцэст 2023 онд санхүүжих 146.7 тэрбум төгрөгийг бүрэн олгохоор төлөвлөн ажиллаж байна. /Эрүүл мэндийн сайдын багцаас эрх шилжээгүй 61 төсөл, арга хэмжээний 119.2 тэрбум төгрөгөөс 82.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгосон./<br>Үүнээс 33 төсөл, арга хэмжээ ашиглалтад орсон, 11 төсөл, арга хэмжээ улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хангаж байгаа бөгөөд барилга угсралтын ажил 90%-аас дээш, 21 төсөл, арга хэмжээ барилга угсралтын ажил 70-89%-тай, 14 төсөл, арга хэмжээ барилга угсралтын ажил 40-69%-тай, 6 төсөл, арга хэмжээ барилга угсралтын ажил 20-39%-тай, 1 төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагаа хийгдэж байна.   | 70             |
| 30. | ЗГҮАХ 2.1.12.1<br>ЗГҮАХ 2.1.12.3<br>ЗГҮАХ 2.1.12.4<br>Эрүүл мэндийн салбарын шилжих 6 их  | 13,460.7        | Их засварын гүйцэтгэлийн хувь    | Засварын ажлын явц 60%тай байна.   | Засварын ажил дуусч хүлээн авсан байна.   | СЭЗГ-ХОХ      | Эрүүл мэндийн салбарын Барилгын их засварын шилжих 6 төсөл, арга хэмжээний 10.08 тэрбум төгрөгөөс 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 9.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгоод байна. Тайлант оны эцэст 2023 онд санхүүжих 279.3 сая төгрөгийг бүрэн олгоно.   | 90             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин  | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|---|---|--|---------------|--|----------------|
|     | засварын төсөл, арга хэмжээг гүйцэтгэнэ. /2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XV.2.1-XV.2.6/   |                 |   |   |  |               | <ul style="list-style-type: none"> <li>- 100 хувийн гүйцэтгэлтэй 5 их засвар, (Хэнтий аймгийн НЭ-ийн төрөх тасаг, Завхан аймгийн Тосонцэнгэлийн НЭ-ийн шугам сүлжээ, Булган аймгийн Гурванбулаг, Хишиг-Өндөр, Рашаант СЭМТ-ийн барилга, Сэлэнгэ аймгийн НЭ-барилга, сантехникийн засвар)</li> <li>- Эх хүүхдийн эрүүл мэндийн төвийн барилгын их засвар 8 багцад хуваагдсаг бөгөөд 6 багц ажил 2022 онд гэрээ байгуулагдан он дамжин хэрэгжиж байна. Үлдсэн 7, 8 дугаар багцийн худалдан авах ажиллагааг 2023 оны 03 дугаар сараас зохион байгуулсан.</li> <li>Багц-7-ын төсөл арга хэмжээний гүйцэтгэл 90 хувь,</li> <li>Багц-8 -ын төсөл арга хэмжээний гүйцэтгэл 25 хувь</li> </ul> |                |
| 31. | ЗГҮАХ 2.1.12.1<br>ЗГҮАХ 2.1.12.3<br>ЗГҮАХ 2.1.12.4<br>Эрүүл мэндийн салбарын шилжих 14 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд үлдэгдэл санхүүжилтийг олгоно. /2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XV.3.1-XV.3.14/ | 11.965.1        | Тоног төхөөрөмжийн хангалтын гүйцэтгэлийн хувь                                  | 14 төсөл арга, хэмжээний гүйцэтгэл 50%-тай байна.           | Тоног төхөөрөмжийн хангалт 100%-ийн гүйцэтгэлтэй байна.                    | СЭЗГ-ХОХ      | Эрүүл мэндийн салбарын шилжих 14 тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хэрэгжсэн ба XV.3.2 Дүүргийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 234,5 сая төгрөгийг 2024 онд олгогдоно. Төсөвт үлдэгдэл санхүүжилт тусгагдсан.  | 100            |
| 32. | ЗГҮАХ 2.1.4.1<br>МУТЖҮЧ-2.2.4<br>Орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулна.   | 5,000.0         | Яаралтай тусламжийн цэгийн тоо  | 2022 оны байдлаар яаралтай тусламжийн 10 цэгийг байгуулсан. | Орон нутагт шаардлагатай 25 цэгт яаралтай тусламжийн цэг байгуулсан байна. | ЭТҮГ-АЛШТХ    | Эрүүл мэндийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/164 дугаар тушаалаар орон нутагт яаралтай тусламжийн цэг байгуулахад нэн шаардлагатай 1,549,8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Архангай, Баян-Өлгий, Булган, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Ховд аймгуудад хуваарилсан. Орон нутгийн яаралтай тусламжийн цэгийн тоог нэмэгдүүлэх, тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор түргэн тусламжийн авто машиныг 14 аймгийн сумын эрүүл мэндийн төвүүдэд худалдан авах төсвийг ЭМС-ын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/403, 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/396 дугаар тушаалаар баталсан.   | 30             |
| 33. | ЗГҮАХ 2.1.4.2<br>Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхийг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана.   | 8,100.0         | Яаралтай тусламжийн хүний нөөцийн болон тоног төхөөрөмжийн чадавхийг бэхжүүлсэн | -   | Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн     | СЭЗГ-ХОХ      | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/615 дугаар тушаалаар "Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-г баталсан. 2023 оны төсөвт эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж (улсын хэмжээнд)-д нийт төсөвт өртөг нь 4.0 тэрбум төгрөгөөр яаралтай тусламжийн тоног төхөөрөмж болох хүчилтөрөгчийн аппаратыг нийлүүлэх гэрээг 2023 оны 06   | 70             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                                    | Суурь түвшин | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|---|--------------|---|---------------|---|----------------|
|     |   |                 | лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын тоо |              | чадавхи бэхжсэн байна.  |               | дугаар сарын 15-ны өдөр байгуулсан. 2023 онд нийт 910.8 сая төгрөгийн өртөгтэй аппаратыг Баянзүрх дүүргийн 50 ортой нэгдсэн эмнэлэг, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Энэрэл эмнэлэг, Өвөрхангай аймаг дахь БОЭТ, Төв аймгийн Эрдэнэ сум, Сүхбаатар аймгийн Асгат, Дарьганга, Мөнххаан, Эрдэнэцагаан сум зэрэг 9 эрүүл мэндийн байгууллагад 2023 онд багтаан олгох юм. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2023-09-12 №060/2023 дугаар техникийн комиссын урьдчилсан дүгнэлт гарч, энэхүү дүгнэлтийг үндэслэн аппаратыг хүлээн авах комисс ажиллаж байна. 2022-2023 оны үндсэн мэргэшлийн сургалтад Яаралтай тусламж судлалаар 19 их эмч суралцаж байгаагаас 8 их эмч улсын төсвийн санхүүжилтээр захиалгаар сурч байна. 2023-2024 оны үндсэн мэргэшлийн сургалтад Яаралтай тусламж судлалаар 23 их эмч элссэнээс 12 их эмч улсын төсвийн санхүүжилтээр захиалгаар сурч байна. |                |
| 34  | Гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр эрүүл мэндийн байгууллагуудыг орчин үеийн оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангах |                 | Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо        |              | Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан байна. | ТЗУГ-ГХХ      | 2023 оны жилийн эцсийн байдлаар гадаадын буцалтгүй тусламжийн хүрээнд <b>14,4 тэрбум төгрөгийн</b> үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, эрүүл мэндийн байгууллагуудыг хангав. Үүнд:<br>– Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан- 5.9 тэрбум төгрөг<br>– Япон Улсын Засгийн газар – 8.5 тэрбум төгрөг   | 100            |
| 35. | ЗГҮАХ 2.1.4.4 Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ.   | 8,500.0         | Шинээр олгосон түргэн тусламжийн автомашины тоо     | -            | 150 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгосон байна.     | СЭЗГ-ХОХ      | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/615 дугаар тушаалаар “Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан. 150 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгох хүрээнд 90 (60.0%) байгууллагад автомашин олгох санхүүжилт шийдэгдэж, худалдан авалт зохион байгуулагдаж байна. Одоогоор нийт ханган нийлүүлэгдэх ёстой 150 машины 82 хувь (123)-д санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдэж, худалдан авалтын ажиллагаа хийгдэж байна. 2023 оны эхний 11 сарын байдлаар 57 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгож, нийт 150 эрүүл мэндийн мэндийн байгууллагын 38.0 хувийг хангажээ.   | 70             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж                                       | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин                                       | Хариуца х нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|---|--|---|----------------|---|----------------|
| 36. | ЗГҮАХ 2.1.5.2 МУХТЖҮЧ 2.2.1 Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлотыг шинэчлэн батлуулах. | -               | Засгийн газрын тогтоол  | -  | Төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.      | НЭМГ-ХӨХ       | Шинэ вакцины хөгжүүлэлт, хүн амын өвчлөлийн нөхцөл байдалтай уялдуулан дархлаажуулалтын товлотд шинэ вакцин нэвтрүүлэх практик шаардлага гарч, Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталсан. Энэхүү хуулийн нэмэлтээр А вируст гепатит, пневмококкийн халдвар, хүний папиллома вирусийн эсрэг вакцинжуулалтыг заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлотд шинээр нэмсэн. Ингэснээр умайн хүзүүний хорт хавдраас сэргийлж, хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулах ач холбогдолтой юм. Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлотыг Засгийн газрын тогтоолоор шинэчлэн батлуулахаар тогтоолын төслийг боловсруулж, яамдуудаас санал авахаар 2023.11.28-ны 1а/5351 дугаар албан бичгийг хүргүүлсэн байна.  | 70             |
| 37. | ЗГҮАХ 2.1.5.2 ЭМССТ 1.19 Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах.   | -               | УИХ-аар хэлэлцүүлсэн хууль  | Үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. | Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлсэн байна.           | НЭМГ-ХӨХ       | Дархлаажуулалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д "Пневмококк, А вируст гепатит, Хүний папиллома вирусийн халдвар"-ын эсрэг вакцин нэмэлтээр оруулах асуудлыг Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр дэмжигдсэн ба Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталсан. Энэхүү хуулийн нэмэлтээр А вируст гепатит, пневмококкийн халдвар, хүний папиллома вирусийн эсрэг вакцинжуулалтыг заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлотд шинээр нэмсэн. Ингэснээр умайн хүзүүний хорт хавдраас сэргийлж, хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулах ач холбогдолтой юм. | 100            |
| 38. | МУХТЖҮЧ-2.2.1 ЭМССТ 1.20 Товлолт дархлаажуулалтад хүний папиллома вирусийн эсрэг вакцин нэвтрүүлэх.                         | -               | Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан 11 насны хүүхдийн эзлэх хувь | -  | Зорилтот бүлгийн хүн амын 75 хувийг хамруулсан байна. | НЭМГ-ХӨХ       | Шинэ вакцины хөгжүүлэлт, хүн амын өвчлөлийн нөхцөл байдалтай уялдуулан дархлаажуулалтын товлотд шинэ вакцин нэвтрүүлэх практик шаардлага гарч, Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталсан. Энэхүү хуулийн нэмэлтээр хүний папиллома вирусийн эсрэг вакцинжуулалтыг заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлотд шинээр нэмсэн. Ингэснээр умайн хүзүүний хорт хавдраас сэргийлж, хүн амын өвчлөл, нас баралтыг бууруулах ач холбогдолтой юм.<br>11 насны 70,000 хүүхдийг вакцинд хамруулахаар 90,000 Хүний папиллома вирусийн эсрэг вакциныг НҮБ-ын Хүүхдийн санд захиалсан.<br>Хүний папиллома вирусийн эсрэг вакциныг 2023 онд сайн дурын үндсэн дээр хийхээр 10,000 хүн тун вакциныг захиалан, хүлээн авч, эхний 11 сарын байдлаар 1045 хүн -вакцинд сайн дураар хамруулсан байна.                       | 30             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин  | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|--|-----------------|---|---|---|---------------|---|----------------|
| 39. | ЗГҮАХ 2.1.5.3<br>Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. | 3,000.0         | Мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт, судалгааны ажлын нэгдсэн тайлан | 47 ТББ, 26 төрийн байгууллагад 2,7 тэрбум төгрөгийн төсөл хөтөлбөрийг дэмжиж хамтран ажилласан. | Зохион байгуулсан тайлан  | НЭМГ-УСХЗХ    | Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангах, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, соён гэгээрүүлэх, ухуулга нөлөөллийн ажил, сургалт, сурталчилгааг явуулах, шаардлагатай санхүүжилт, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх нь хэрэгжилтийг зохион байгуулахад ихээхэн хувь нэмэртэй юм. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 30-нд баталсан “Зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлэх, иргэдэд эрүүл идэвхтэй амьдрах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах” ажлын удирдамжийг дараах 6 сэдвийн хүрээнд жилийн турш хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Жилийн ажлын эхний аяныг “Эрүүл жиндээ энэ жилдээ” уриатай 2023 оны 03 дугаар сараас эхлүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. 2023 оны 05 дугаар сард Амны хөндийн эрүүл мэндийн аяныг зохион байгуулсан. 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн “Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд” цахим аянг эхлүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 21 аймгийн нийт 300 гаруй эрүүл мэндийн байгууллагын цахим хуудсаар сэтгэцийн эрүүл мэндийн постер, видео, онлайн зэрэг 20 сэтгэцийн эрүүл мэндийн сэдвийн хүрээнд бэлтгэн г түгээж байна. Архи тамхины хэрэглээ, мансууруулах бодис, цахим мөрийтэй тоглоом, сэтгэл гутрал, стресс зэрэг сэдвээр сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна.  | 100            |
| 40. | ЗГҮАХ 2.1.5.4<br>Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулах.  | -               | УИХ-аар батлагдсан хууль, Шинээр батлагдсан дүрэм, журмын тоо                               | Хуулийн төслийг боловсруулсан.  | Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж, батлуулсан байна. Хууль дагаж гарах дүрэм журмыг боловсруулсан байна. | НЭМГ-ХБӨХ     | Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр батлуулсан.<br>1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу Эрүүл мэндийн яамны албан ёсны цахим хуудсанд <a href="https://moh.gov.mn/">https://moh.gov.mn/</a> хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг ил тод байршуулан иргэд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоос саналыг хүлээн авч хуулийн төсөлд тусгасан.<br>2. Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хуулийн үзэл баримтлалыг Эрүүл мэндийн яамны албан ёсны цахим сайтад байршуулан, салбар яамнуудаас санал авахаар Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 1а/1296 тоот албан бичиг хүргүүлэн ажилласан.<br>3. Хуулийн төсөлд бүх яамдаас 1а/1296 дугаар албан бичгээр санал авч саналыг тусган Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдаас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1а/2582 тоот албан бичгийг хүргүүлсэн.<br>4.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023.06.08-ны 1/3223 дугаар албан бичиг, Сангийн сайдын 01/4201 дугаар албан бичгүүдээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл олгосон.<br>5. Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийн дагуу материалуудыг нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх тухай 2023 | 70             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт            | Суурь түвшин | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|-----------------------------|--------------|--|---------------|--|----------------|
|     |   |                 |                             |              |  |               | оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 1а/2793 тоот албан бичгээр ЗГХЭГ-г хүргүүлсэн.<br>6.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай анхдагч хуулийн төслийг Улсын их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар дэмжигдсэн.  |                |
| 41. | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14.1<br>Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг батлуулах.  | -               | Засгийн газрын тогтоол      | -            | Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг боловсруулж, батлуулсан байна. | НЭМГ-УСХЗХ    | Импортын согтууруулах ундааны техникийн зохицуулалтын талаарх холбогдох стандарт болон норматив техникийн баримт бичгийг судалж байна. Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтын төслийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамтай хамтран боловсруулж байна. Техникийн зохицуулалтыг боловсруулахад бусад салбарын төлөөлөл шаардлагатай тул салбар хоорондын ажлын хэсгийг байгуулахаар төлөвлөж байна.  | 0              |
| 42. | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11.2<br>Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журам боловсруулж батлуулна. | -               | Эрүүл мэндийн сайдын тушаал | -            | Журмыг шинэчлэн боловсруулж Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна.   | ЭТҮГ<br>НЭМГ  | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/315 тушаалаар батлагдсан ажлын хэсэг 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр жолооч бэлтгэдэг сургалтын байгууллагын төлөөлөл, ЦЕГ, ТББ, ЭЭХХЗГ зэрэг албан бус ажлын хэсэгтэй уулзалт хийж, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, эрүүл мэндийн үзлэгийн хуудасны загварын төслийг тус тус боловсруулсан.<br>Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд ЗТХЯ, ЗХАБҮЗ-ийн ажлын албатай хамтран хэрэгжүүлэх тухай саналыг 2023 оны 16/1946 албан бичгээр хүргүүлсэн.<br>ХЗДХСайдын 2023 оны А/118 дугаар тушаалаар байгуулагдсан жолооны үнэмлэхний загвар батлах тухай ажлын хэсгээс гарсан жолооны үнэмлэхний загварын төсөлтэй жолоочийн эрүүл мэндийн үзлэгийн хуудасны загвар болон бусад холбогдох мэдээллийг коджуулж оруулах тал дээр ажлын хэсгийн нарийн бичигтэй хамтран ажиллаж байна. | 30             |
| 43. | Агаарын тухай хуулийн 21.4<br>Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож, жагсаалт батлуулах.  | 18.0            | Эрүүл мэндийн сайдын тушаал | -            | Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож, жагсаалт              | НЭМГ          | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/463 дугаар тушаалаар Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож, жагсаалт батлуулах ажлын хэсгийг БОАЖЯ, ХНХЯ, АШУҮИС, Нийслэлийн агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Стандарт хэмжил зүйн газар, Монголын хөдөлмөрийн эрүүл ахуйчдын үндэсний холбоо зэрэг байгууллагын нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын хэсгийн хурлаар үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, 6 удаагийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж, хамгаалалтын бүсийн хэмжээг   | 50             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|--|--------------|--|---------------|---|----------------|
|     |   |                 |  |              | батлагдсан байна.  |               | тогтоох жагсаалтын төслийг боловсруулсан. 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 6/5388, 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 6/4270 тоот албан бичгээр холбогдох мэргэжлийн байгууллагуудаас саналыг авч, тус яамны Салбарын хяналтын газрын саналыг нэмж тусган жагсаалтыг эцэслэн боловсруулсан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, Ерөнхий шаардлага MNS 5105:2001 стандартад дурдагдаагүй орчиндоо эрсдэл бүхий хүчин зүйл үүсгэн үйл ажиллагаа явуулдаг 14 чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагад эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээг тогтоох Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг ЭМЯ-ны удирдлагуудад тойрох хуудсаар танилцуулж, санал авч байна.  |                |
| 44. | Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль 15.3<br>Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг боловсруулах.   | -               | Эрүүл мэндийн сайдын тушаал  | -            | Журам Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан байна.   | НЭМГ-УСХЗХ    | Эхийн сүүний нөөцийн банкны журмын төсөл боловсруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор ЭМЯ, НЭМҮТ, НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөллүүд 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдөр уулзалт хийж ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн. Журмын эхний төслийг боловсруулсан ба холбогдох газруудаас санал авахаар ажиллаж байна.<br>ДЭМБ-аас 2022 онд батлагдан гарсан Зүүн өмнөд Азийн “Эхийн сүүний банкны стандарт”-ыг орчуулсан.   | 0              |
| 45. | Ерөнхийлөгчийн 2019 оны 104 дүгээр зарлиг 1.12<br>Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлохыг завдсан тохиолдлуудад урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл сурталчилгаа хийнэ.   |                 | Аян зохион байгуулсан тайлан   | -            | “Амиа хорлолтын эсрэг өдөр”-ийг угтсан аян зохион байгуулсан байна.  | НЭМГ-ХБӨХ     | Дэлхий даяар сэтгэцийн эрүүл мэндийн өдрийг жил бүрийн 10-р сарын 10-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Энэ жил “Сэтгэцийн эрүүл мэнд бол хүний түгээмэл эрх юм” гэсэн уриан дор тэмдэглэсэн.<br>Энэхүү өдрийг тохиолдуулан СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД-2023 эрдэм шинжилгээний олон улсын хурлыг “Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд” уриан доор тэмдэглэсэн.   | 50             |
| 46. | Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлиг 1.3<br>Архи, согтууруулах ундаанд ногдуулах онцгой албан татварын орлогоос архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлээр эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлсэн үйл ажиллагааны тоо | -               | Согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлээр эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлсэн үйл ажиллагааны тоо | -            | Согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлээр эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлсэн үйл ажиллагааны тайланг хүлээн авсан байна. | НЭМГ-ХБӨХ     | 2023 оны жилийн эцсийн байдлаар архи согтууруулах ундааны хор уршгийг нийгэмд сурталчлан таниулж, соён гэгээрүүлэх чиглэлийн 9 төсөлд нийт 278.6 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Тухайлбал:<br>1. СЭМ-ийг хамгаалах, архи тамхи мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх сургалт<br>2. СЭМ-ийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт хөнөөллөөс сэргийлэх “Анхааръя” төсөл<br>3. Иргэд, залуучуудад амралт, баяр ёслолыг архи дан согтуурахгүйгээр тэмдэглэх шинэ соёлыг төлөвшүүлэх<br>4. Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдолд, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэх гэх мэт | 100            |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|--|-----------------|---|--------------|---|---------------|---|----------------|
| 47. | Ерөнхийлөгчийн 2022 оны 43 дугаар зарлиг 1.7<br><br>Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт архи, согтууруулах ундаа, түүнээс үүдэн гарах хор уршиг, сөрөг нөлөөг сурталчлан таниулах агуулгыг тусгах. | -               | Шинээр боловсруулсан сургалтын хөтөлбөрт тусгах агуулга |              | Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах архи, согтууруулах ундаа, түүнээс үүдэн гарах хор уршиг, сөрөг нөлөөг сурталчлан таниулах агуулгыг боловсруулж хүргүүлсэн байна. | НЭМГ-ХБӨХ     | Боловсрол шинжлэх ухааны яаманд 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр 6/4466 дугаар “Санал хүргүүлэх тухай” албан бичгээр согтууруулах ундаа, хорт зуршил түүнээс гарах хор уршиг, сөрөг нөлөөний талаар сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт тусгах саналаа боловсруулан хавсралтаар хүргүүлсэн.<br>ЕБС-ийн Эрүүл мэндийн боловсрол-эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр архи мансууруулах бодис ба донтолт, стресс менежмент сэдвүүдээр 4,7,11,12 гэсэн нийт 4 ангийн “Эрүүл мэнд” хичээлийн сурах бичгийн номд нийт 8 бүлэг сэдэв сургалтын материалыг боловсруулан өгч, одоогоор сургалтад ашиглаж байна.   | 100            |
| 48. | Улсын Их Хурлын Байнгын Хорооны 2022 оны 06 дугаар тогтоол<br><br>Хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх зарим арга хэмжээг хэрэгжүүлэх.   | -               | Үнэлгээний тайлан                                       | -            | Үнэлгээний тайлан гарсан байна.   | НЭМГ-ХБӨХ     | БШУЯ, ЦЕГ, ТЕГ, СЭМҮТ-тэй хамтран Аймаг, дүүргийн Залуучуудын хөгжлийн төвүүдээр дамжуулан тамхи, архи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, хор уршиг, сэргийлэх арга замуудын талаар сургалт, зөвлөгөө, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, өсвөр үе, залуучуудыг хамруулсан. Хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлдэг байгууллагад НЭМҮТ, СЭМҮТ багийн бүрэлдэхүүнээр үнэлгээ хийж, хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн. Тухайлбал: нийслэлийн 5 дүүргийн 10 автобусны зогсоол, 5 гудамжны мэдээллийн байгууламжид бүх төрлийн тамхины бүтээгдэхүүний хор уршгийг сурталчлах чиглэлээр зурагт хуудас байршуулсан. Мөн 4 худалдааны төвийн мэдээллийн лед дэлгэцэд тамхины хор уршгийг сурталчлан видео шторкийг байршуулсан.  | 30             |
| 49. | Улсын Их хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоол<br><br>Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах.  | -               | Шинээр гаргасан МСС-ны материалын төрөл, тоо            | -            | Хоол, хүнсний зөв, зохистой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байна.  | НЭМГ-УСХЗХ    | 1. Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталсан “Зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлэх, иргэдэд эрүүл идэвхтэй амьдрах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах” ажлын хүрээнд зохистой хооллолт, эрүүл идэвхитэй амьдралын хэв маягийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг мэдээлэл сурталчилгаа, бичлэг, зөвлөгөө, үзлэг оношлогоо, ажлын байрны дасгал, спортын тэмцээн зэрэг олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан.<br>2. 2023 онд иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, хоол хүнсний зохистой хэрэглээ, эрүүл зан үйлийг хэвшүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллагын “Эрүүл зан үйл төлөвшүүлэх сургагч багш бэлтгэх”, “Эрүүл амьдрал энгийнээс эхлэнэ”, “Эрүүл мэндийн боловсрол- цогц мэдээлэл” зэрэг төсөл ажлыг дэмжин Эрүүл мэндийг дэмжих сангаас нийт 49,940,000 төгрөгийн санхүүжилтийг олгож эрүүл зан үйлийг хэвшүүлэх ажлыг дэмжин ажиллаж байна. | 100            |



| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт            | Суурь түвшин  | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|--|-----------------|-----------------------------|---|---|---------------|---|----------------|
|     |  |                 |                             |   |   |               | 3. ЭМЯ, МҮОНРТ-тэй хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох Эрүүл мэнд-Теле сэтгүүл телевизийн нэвтрүүлгийн 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн дугаар Хүүхдийг илүүдэл жин таргалалтаас сэргийлэх, хөдөлгөөний хомсдолоос сэргийлье сэдвээр явагдсан бөгөөд эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсуудаар түгээгдэж байна.<br>4. ЭМЯ, БШУЯ, ХХААХҮЯ хамтран ДЭМБ болон НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэй сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны шим тэжээлийг сайжруулах, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх чиглэлээрх бодлогыг дэмжих, хүүхдийн хоолны чанар, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хоол шим тэжээлийн талаар олон нийтийн ойлголтыг сайжруулах хүрээнд “Хүүхдийн хоол” үндэсний чуулганыг 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр 1000 оролцогчтой зохион байгуулсан нь хүүхдийн хоолны чанар хүртээмжийг сайжруулах талаар оролцогч талуудад чиглэсэн томоохон нөлөөллийн арга хэмжээ болсон.   |                |
| 50. | Ерөнхий сайдын 2022 оны 188 дугаар захирамж<br><br>Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журмыг шинэчлэн батлуулах. |                 | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/143 дүгээр тушаалыг мөрдөж байна. | Журам Эрүүл мэндийн сайдын тушаалаар шинэчлэн батлагдсан байна. | НЭМГ-УСХЗХ    | Эрүүл мэндийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/160 дугаар тушаалаар “Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодисыг улсын бүртгэлд бүртгэх журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулж, ажлын хэсгийн хурлыг 2023 оны 06, 11 дүгээр сард 2 удаа зохион байгуулж, журмын төслийг боловсруулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалтууд хийж, зөвшилцөн журмын төслийг эцэслэн боловсруулж, ЭМЯ-ны удирдлагуудад тойрох хуудсаар танилцуулж, саналыг авч байна.   | 50             |
| 51. | Засгийн газрын 2022 оны 55 дугаар тэмдэглэл<br><br>Дархлаажуулал-тын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тушаал шинэчлэн батлуулна.               |                 | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2001 оны 34 дүгээр тушаалыг мөрдөж байна.    | Журам Эрүүл мэндийн сайдын тушаалаар шинэчлэн батлагдсан байна. | НЭМГ-ХӨХ      | Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлж, 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар баталсан.<br>Нэмэлт өөрчлөлт оруулсан хууль болон ЗГ-ын тогтоолтой уялдуулан ЭМС-ын 2012 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн “Дархлаажуулалтын тухай” 217 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2002 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн “Журам батлах тухай” 201 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 1997 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн “Журам батлах тухай” А/219 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2001 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн “Дархлаажуулалтын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 34 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн “Дархлаажуулалтын тухай” А/261 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2011 оны 4 дүгээр сарын 11-ны өдрийн 122 тоот тушаал вакцин био бэлдмэлийг хүлээн авах, тээвэрлэх, хадгалах явцад баримтлах журам, Эрүүл мэндийн сайдын 2016 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” А/278 тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/315 дугаар тушаалуудад | 0              |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж                       | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                            | Суурь түвшин | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|---|--------------|---|---------------|---|----------------|
|     |   |                 |   |              |   |               | өөрчлөлт оруулахаар холбогдох мэргэжилтнүүдтэй ажлын хэсгийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулан ажиллаж байна.   |                |
| 52. | МУХТЖҮЧ 2.2.2<br>Зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих аян зохион байгуулна. |                 | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь |              | Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьд хүрсэн байна. | НЭМГ-УСХЗХ    | Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлэх, эрүүл идэвхтэй амьдралыг сурталчлах, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэсэн аяны үйл ажиллагааг 2023 оны туршид зохион байгуулахаар Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/87 өдрийн тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийг батлуулсан.<br>2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр “Энэ жилдээ-эрүүл жиндээ” уриатай аяны үйл ажиллагааг эхлүүлж, 21 аймаг, 9 дүүрэг, эрүүл мэндийн яамны харьяа 22 байгууллагаас эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх мэдээлэл сурталчилгаа, видео бичлэг, зөвлөгөө, үзлэг оношилгоо, ажлын байрны дасгал, спортын тэмцээн зэрэг олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Олон нийтийн мэдээлэл сурталчилгааны нийт хандалт 369,761 байна. 21 аймгийн хүрээнд 141 удаагийн сургалтаар 4977 хүнд эрүүл мэндийн боловсрол олгож, олон нийтийг хамруулсан үйл ажиллагаанд 14474 хүн оролцож, 650 ширхэг мэдээлэл сургалт, сурталчилгааны материал хэвлэж түгээсэн. Цахим сүлжээний инфографикийн хандалт – 29233 байна. Нийт 658 хүнд эрүүл мэндийн үзүүлэлт, зөвлөгөө өгч, 418 хүн авсан хүн спортын тэмцээнд оролцсон. 17 ярилцлага, мэдээлэл, 2 удаагийн өдөрлөг зохион байгуулсан.<br>-“Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд” цахим аяныг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл зохион байгуулж байна. 21 аймгийн нийт 300 гаруй эрүүл мэндийн байгууллагын цахим хуудсаар сэтгэцийн эрүүл мэндийн постер, видео, онлайн зэрэг 20 сэтгэцийн эрүүл мэндийн сэдвийн хүрээнд бэлтгэн түгээж байна. “Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд аян”-ы хүрээнд явагдаж байна.<br>-Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх “Харамсахгүйн төлөө хамтдаа” аяныг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, цуврал контентуудыг ЭМЯ, НЭМҮТ, эрүүл мэндийн байгууллагуудын цахим сувгаар түгээж байна.<br>-Эрүүл мэндийг дэмжих санд 2023 оны 1-4 дүгээр улиралд 2023 оны 1-4 дүгээр улиралд халдварт, халдварт бус өвчнөөс сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхины хор уршгийг таниулах сурталчлах үйл ажиллагааг дэмжсэн 303 төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санал ирүүлснээс 41 төслийг сонгон шалгаруулж, нийт 2.1 тэрбм төгрөгийн санхүүжилт олгосон. ЭМЯ болон МҮОНРТ хоорондын хамтын ажиллагааны санамж бичгийг 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдөр байгуулж, санамж бичгийн хүрээнд халдварт, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхины хор уршгийг таниулан сурталчлах, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 20 сэдвээр нэвтрүүлэг бэлтгэж, 2023 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр | 70             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                | Суурь түвшин | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|--|-----------------|---------------------------------|--------------|--|---------------|---|----------------|
|     |  |                 |                                 |              |  |               | хүртэл долоо хоног бүрийн бүтэн сайн өдөр 11:20 минутаас 20 минутаар сүлжээний дагуу цацагдсан. Нийт 20 дугаар 480 минут, MNB пэйж хуудас болон төрөлжсөн сувгуудаар 1960 минутын давталттайгаар үзэгчдэд хүрсэн.<br>-ЭМЯ болон Таван Богд Группын хооронд хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, эрүүл зохистой хооллолт, дасгал хөдөлгөөн, нойрны ач холбогдол, амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр цуврал контент, постер, ярилцлага, видео бичлэг бэлтгэн түгээхэд бэлэн болсон.   |                |
| 53. | МУХТЖҮЧ 2.2.2 Эрүүл мэндийн салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх.     |                 | Үнэлгээний тайлан               | -            | Үнэлгээний тайланг жендерийн үндэсний хороонд хүргүүлсэн байна.              | НЭМГ-ХБӨХ     | Бодлогын баримт бичгийн явцын үнэлгээг хийж, тайланг 2/4615 дугаар албан бичгээр ЭМЯ-ны харьяа болон аймаг, нийслэлийн ЭМГ-т хүргүүлсэн. Мөн ЭМЯ-ны газар, хэлтэст дотоод меморандум №207 хүргүүлсэн. Бодлогын хэрэгжилт 38.7 хувийн үнэлгээтэй буюу хангалтгүй байна.  | 30             |
| 54. | Өсвөр үеийн “Үе тэнгийн зөвлөгч” бэлтгэх сургалтыг Үндэсний хэмжээнд зохион байгуулах. | -               | Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо | -            | 21 аймаг, 9 дүүрэгт үе тэнгийн зөвлөгч болон сургагч багш бэлтгэгдсэн байна. | НЭМГ-ХБӨХ     | Өсвөр үе, оюутан залууст чиглэсэн үе тэнгийн зөвлөгч бэлтгэх олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг дэлгэрүүлэх зорилгоор үндэсний хэмжээний сургагч багш бэлтгэх “Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд” сэдэвт сургалтын хөтөлбөрийг ЭМЯ-ны газрын даргаар батлуулан Монголын эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын холбоотой хамтран 2023 оны 02 дугаар сард зохион байгуулж, үндэсний хэмжээний сургагч 60 багшийг бэлтгэсэн. Сургагч багш нар 2023 оны 03-04 дүгээр сард АШУҮИС, Этүгэн ИС, Ач АУИС, МУИС, МУБИС 5 их, дээд сургуулийн 150 оюутануудад сургалтыг зохион байгуулж, “Үе тэнгийн зөвлөгч” оюутнуудыг бэлтгэсэн.<br>НЭМҮТ, АШУҮИС-иас бэлтгэгдсэн үндэсний сургагч багш нар 21 аймгийн өсвөр үеийн эмч, мэргэжилтнүүдэд цахим сургалт зохион байгуулсан. Энэхүү өсвөр үеийн эмч, мэргэжилтнүүд нь Аймгийн боловсролын газартай хамтран “Үе тэнгийн сургагч” бэлтгэх сургалтыг 2023 оны 09-10 дугаар сард зохион байгуулж нийт 214 өсвөр үеийн сургагч багш бэлтгэгдсэн. | 100            |
| 55. | Эрүүл ахуйч, тархвар судлаачдын Үндэсний IV зөвлөгөөн зохион байгуулах.                |                 |                                 |              | Үндэсний зөвлөгөөн зохион байгуулж, нэгдсэн зөвлөмж гарсан байна.            | НЭМГ-УСХЗХ    | Эрүүл ахуйч, тархвар судлаачдын Үндэсний дөрөвдүгээр зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах удирдамж, арга хэмжээний төлөвлөгөө, төсвийг боловсруулсан. Зөвлөгөөнийг санхүүжүүлэх хүсэлтийг ДЭМБ-д хүргүүлж, дэмжигдсэн. Уг зөвлөгөөнийг зохион байгуулах чиглэлийг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд 2023 оны 11 дүгээр сарын 13-ны 6/5103 тоот албан бичгээр хүргүүлсэн. НЭМҮТ ажлын удирдамж төсөв боловсруулан, 11 дүгээр сарын 17-ны өдөр НЭМҮТ, ЗОНОЗ, ХӨСҮТ, АШУҮИС-НЭМС, ЭМЯ-СХГ, НЭМГ, ДЭМБ-ийн төлөөлөлтэй уулзаж, зөвлөгөөний тов, удирдамжийг тохиролцсон боловч цаг хугацааны хувьд зохион байгуулж амжихгүй болсон тул 2024 оны 1-р улиралд зохион байгуулахаар хойшлуулсан.<br>2023 оны 12 дугаар сард багтаан Эрүүл мэндийн сайд нийт эрүүл ахуйч, тархвар судлаач нартай зангиагүй нээлттэй уулзалт зохион байгуулахаар төлөвлөж байна.   | 0              |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин  | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|--|---|---|---------------|--|----------------|
| 56. | ЗГҮАХ 2.1.5.5 Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүрэм, стандартуудыг шинэчилнэ.  | -               | Шинээр батлагдсан дүрэм, стандартын тоо                      | -   | Шаардлагатай дүрэм, стандартыг шинэчлэн батлуулсан байна.   | НЭМГ-ХБӨХ     | Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.7.Энэ хуулийн 7.1.2, 7.1.3-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын бүтэц, дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж тусгасан болно. Хууль батлагдсанаар нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц, дүрэм шинэчлэгдэн батлагдана.  | 0              |
| 57. | ЗГҮАХ 2.1.5.6 ЭМССТ 1.13 Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.  | -               | УИХ-аар батлагдсан хууль, Шинээр батлагдсан дүрэм журмын тоо | Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэ -хээр хүргүүлсэн. | Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж, батлуулсан байна. Хууль дагаж гарах дүрэм журмыг боловсруулсан байна. | БТГ-СУХ       | Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 онд хүргүүлсэн боловч ЗГХЭГ-аас 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн ХЭГ/121 тоот албан бичгээр Эрүүл мэндийн сайд шинээр томилогдсонтой холбоотойгоор буцаагдсан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг дахин батлуулахаар холбогдох яамдад албан бичгээр хүргүүлсэн ба Тамхины хяналтын тухай хуулийн үзэл баримтлалыг 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр шинэчлэн батлуулсан. Тамхины хяналтын тухай хуулийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бүх яамдаас санал авсан, 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 1А/3896 1а/3895 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд зөвшөөрөл авахаар хүргүүлсний дагуу санал ирүүлсэн бөгөөд саналыг судалж байна. | 30             |
| 58. | ЗГҮАХ 2.1.5.7 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхыг нэмэгдүүлж, аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах. | 7,000.0         | Байгуулсан нийгмийн эрүүл мэндийн төвийн тоо                 | -   | 8 аймаг, 4 дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулсан байна.   | БТГ-СУХ       | "Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тухай" Засгийн газрын тогтоол болон дагалдаж гарах баримт бичгийн төслийг боловсруулсан ба уг асуудлыг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд шинээр төв байгуулах ажил хойшлогдсон. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад нөхцөл байдлын дүн шинжилгээ хийв. Дүн шинжилгээгээр орон нутгийн эрүүл мэндийн газар, нийгмийн эрүүл мэндийн төв, дүүргийн эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг дахин нягталж үндэсний түвшинд Өвчний хянат сэргийлэлтийн төв, аймаг, дүүргийн түвшинд нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах бүтэц, зохион байгуулалтын бодлогын хувилбарууд боловсруулсан   | 30             |
| 59. | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга (нэмэлт, өөрчлөлт)-ын төсөл боловсруулж батлуулна.   | -               | ЗГ-ын хуралдааны шийдвэр                                     | Ажлын хэсэг байгуулагдсан                                       | Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.  | БТГ           | - Эрүүл мэндийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/53 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.<br>- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн ажиллах цагалбар төлөвлөгөөг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж батлуулсан.<br>- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг 4 удаа хуралдуулсан.<br>- Эрүүл мэндийн байгууллагуудаас хуулийн хэрэгжилттэй холбогдуулан албан бичгээр санал авсан.<br>- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулиудад зүйл, хэсэг, заалт тус бүрд оруулсан өөрчлөлтөд тоон судалгаа гаргасан.   | 0              |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж                         | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин   | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|--|--|---|---------------|---|----------------|
|     |   |                 |  |  |   |               | <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын хүрээнд боловсруулсан.</li> <li>- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн зүйл, хэсэг, заалт бүрээр дүн шинжилгээ хийсэн.</li> <li>- Хуулийн төслийн үзэл баримтлалын эхний төслийг боловсруулсан.</li> </ul>   |                |
| 60. | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай шинэчилсэн найруулга (нэмэлт, өөрчлөлт)-ын төсөл боловсруулж батлуулна. | -               | ЗГ-ын хуралдааны шийдвэр   | Ажлын хэсэг байгуулагдсан  | Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.  | БТГ /ЭТҮГ/    | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг шинэчилэн боловсруулах ажлын хэсэг Эрүүл мэндийн сайдын 2023 оны 3 дугаар сарын А/53 дугаар тушаалаар батлагдсан. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн заалт бүрийг Эрүүл мэндийн тухай хуультай харьцуулан дүн шинжилгээ хийж, ажлын хэсэгт танилцуулсан. Эрүүл мэндийн тухай хуультай давхцсан заалт, нэмж оруулах шаардлагатай зүйл заалт бүр дээр ялгаж гаргасан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл, эмнэлгийн шатлал зэргээр олон улсын, дэлхийн орнуудын байдлыг судалж, ажлын хэсгийн хурлаар танилцуулсан. ЭТҮХ-ийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан түр хүлээж байна.   | 30             |
| 61. | ЗГҮАХ 2.1.10.1 Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж батлуулна.                 |                 | УИХ-д өргөн барьсан хууль  |  | Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж батлуулсан байна.  | БТГ           | <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/53 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.</li> <li>- Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн ажиллах цагалбар төлөвлөгөөг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж батлуулсан.</li> <li>- Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг 4 удаа хуралдуулсан.</li> <li>- Эрүүл мэндийн байгууллагуудаас хуулийн хэрэгжилттэй холбогдуулан албан бичгээр санал авсан.</li> <li>- Эрүүл мэндийн тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулиудад зүйл, хэсэг, заалт тус бүрд оруулсан өөрчлөлтөд тоон судалгаа гаргасан.</li> <li>- Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын хүрээнд боловсруулсан.</li> <li>- Эрүүл мэндийн тухай хуулийн зүйл, хэсэг, заалт бүрээр дүн шинжилгээ хийсэн.</li> <li>- Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан.</li> <li>- Хуулийн төслийг боловсруулан Эрүүл мэндийн яамны цахим хаягт байршуулан санал авч байна.</li> </ul> | 30             |
| 62. | ЗГҮАХ 2.1.6.3 Дүрс архивлан хадгалах нэгдсэн тогтолцоо (PACS) бүрдүүлнэ.                                      | 100.0           | Дүрс архивлан хадгалах систем нэвтэрсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | Төрөлжсөн мэргэшлийн 2 эмнэлэг дүрс архивлан хадгалах системтэй. | Эрүүл мэндийн байгууллагуудад Дүрс архивлан хадгалах систем бүрэн ашиглагдаж жигдэрсэн байна. | БТГ-СТХ       | Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд хийгдэж буй (PACS) системд 2023 оны эхний хагас жилийн байдлаар ЭХЭМҮТ, ХӨСҮТ, ХСҮТ, ГССҮТ, СЭМҮТ болон ЧД, СХД, ХУД БЗД-ийн ЭМТ, Орхон, Ховд, Дорнод, Өвөрхангай аймгийн БОЭТ, аймгийн 17 НЭ нийт 31 байгууллага холбогдон оношилгоо, шинжилгээний зураг дүрсэн мэдээллийг хадгалах, дамжуулах үйл ажиллагааны хүрээнд E-Health програм хангамжаар дамжуулан хөгжүүлэлт хийж ашиглаж байна.  | 90             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                                     | Суурь түвшин   | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|--|--|---|---------------|--|----------------|
| 63. | ЗГҮАХ 2.1.6.4<br>Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ.         | 500.0           | Телемедицин нэвтэрсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | ЭХЭМҮТ, УНТЭ, УГТЭ-т телемедициннэ втэрсэн.                | Лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 31 эрүүл мэндийн байгууллагад телемедицин нэвтэрсэн байна. | БТГ-СТХ       | Алсын зайн анагаах ухааны системийг УГТЭ-ийн зүрхний төвийн санаачилгаар МН кардио програм хангамжийг хөгжүүлсэн. Тус програмд:<br>- Хувийн эрүүл мэндийн байгууллага-4,<br>- Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллага-212,<br>- Аймгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв-21<br>- Дүүргийн эрүүл мэндийн төв-9<br>- Эрүүл мэндийн яамны харьяа-4 нийт 250 байгууллага холбогдон зүрх судасны чиглэлээр эмнэлзүйн хэлэлцүүлэг, хариу зөвлөгөө зэрэг үйл ажиллагаанд ашиглаж байна.<br>- 2023 онд шинээр анхан шатны эрүүл мэндийн 26 байгууллагыг холбож зүрх судасны чиглэлээр сургалт, үзлэгийн мэдээлэл, заавар зөвлөмжийг өгч байна.<br>- ЭХЭМҮТ Эх нярайн тусламжид зайн оношилгооны дэмжлэг үзүүлэхээр 21 аймаг болон нийслэлийн амаржих газруудад IP camera, IP phone тогтолцооны тоног төхөөрөмжүүдийг суурилуулан ашиглаж байна.<br>2023 оны байдлаар зайн зөвлөгөө-588, зайн сургалт-42, зайн хурлыг-148 хийсэн байна.             | 100            |
| 64. | ЗГҮАХТ 4.1.4.1<br>Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний E-Mongolia платформд холбоно.       | -               | Нэмэгдсэн үйлчилгээний төрлийн тоо                   | 21 төрлийн эрүүл мэндийн лавлагаа үйлчилгээг үзүүлж байна. | E-Mongolia платформоор дамжуулан Төрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн байна. | БТГ-СТХ       | Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээг үзүүлэх чиглэлд Эрүүл мэндийн салбарын Иргэнд зориулсан 11 ААН-д зориулсан 20 нийт 31 үйлчилгээг E-Mongolia платформоор дамжуулан хүргэж байна.<br>E-Mongolia платформоор дамжуулан давхардсан тоогоор иргэд 3,306,706 удаагийн үйлчилгээг цахимаар, аж, ахуй нэгж 9,803 удаагийн үйлчилгээ 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар цахимаар үйлчилгээнүүдийн авсан байна. Эмнэлэгт өвчтөн илгээх (Каскад) АМ-13А,Б,В маягтыг цахимаар илгээх, хүлээн авах үйлчилгээг "E-Mongolia"-д 2023 оны 4 сарын 01-ний өдөр холбосон.<br>"E-health" программ хангамжид эрүүл мэндийн 63 байгууллага, энгийн эмийн жорыг нийт 1200 гаруй хувийн хэвшлийн эмийн сангуудыг холбож E-Mongolia платформоор дамжуулан энгийн эмийн жор бичих хөгжүүлэлт хийгдэж, туршилт амжилттай хийгдэн нэвтрэхэд бэлэн болсон. Иргэн энгийн эмийн жороо авах боломж бүрдлээ. | 100            |
| 65. | ҮАБЗ-ийн 2018 оны 06 дугаар зөвлөмж<br>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч, донтогчдын талаарх судалгааг зохион байгуулна. | -               | Судалгааны тайлан                                    | -  | Судалгааны үр дүнг хүлээн авсан байна.  | БТГ-СТХ       | "Үндэсний хэмжээнд мансууруулах бодис ба архинд донтох эмгэгийн тархалт, эмчилгээний хамралт ба амиа хорлож нас барсан, оролдлого хийсэн тохиолдлыг судлах нь" судалгааг Эрүүл мэндийг дэмжих сангийн (66,185,000₮) санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн. Судалгааны үр дүн, тайланг Эрүүл мэндийг дэмжих санд 2023.XI/30-ны 1/1171 албан бичгээр хүргүүлсэн.  | 100            |
| 66. | Ерөнхийлөгчийн 2019 оны 104 дүгээр зарлиг   | 200.0           | Батлагдсан маягт<br>Шинээр үүссэн мэдээллийн сан     | -  | Амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон  | БТГ-СТХ       | Ерөнхийлөгчийн 2019 оны 104 дүгээр зарлигийн хэрэгжилтийн хангах зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны А/137 дугаар тушаалаар Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг  | 50             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин  | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|--|---|---|---------------|---|----------------|
|     | Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээтэй болгоно. |                 |  |   | тохиолдлыг бүртгэх маягыг батлуулж, мэдээллийн сан үүсгэсэн байна.            |               | бүртгэх мэдээллийн сан байгуулах үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулсан. Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн сан үүсгэх зорилгоор 4 байгууллагын цахим туршилтууд хийгдсэн. 4 яамдын хамтарсан ажлын хэсгээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан үүсгэх асуудлаар санал солилцож хамтран тушаал батлахаар Цахим хөгжлийн яам, Инновацийн Байнгын хорооны хамтарсан ажлын хэсгийн хүрээнд цахимжуулахтай холбоотой батлагдах 120 хуулийн өөрчлөлтөд тусгагдан Эрүүл мэндийн тухай хуульд "Магадлагааны салбар дундын нэгдсэн сан, түүнийг зохицуулах журам" заалт УИХ-ын чуулганы анхны хэлэлцүүлгээр орж дэмжигдсэн.   |                |
| 67. | Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмыг боловсруулж, батлуулна.                                | -               | Засгийн газрын тогтоол   | -   | Журам Засгийн газрын тогтоолоор батлагдсан байна.                             | БТГ-СТХ       | Тус журмын төслийг Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/509/А/60 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгээр нийт 4 удаа хэлэлцүүлж, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон эдгээр хуулиудыг дагаж гарсан журмуудад нийцүүлэн боловсруулсан. Засгийн газрын тогтоолын төсөлд тусгах саналыг бүх яамд болон ТЕГ-аас 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр эцэслэн авсан бөгөөд саналын товъёог нэгтгэгдсэн. Журмын төслийн үндсэн зохицуулалт болох Эрүүл мэндийн өгөгдөл солилцох платформыг гүйцэтгэх Эрүүл мэндийн мэдээллийн технологийн төв Улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг мөн боловсруулж дууссан. Иймд дээрх журмыг УТҮГ-ыг байгуулах асуудалтай хамт хэлэлцүүлэхээр Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газарт албан бичиг хүргүүлсэн. УТҮГ-ыг байгуулах болон журмын тогтоолын төслийг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх төлөвлөгөө батлагдсан ч хойшилсон тул 2023 оны 9 дүрээр сарын 29-нд дахин хэлэлцүүлэхээр саналаа өгсөний дагуу ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 10 дугаар сарын 11-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гарсан. Тус хурлын гишүүдийн саналыг тусган шийдвэрийн дагуу ЗГХЭГ-т хүргүүлэхээр бэлэн болсон. | 70             |
| 68. | ЗГҮАХ 2.1.6.8 Эрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ.   | 1,300.0         | Мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоо | 127 сум, өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн. | 191 сум, өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн байна. | ЭТҮГ-АЛШТХ    | 2023 оны 8 дугаар сарын 10-ны А/291 дугаар тушаалаар Нийслэлийн 18 ӨЭМТ-ийн Дорноговь, Говь-Алтай, Дорнод, Өвөрхангай, Архангай, Булган аймгийн 28 Сумын ЭМТ-д нийт 56 ширхэг мобайл тоног төхөөрөмжийг багцыг хуваарилсан. Нэмэлтээр Архангай, Говь-Алтай, Дорнод, Өвөрхангай, Дундговь, Завхан, Ховд, Хэнтий аймгийн 57 СЭМТ, Баянзүрх, Баянгол, Налайх, Багануур дүүргийн 17 ӨЭМТ-д мобайл технологийн төхөөрөмж хуваарилж байна. Эрх, сумын ЭМТ-ийг мобайл тоног төхөөрөмжөөр хангахаас гадна уг тоног төхөөрөмжийг ашиглах, өвчин эмгэгийг оношлох талаарх арга зүйн сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 24-31-ний өдрүүдэд зохион байгуулж, Увс, Төв аймгийн 50 орчим эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулав.  | 100            |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин                   | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|--|--------------------------------|---|---------------|---|----------------|
| 69. | ӨОУ-ын 11 дүгээр ангиллыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.  | -               | Батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөө<br><br>2023 онд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь                | -                              | ӨОУ-ын 11 дүгээр ангиллыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг зохион байгуулсан байна. | БТГ-СТХ       | 2023-2024 онд ӨОУА-ын шинэ хувилбарт шилжих календарчилсан төлөвлөгөө боловсруулсан. Тус төлөвлөгөөг ДЭМБ-ын аргачлал, зөвлөмжийн дагуу боловсруулсан бөгөөд 5 бүлгийн 28 арга хэмжээг төлөвлөсөн.<br>"Өвчний олон улсын арван нэгдүгээр ангилал (ICD-11)"-ыг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон "Өвчний олон улсын арван нэгдүгээр ангилал (ICD-11)"-ыг эх хэлнээ хөрвүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, эдгээр ажлын хэсгийн ажлын удирдамжийг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын А/399 дүгээр тушаалаар батлуулсан.   | 70             |
| 70. | МУТЖҮЧ 2.7.4. "Хүний генетикийн тухай хууль"-ийн төслийг боловсруулна.  | -               | ЗГ-ын хуралдааны шийдвэр   | Хуулийн төслийг боловсруулсан. | Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.  | БТГ-СТХ       | Хүний генетикийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/111 тушаалаар батлуулсан. Хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг 2 удаа хуралдуулсан.<br>- Хүний генетикийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 хавсралтын дагуу хийсэн.<br>- Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгаанд үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан.<br>- Хуулийн төслийг боловсруулах ажил хийгдэж байна.  | 0              |
| 71. | МУТЖҮЧ 2.2.5, ЗГҮАХ 2.1.7.1, Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулна.  | -               | Эрсдэлийн сангийн хэмжээ   | -                              | Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг даатгалын санхүүжилтийн 8 хувь (45.7 тэрбум)-иар байгуулсан байна.   | БТГ-СУХ       | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардлагатай тооцоолол, судалгааг хийж, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуульд 1,972.7 тэрбум төгрөгөөр төсөвлөж, үүнээс эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангийн хэмжээг 54.6 тэрбум төгрөгөөр батлагдсан нь өмнөх оныхоос 16.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.  | 30             |
| 72. | ЗГҮАХ 2.1.7.3 Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн Улсын төсөв (ЭМДС)-өөс санхүүжүүлнэ. | 4,500.0         | Батлагдсан урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар, Урт хугацааны тусламж, үйлчилгээнд улсын төсөв (ЭМДС)-өөс | -                              | Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар батлагдаж, тусламж, үйлчилгээний 15 хувийг улсын төсөв (ЭМДС)-өөс                                      | БТГ-СУХ       | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тогтолцоонд суурилсан Идэвхтэй насжилтыг дэмжих төв (ИНДТ) байгуулах, Кейс менежментийг нэвтрүүлэх, УХТҮ-ний загвар туршиж үр дүнг тооцоо "Олон нийтэд түшиглэсэн ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний шинэлэг тогтолцоо, үйлчилгээг хөгжүүлэх нь" ТА9928 төслийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, АХБ хамтран техник туслалцааны төслийг хэрэгжүүлэв. "Ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар турших төлөвлөгөө батлах тухай Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны А/127, А/333 тушаалын хүрээнд аймгийн түвшинд (Дархан-Уул аймаг) | 50             |



| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин  | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|---|---|---|---------------|--|----------------|
|     |   |                 | санхүүжүүлсэн хэмжээ  |   | санхүүжүүлсэн байна.  |               | “Ахмадын хөгжлийг дэмжих төв”, сумын түвшинд (Сэлэнгэ аймгийн Мандал сум) сумын нэгдсэн эмнэлгийг түшиглэсэн “Идэвхтэй насжилтыг дэмжих төв”, дүүргийн түвшинд Нийслэлийн (Сонгинохайрхан дүүрэг) “Ачлалт хүүхдүүд” ТББ-ын асрамжийн газрыг түшиглэн орон нутгийн удирдлагуудыг чадавхижуулах уулзалт, сургалт 2 удаа зохион байгуулж кейс менежементийн заавар боловсруулж мэдээлэл сурталчилгааны контент 2-ыг бүтээж Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр NTV телевизтэй хамтарч хийв.<br>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 08 дугаар тогтоолоор оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад урт хугацааны тусламж үйлчилгээ болох дагнасан сэргээн засахын тусламж, үйлчилгээний 12 оношийн хамааралтай бүлгийн амбулаторийн үзлэг 20,000 төгрөг, өдрийн эмчилгээ 150,000 төгрөг, хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ нь 700,000-1,771,000 төгрөг байхаар тусгаж, төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зардлын ялгааг арилгасан. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад сэргээн засах тусламж, үйлчилгээний 190,024 тохиолдолд 24.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон.                          |                |
| 73. | ЗГҮАХ 2.1.7.6 Санхүүжилтийн гүйцэтгэл, удирдлагын хагас бие даасан байдалтай уялдуулан эрүүл мэндийн байгууллагуудын хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлнэ. | -               | Санхүүжилтийн загвар хэрэгжүүлж байгаа байгууллагын тоо   | Гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэн бүх байгууллагууд санхүүжилтийн загвартай болсон. | Гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжсэн байгууллагууда д санхүүжилтийн загварыг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна. | БТГ-СУХ       | Байгууллагуудын гүйцэтгэлийн санхүүжилтийн 2022 оны болон 2023 оны эхний хагас хэрэгжилтэд судалгаа хийж өр авлага бүхий байгууллагуудын судалгааг гаргасан. АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжиж буй Санхүүжилтийн хөтөлбөр 49173-004-ийн “Нэгдсэн эмнэлгүүдийн хагас бие даасан байдлын хэрэгжилтийг дэмжих” төсөлд хамрагдсан АӨСҮТ, УНТЭ, УГТЭ, ГССҮТ, ЭХЭМҮТ, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвтэй гүйцэтгэлийн санхүүжилтийн хэрэгжилт болон байгууллагын бие даасан байдлын талаар харилцан санал солилцож уулзалт хэлэлцүүлэг 2 удаа зохион байгуулсан. Гүйцэтгэлийн санхүүжилтийн тариф, оношийн хамааралтай бүлгийн санхүүжилт, эрүүл мэндийн байгууллагад тулгамдаж буй асуудлын талаар эрүүл мэндийн байгууллагын удирдлагуудтай нийт 3 удаагийн уулзалт зохион байгуулж ажлын хэсэгт ажилласан. ЭМД-ын гүйцэтгэлийн санхүүжилтийн талаар Өвөрхангай, Орхон аймаг болон Сумын эмч мэргэжилтнүүд, өрхийн эрүүл мэндийн эмч эрүүл мэндийн төвийн ахлагч нартай хэлэлцүүлэг (ӨЭМТ-ийн чуулга уулзалт, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” хэлэлцүүлэг – 2023.04.29) зохион байгуулсан. | 50             |
| 74. | Эрүүл мэндийн байгууллагын хөрөнгийн удирдлагын цахим мэдээллийн санг бий болгох, програм хангамж нэвтрүүлнэ.   | 300.0           | Эрүүл мэндийн байгууллагын хөрөнгийн удирдлагын цахим мэдээллийн санд холбогдсон байгууллагын тоо | -   | Эрүүл мэндийн байгууллагууд хөрөнгийн удирдлагын цахим мэдээллийн сангийн програм хангамж                                 | БТГ-СУХ       | Эрүүл мэндийн байгууллагуудын хөрөнгийн бүртгэлийн нэгдсэн тогтолцооны хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлтийн систем /HEPS/ програм хангамжид хөгжүүлэлт хийж, ашиглаж байна. Энэ ажлын хүрээнд эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн олон улсын нэршил ангиллын UMDNS системийг Монгол Улсад нэвтрүүлэхээр 10068 нэршлээс эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэршил болох 532 нэгдсэн нэршлийг боловсруулан гаргасан. Мөн нэршлүүдийг зурагжуулж гарын авлагыг хэвлүүлэн, эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн, ашиглаж байна.  | 50             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|--|-----------------|---|--|--|---------------|---|----------------|
|     |  |                 |   |  | ашигладаг болсон байна.  |               |   |                |
| 75. | Эрүүл мэндийн салбарын энтерпрайз архитектурыг сонгосон эрүүл мэндийн байгууллагад туршиж, эцэслэн сайжруулна.   | -               | Нэвтрүүлсэн мэдээлэл технологийн энтерпрайз архитектур                      | Холбогдох баримт бичгүүдийн төслийг боловсруулж байна.                             | Эрүүл мэндийн салбарын энтерпрайз архитектурыг нэвтрүүлсэн байна.  | БТГ-СТХ       | Эрүүл мэндийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/27/А/114 дугаар хамтарсан тушаалаар Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 08 дугаар тэмдэглэлийн 2 дахь заалтаар үүрэг болгосны дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглагдаж буй программ хангамж, мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэн, эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэх” үүрэг бүхий ажлын хэсэг тус тус байгуулсан. Дэлхийн банкны цахим Эрүүл мэнд-2 төслийн хүрээнд хийж зурагдсан төслийн дагуу Эрүүл мэндийн салбарын энтерпрайз архитектурын дагуу Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 6 программ, 648 төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг холбон 1,2 сая хүний үзлэгийн мэдээллийг нэгтгэн 7 хоног бүр статистик тоо, судалгааны багуудын үр дүнг тооцон гаргаж байна. | 50             |
| 76. | ЗГҮАХ 2.1.7.11 Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв (ЭМДС)-ийн орлогыг нэмэгдүүлнэ. | -               | Шинэчлэгдэн батлагдсан ЭМД-ын шимтгэлийн хувь                               | -  | ЭМД-ын тухай хуулийн 8.1.3-т заасан даатгуулагчийн сард төлөх шимтгэлийн хувь хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний загвар 5-аас доошгүй хувиар тус тус тогтооно. | БТГ-СУХ       | Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, “Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 12 дугаар тогтоолыг үндэслэн Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2024 оны хувь хэмжээг тогтоох талаар судалгаа, тооцооллыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай хамтран хийж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн ЭМДҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. ЭМДҮЗ-ийн саналыг үндэслэн “Эрүүл мэндийн даатгалын 2024 оны шимтгэлийн хувь хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, санал авахаар бүх яамдад 2023 оны 1а/5512 тоот албан бичгийг хүргүүлсэн. Засгийн газрын хуралдаанаар 12 сарын 20-ны дотор багтаан хэлэлцүүлнэ.  | 50             |
| 77. | ЗГҮАХ 2.1.7.12 Олон улсын эмнэл зүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлнэ.  | 1,400.0         | Олон Улсын эмнэлзүйн удирдамжийг хэрэглэж байгаа эмнэлгийн мэргэжилтний тоо | 2020 онд Волтерс Клувер байгууллагатай “Uptodate” платформыг ашиглах гэрээ хийсэн. | Олон Улсын эмнэл зүйн удирдамжийг нэвтрүүлсэн байна.   | ЭТҮГ-АЛШТХ    | Олон улсын эмнэлзүйн цахим UpToDate платформыг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэн, эмч, эмнэлгийн мэргэжилтний хэрэглээний түвшин сар бүр нэмэгдэж байна. 2023 оны эхний 11 сарын байдлаар тус платформын хэрэглэгчдийн тоо 46,745 байгаа нь өмнөх 9 сартай харьцуулахад 24.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Цахим платформын хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор Монгол улсын эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгэмлэг,   | 100            |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|--|-----------------|---|--|--|---------------|--|----------------|
|     |  |                 |   |  |  |               | UpToDate цахим платформын Монгол улсыг хариуцсан мэргэжилтэн Жинжер Чанг нартай хамтран 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр цахим сургалт зохион байгуулж, нийслэл болон орон нутгийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 300 гаруй эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулав.   |                |
| 78. | Эрүүл мэндийн салбарын санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, олон улсын стандартын дагуу тайлагнана.   | -               | Тайлан өгсөн эрүүл мэндийн байгууллагын тоо<br><br>Зөрчилгүй санал дүгнэлт авсан байгууллагын тоо | Санхүүгийн нэгтгэсэн тайланг холбогдох хууль, НББОУС-ын дагуу тайлагнадаг.           | Эрүүл мэндийн салбарын санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, олон улсын стандартын дагуу тайлагнаж СЯ-д хүргүүлсэн байна.                                      | СЭЗГ-СДХ      | Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 451 байгууллагын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хянан хүлээн авч Эрүүл мэндийн сайдын багцын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусган Үндэсний аудитын газар, Сангийн яаманд хуулийн хугацаанд нь хүргүүлсэн. Эрүүл мэндийн сайдын багцын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан.<br><br>Эрүүл мэндийн Сайдын багцын нэгтгэл тайланд нийт 451 эрүүл мэндийн байгууллагын тайланг нэгтгэснээс 396 байгууллагад дүгнэлт гарсан бөгөөд 329 байгууллага "Өөрчлөлтгүй", 60 байгууллага "Хязгаарлалттай", 3 байгууллага нь "Сөрөг", 4 байгууллага "Дүгнэлт өгөхөөс татгалзсан" санал дүгнэлтүүд авч, 54 байгууллагын санхүүгийн тайлан түүвэрт хамрагдаж, 1 байгууллагын санхүүгийн тайлан аудит хамруулаагүй байна. | 100            |
| 79. | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, 2025-2026 оны дунд хугацааны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлнэ. | -               | Батлагдсан хууль  | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны батлагдсан төсөв | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, 2025-2026 оны дунд хугацааны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлнэ. | СЭЗГ-СДХ      | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдлийг 2023 оны 1а/1462 дугаар албан бичгээр Сангийн яаманд урсгал зардлын хүрээнд 31 төсөл арга хэмжээний 387.5 тэрбум, хөрөнгө оруулалтын хүрээнд 399.8 тэрбум төгрөг, ЭМДСангийн орлогыг 102.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх тооцооллыг боловсруулж хүргүүлсэн. Мөн 2024 оны төсвийн хязгаарын саналыг төсвийн хязгаарын саналын цагалбарын хугацаанд багтаан албан бичгээр Сангийн яаманд урсгал зардлын хүрээнд 33 төсөл арга хэмжээний 404.5 тэрбум, хөрөнгө оруулалтын хүрээнд 399.8 тэрбум төгрөг, ЭМДСангийн орлогыг 259.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх тооцооллыг гаргаж Сангийн яаманд 1а/2689 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.   | 100            |
| 80. | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд санал хүргүүлж, батлуулна.                             |                 | Батлагдсан хууль  | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны батлагдсан төсөв | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийг боловсруулж, хугацаанд нь  | СЭЗГ-СДХ      | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн саналыг нэгтгэн Дирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 2023 оны 1а/3710 дугаарын албан бичгээр Сангийн яаманд урсгал зардлын хүрээнд 420.7 тэрбум, хөрөнгө оруулалтын хүрээнд 735.2 тэрбум төгрөг, ЭМДСангийн төсвийн хүрээнд 2029.6 тэрбум төгрөгийн төсвийн төслийн саналыг нэгтгэн боловсруулж хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцын төсөв нийт 1,634.4 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг нийт 1,933.0 тэрбум төгрөгөөр тус тус батлуулсан. Эрүүл мэндийн сайдын багцын төсөв 2023 оны тодотгосон төсвөөс 20 хувиар,  | 100            |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж           | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                                | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|---|--|--|---------------|--|----------------|
|     |   |                 |   |  | Сангийн яаманд санал хүргүүлж, батлуулсан байна.                   |               | Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 20.6 хувиар нэмэгдсэн байна.   |                |
| 81. | Тусгай сангийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулж, тайлагнана. | 2.100,0         | Дэмжих сангийн зарцуулалтын тайлан              | Жил бүр хуулийн хугацаанд тайлагнадаг.   | Тусгай сангийн тухай хуулийн дагуу зарцуулж, тайлагнасан байна.    | СЭЗГ-СДХ      | Эрүүл мэндийг дэмжих сангийн 2023 оны батлагдсан төсвийн хүрээнд 2023 оны эхний 11 сарын байдлаар 2022 оны 4-р улирал, 2023 оны эхний 3 улирлын хүрээнд шалгарсан төслийн мөнгөн урьдчилгааны тайлан, анхан шатны баримтыг хянан хүлээн авч 1,496,422,1 мянган төгрөгийг олгон, сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээ гарган, Төрийн санд өгч, улирал бүр санхүүгийн тайлан гаргаж ажилласан. 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 77 төслийг сонгон шалгаруулж 1,857.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр ажиллаж байна.  | 100            |
| 82. | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулна.                         | -               | ЗГ-ын хуралдааны шийдвэр                        | Хуулийн төслийн үзэл баримтлалыг Эрүүл мэндийн сайд, ХХААХҮ-ийн сайд баталсан. | Хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | БТГ-СУХ       | <ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/53 дугаар тушаалаар эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг шинэчлэгдэн байгуулагдсан.</li> <li>- Хуулийн төслийн үзэл баримтлалыг Эрүүл мэндийн сайд, Хууль, зүй дотоод хэргийн сайдаар 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр дахин батлуулсан.</li> <li>- Хуулийн төслийг Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2023.07.28-ны өдөр, 2023.09.20-ны өдөр, 2023.11.02-ны өдрийн хурлаар тус тус хэлэлцүүлж, Мэргэжлийн салбар зөвлөл, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг 3 удаа зохион байгуулсан.</li> <li>- Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны 20/А/95 дугаар тушаалаар “Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, чанарын өнөөгийн байдалд хяналт шалгалт, үнэлгээ хийх” ажлын хэсгийг Эрүүл мэндийн яам, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газрын төлөөллийг оролцуулан байгуулж, хяналт шалгалт, үнэлгээ хийсэн.</li> <li>- Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төсөлтэй дагалдах дараах үнэлгээ, тайланг хийгээд байна: <ul style="list-style-type: none"> <li>• Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ – 151 хуудас;</li> <li>• Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан-27 хуудас;</li> <li>• Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцооны тайлан-31 хуудас;</li> <li>• Хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулга-32 хуудас;</li> <li>• Хуулийн төслийн товч танилцуулга-3 хуудас;</li> <li>• Дагалдан гарах хууль-14 хуудас;</li> <li>• Хуулийн төслийн орчуулга-40 хуудас.</li> </ul> </li> </ul> | 90             |
| 83. | ЗГҮАХ 2.1.8.1 Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг нэвтрүүлнэ.                          | -               | Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл нэвтрүүлсэн | -  | Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг эмийн                 | БТГ-СТХ       | Эмийн экспорт, импортын лиценз, эмийн бүртгэл, мэдээллүүдийг цахимжуулах ажлыг ЦХХХЯ, Үндэсний дата төв, И-Монгол академитай хамтран И-Монголиа платформд Эмийн чанар аюулгүй байдал, үйлдвэрлэлтэй холбоотой мэдээллийг авах,   | 30             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж               | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин  | Зорилтот түвшин  | Хариуца х нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|---|---|--|----------------|---|----------------|
|     |   |                 | эмийн сангийн эзлэх хувь                                  |   | сангуудад нэвтрүүлсэн байна.   |                | хянах ажил болон И-Монголиа платформд ХУР системээр дамжуулан "Licemed" програмаас шаардлагатай сервисүүдийг гаргах хөгжүүлэлт хийгдсэн. ЭЭХХЗГ-аас ҮДТ-д DELL сервер тоног төхөөрөмжийг байршуулах гэрээ байгуулан байршуулсан. Татварын ерөнхий газраас эмийн эцсийн үнийн мэдээлэл авахад шаардлагатай виртуал серверийг гаргасан бөгөөд мэдээлэл солилцох боломж бүрдсэн. ЭМСайдын 2023.11.08-ны өдрийн А/391 тоот тушаалын хүрээнд эрүүл мэндийн салбарын салбарын цахим системүүдийн хооронд өгөгдөл солилцох боломжийг бүрдүүлэх, цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд "Лайммед" эмийн бүртгэлийн системээс Гаалийн ерөнхий газар, татварын ерөнхий газар, Худалдан авах ажиллагааны газар зэрэг төрийн бусад байгууллагуудтай өгөгдөл солилцож, хэрэгцээт тоо мэдээ эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц хангамжийн судалгааг бүрдүүлэх боломжийг бүрдүүлэх нэмэлт ажлыг эхлүүлсэн. |                |
| 84. | ЗГҮАХ 2.1.8.2 Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалт хийнэ.                                  | -               | Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан                       | ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээг шинэчилэн баталсан. | Эмийн үнэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна.   | ХШҮДАГ БТГ     | Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 20/А/95 дугаар хамтарсан тушаалаар Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, чанарын өнөөгийн байдалд хяналт шалгалт, үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэгт ЭМЯ, ЭЭХХЗГ, ЭМДЕГ, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Татварын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газрын төлөөлөл орсон. Хяналт шалгалт, үнэлгээнд нийт 368 байгууллагыг хамруулсны 223 эмийн сан, 109 эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага, 19 эмийн үйлдвэр, 12 аймгийн нэгдсэн эмнэлэг, 5 аймгийн БОЭТ байсан. Эмийн үнэ, чанарт хийсэн хяналт шалгалтын дүнг 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Шадар сайд С.Амарсайхан, Эрүүл мэндийн сайдад танилцуулсан. Цаашид шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэй үргэлжлүүлж, эмийн үнийг бууруулахад бодитой санал танилцуулахыг үүрэг болгосон.                | 100            |
| 85. | ЗГҮАХ 2.1.8.3 Эмийн чанар аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | 1,000.0         | Батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/450 дугаар тушаалаар Эмийн чанар аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан.   | Эмийн чанар аюулгүй байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 50 хувьд хүрсэн байна. | ЭТҮГ-ЭТЧАБХ    | Төлөвлөгөөнд нийт 32 үйл ажиллагаа төлөвлөгдсөний 18 үйл ажиллагаа 100%-ийн биелэлттэй, 4 үйл ажиллагаа 90%, 3 үйл ажиллагаа 80%, 3 үйл ажиллагаа 70%, 2 үйл ажиллагаа 60% -аас доош 2 үйл ажиллагаа хугацаа болоогүй хэрэгжиж эхлээгүй байна.  | 100            |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин  | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|--|-----------------|---|---|--|---------------|--|----------------|
| 86. | Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журмыг шинэчилнэ.                                       | -               | Шинэчлэн батлагдсан журам   | -   | Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам шинэчлэн батлагдсан байна.            | ЭТҮГ-ЭТЧАБХ   | Эрүүл мэндийн сайдын 2023 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн А/196 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тушаалыг батлуулан бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.  | 100            |
| 87. | Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспорын лиценз олгох журмыг шинэчилнэ.  | -               | Шинэчлэн батлагдсан журам   | -   | Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспорын лиценз олгох журам шинэчлэн батлагдсан байна.                                       | ЭТҮГ-ЭТЧАБХ   | Монгол Улсын Их хурлын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг хүчингүй болсонтой холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын лиценз олгох журам батлах тухай” А/407 дугаар тушаалыг 2023 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/82 тушаалаар хүчингүй болгож, Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.   | 100            |
| 88. | Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх журмыг шинэчилнэ.  | -               | Шинэчлэн батлагдсан журам   | -   | Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх журам шинэчлэн батлагдсан байна.   | ЭТҮГ-ЭТЧАБХ   | Эрүүл мэндийн сайдын 2023 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн А/67 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан.   | 100            |
| 89. | ЗГҮАХ 2.1.8.4 Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ. | -               | Сүлжээнд нэгдсэн Төр, хувийн хэвшлийн лавлагаа шатлалын эмнэлгүүдийн эзлэх хувь | -   | Төр, хувийн хэвшлийн лавлагаа шатлалын эмнэлгүүд сүлжээнд нэгдэж, нянгийн тэсвэржилтийн талаарх мэдээллээ өгч хэвшсэн байна. | ЭТҮГ-ЭТЧАБХ   | Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэх ажлын хүрээнд WHONET үндэсний сүлжээнд 2023 онд 20 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, 7 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 13 төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хувийн 4 лаборатори зэрэг нийт 46 эрүүл мэндийн байгууллагын нян судлалын лаборатори нэгдэж, сүлжээнд нэгдсэн ЭМБ-ууд нянгийн тэсвэржилтийн талаарх мэдээллээ өгч хэвшсэн. Сар бүр анализ хийх асуудлаар цахим сургалт тогтмол хийгдэж байна.  | 70             |
| 90. | ЗГҮАХ 2.1.8.7 Биобэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ.   | 2,000.0         | Биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэлийн өсөлтийн хувь                           | 2021 онд тэжээлт орчны үйлдвэрлэл 5 хувиар өссөн, биобэлдмэлийн үйлдвэрлэл нийт хүчин чадлын 20 хувьд үйлдвэрлэсэн. | Биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэл 30 хувиар өссөн байна.  | БТГ-СУХ       | Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн Био үйлдвэрлэлийн лаборатори 2023 онд Микробиологийн тэжээлт орчин-148 нэр төрлийн 1309 литр, Нян судлал, химийн шинжилгээнд хэрэглэх будаг урвалж уусмал-129 нэр төрлийн 327 литр, Нян будах, нянгийн биохимийн идэвхт тодорхойлох шинжилгээнд хэрэглэх будаг, урвалж шингээсэн цаасан диск-24 нэр төрлийн 17,330 ширхэг, Оношилгооны бактериофагийн бэлдмэл нэг нэр төрлийн 95 мл тус тус үйлдвэрлэсэн. Үүнээс микробиологийн тэжээлт орчин – 15.8 хувиар, Нян будах, нянгийн биохимийн идэвхт тодорхойлох шинжилгээнд хэрэглэх будаг, урвалж шингээсэн цаасан диск - 2.1 дахин тус өссөн байна. | 70             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|-----|--|-----------------|---|--|---|---------------|---|----------------|
|     |  |                 |   |  |   |               | Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Биобэлдмэлийн үйлдвэр 2023 онд Хүний хэвийн иммуноглобулин 10%, 1.5мл -ыг 1,119 тун/шил үйлдвэрлэж, "Шиллэг эд" биобэлдмэлийн загвар 25 тун/шил, Микробиологийн шинжилгээнд хэрэглэгддэг 12 нэр төрлийн тэжээлт орчны загвар 6л, Гэдэсний бүлгийн бактерийг хурдавчилсан аргаар илрүүлэх 3 төрлийн орчны загвар 1.5л, Гиалуроны хүчлээр баяжуулсан тараг бүтээгдэхүүнийн загвар 34л, Шар сүүгээр баяжуулсан зутаны загвар 7л, гар халдваргүйжүүлэгч загвар бүтээгдэхүүг 1л тус тус гарган авсан.<br>Биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэлийн хэмжээ нь байгууллага болон лабораториудын захиалгатай шууд хамааралтайгаар өсөж, буурч байна. 2023 онд Зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл 15,8 % – 210 % өссөн, зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл 14,3 хувиар буусан байна. Нийлбэр дүнгээр тэжээлт орчны үйлдвэрлэл 17,9 % өсөлттэй, Биобэлдмэлийн үйлдвэрлэл "Хүний хэвийн иммуноглобулин 10%, 1.5мл" -ыг 2022 онд үйлдвэрлээгүй байсан бол 2023 онд биобэлдмэлийн үндсэн 1 удаагийн цувралын 1,119 тун/шил бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн. Мөн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн туршилт судалгаануудыг гүйцэтгэж, 6 загвар бүтээгдэхүүн гарган авсан. |                |
| 91. | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 18.1 Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төсөл боловсруулна.               | -               | ЭЗХЯ-нд хүргүүлсэн санал                                      | Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө батлагдсан.  | ЭЗХЯ-нд хугацаанд нь хүргүүлж хамтран ажилласан байна.              | БТГ-СУХ       | Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны А/167 дугаар тушаалаар батлагдсан "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ, салбарын танилцуулга болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийн "Салбарын үр дүн", "Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн", "Хөтөлбөрийн үр дүн"-гийн шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тус тус боловсруулан хүргүүлсэн. Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний төслийг Эдийн засаг хөгжлийн яамнаас УИХ-д танилцуулан 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан.   | 100            |
| 92. | "Алсын хараа-2050" 2.2.26, ЗГҮАХ 2.1.8.9 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ. | 500.0           | Тогтмол баяжилт хийгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл | 2022 онд эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн программд 585 эрүүл мэндийн байгууллагын 1,157 хэрэглэгч, 27,851 эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгдсэн. | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлд тогтмол баяжилт хийсэн байна. | ЭТҮГ-ЭТҮЧАБ Х | www.heps.hdc.gov.mn програмыг ашиглан Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санд тогтмол баяжилтийг хийж байгаа бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 588 эрүүл мэндийн байгууллагын 1181 хэрэглэгч, 31163 эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгдсэн байна. Үүнээс Эрүүл мэндийн яамны харьяа 17 эрүүл мэндийн байгууллагад 2973, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 22 эрүүл мэндийн байгууллагад 1426, орон нутгийн харьяа 310 эрүүл мэндийн байгууллагад 5597 буюу нийт 349 эрүүл мэндийн байгууллагад арав ба түүнээс дээш жил ашигласан 9996 эмнэлгийн тоног төхөөрөмж байна.   | 70             |

| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|--|-----------------|---|--|--|---------------|--|----------------|
| 93. | ЗГҮАХ 2.1.9.1<br>Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сүлжээг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд бий болгон, чадавх бэхжүүлнэ.                   | 250.0           | Төгсөлтийн дараах сургалтын зөвшөөрөл авсан БОЭТ, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тоо | 2022 оны байдлаар 5 БОЭТ, 1 дүүргийн эмнэлэг төгсөлтийн дараах сургалтын зөвшөөрөл авсан     | 5 БОЭТ, 5 аймаг, дүүргийн эмнэлэгт төгсөлтийн дараах сургалт явуулдаг болсон байна.            | ТЗУГ          | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн сургалтыг 2018 онд Орхон, 2021 онд Дорнод, 2022 онд Ховд, Өмнөговь, Өвөрхангай БОЭТ-д үе шаттай явуулж эхэлсэн. Мөн “Эрчимт эмчилгээний сувилахуй”, “Яаралтай тусламжийн сувилахуй”-н төрөлжсөн мэргэшлийн сургалтыг Орхон БОЭТ-д зохион байгуулж, сургалтын төрөл, чиглэлийг нэмэгдүүлж байна. 2023 онд Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 3-р хурлаар Булган, Хөвсгөл, Сонгинохайрхан, Баянгол, Налайх ДЭМТ, ТТАХНЭ, ЦТЭ зэрэг 7 байгууллагад Ерөнхий мэргэшил судлалаар сургалт эрхлэх зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.  | 100            |
| 94. | ЗГҮАХ 2.1.9.2<br>Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацын тэргүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнг гадаадад урт хугацааны сургалтад хамруулна. | 706.0           | Гадаад улсад урт хугацааны сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо              | 2022 онд урт хугацааны гадаад сургалтад 11 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.                 | Эмнэлзүйн чиглэлээр 15 эмнэлгийн мэргэжилтэнг гадаад улсад урт хугацаагаар суралцуулсан байна. | ТЗУГ          | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/103 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн ажилтны 2023-2024 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл, элсэлтийн хяналтын тоо, сургалтын зардал” баталсан. 2023 онд гадаад сургалтад 190.0 сая төгрөг төсөвлөжээ. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ-өөс гадаад сургалтын захиалга авсан байна. Үүдэл эсийн технологи, нойр булчирхай шилжүүлэн суулгах мэс засал чиглэлээр урт хугацааны сургалтад хамрагдах захиалга авсан байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/185 дугаар тушаалаар баталсан “Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэл, чиглэл”-д эмнэлзүйн сургалтад урт хугацаагаар өндөр хөгжилтэй улсад суралцах тэргүүлэх 11 чиглэлд эмнэлгийн мэргэжилтнийг суралцуулахаар төлөвлөсөн байгаа. Гадаад сургалтын төлөвлөгөөний дагуу БНСУ, БНТУ-д ЕСМО эмчилгээ 3, бөөр үргэлжлэн орлуулах эмчилгээ 1, нойр булчирхай шилжүүлэн суулгах 1, глауком 1, мэдрэлийн мэс заслаар 2, нийт 8 эмнэлгийн мэргэжилтэн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан. Австрали Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Сидней их сургуульд хүүхдийн эмчийн 1 жилийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт ЭХЭМҮТ-ийн 50 эмч цахимаар суралцаж байна. Энэ нь зорилтот түвшиндээ хүрсэн байна. | 100            |
| 95. | ЗГҮАХ 2.1.9.3<br>Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлнэ.   | 1,000.0         | Ажиллан суралцах арга хэмжээнд хамрагдсан эмч, мэргэжилтний тоо                         | 2022 онд 115 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллан суралцах арга хэмжээнд хамрагдсан.           | 100 хүртэлх эмч, мэргэжилтэн ажиллан суралцсан байна.  | ТЗУГ          | 2023-2024 оны хичээлийн жилд ажиллан суралцах хэлбэрээр төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтад 8 эрүүл мэндийн байгууллагын 111 эмнэлгийн мэргэжилтэн суралцсан.  | 100            |
| 96. | Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох, Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд                          | -               | Батлагдсан журам  | Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/492 дугаар тушаалаар | Журмууд шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна.   | БТГ-СУХ       | Эрүүл мэндийн сайдын 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/295 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах, багц цаг тооцох, зөвшөөрлийн гэрчилгээ олгох журам”, хоёрдугаар хавсралтаар “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд зөвшөөрөл олгох журам”, гуравдугаар хавсралтаар “Зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг”, дөрөвдүгээр хавсралтаар “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний загвар”, тавдугаар хавсралтаар “Гадаадын эмнэлгийн мэргэжилтний танилцуулгын маягт”-ыг тус   | 100            |



| Д/д | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|-----|---|-----------------|---|--|---|---------------|--|----------------|
|     | мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журмыг шинэчлэн боловсруулж батлуулна.   |                 |   | зохицуулж байна.   |   |               | тус батлуулсан. Журмыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, бүртгүүлсэн.   |                |
| 97. | “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулна. | -               | Батлагдсан журам  | Эрүүл мэнд спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 97/56 дугаар тушаалаар зохицуулж байна.           | Журам шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна.  | БТГ-СУХ       | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журмыг шинэчлэн боловсруулж, сайдын тушаалын төсөлд газар, хэлтсүүдээс санал авсан. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 337 дугаар тушаалтай уялдуулан гаргах шаардлагын үүднээс хүлээгдсэн. Нөлөөллийн шинжилгээнд тооцоо судалгааг дахин өргөжүүлж хийн тушаалын төсөлд газрын дарга нараар дахин тойруулж санал авч байна.   | 50             |
| 98. | ЗГҮАХ 2.1.9.4 Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг цалин урамшуулалтай уялдуулан эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ.          | -               | 2023 онд шинээр ёс зүй харилцаа хандлагын урамшууллыг олгодог болсон эрүүл мэндийн байгууллагын тоо | эрүүл мэндийн ажилтны үр дүнгийн урамшуулал олгоход “ёс зүй, харьцааны байдал” гэсэн шалгуур орсон | Цалин урамшууллыг ёс зүй харилцаа, хандлагатай уялдуулж олгодог эрүүл мэндийн байгууллагын тоо нэмэгдсэн байна. | БТГ-СУХ       | - Эрүүл мэндийн салбарын цалин хөлс, нийгмийн баталгааны одоогийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудлын талаар НББСШУБХ-нд ЭМС мэдээлэл хийсэн. Эрүүл мэндийн сайдын А/77 тушаалаар батлагдсан ХНХЯ-тай хамтарсан ажлын хэсэг нийт 5 удаа хуралдаж. цалин хөлсийг нэмэгдүүлэх, доод хэмжээг шинэчлэн батлах төсөлд 2023 оны 06 дугаар сарын 05-ны 1а/2593 тоот албан бичгээр санал хүргүүлсэн. Засгийн газрын “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2023 оны 241 тогтоол батлагдан 2023 оны 07 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.<br>- Ур чадварын нэмэгдэл олгох 3 яамдын сайдын хамтарсан тушаалыг төсөлд эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн ур чадвараас гадна харьцаа хандлага, ёс зүйн асуумжийг удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилтан гэсэн ангиллаар үнэлэж олгохоор тусгасан. Тушаалын төсөл яамны газрын дарга нараар тойрч Сайдаар зурагдан батлагдан хамтран батлах санал авахаар 2023 оны 11 дүгээр сарын 30 нд ХНХЯ, СЯ тоот албан бичгээр хүргүүлсэн. | 70             |
| 99. | ЗГҮАХ 2.1.9.5, МУТЖҮЧ 2.2.8 Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ.   | 934.0           | Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь  | ЗГ-аар батлагдсан үндэсний хөтөлбөр хүчингүй болсон.   | Нийгмийн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж, хэрэгжиж эхэлсэн байна.                                | БТГ-СУХ       | - “Эрүүл мэндийн ажилтнуудын нийгмийн баталгааны суурь судалгаа” үндэсний хэмжээний анхны суурь судалгааг ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн. Судалгааны дүнг бодлого боловсруулах шийдвэр гаргах түвшинд өргөнөөр ашиглаж байна.<br>- Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам сэдвээр НББХ-д 2023 оны 5 дугаар сард танилцуулга бэлтгэн хэлэлцүүлсэн.<br>- Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр хөнгөлөлттэй зээлд хамрагдах, цалин урамшууллыг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах хөдөө орон нутагт ажиллах нэмэгдэл олгох зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан хүргүүлсэн.   | 0              |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж                                      | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|---|--|--|---------------|--|----------------|
|      |  |                 |   |  |  |               | - Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааны цогц хөтөлбөрийн төсөл боловсруулж байна.  |                |
| 100. | ЗГҮАХ 2.1.9.6 Сувилахуйн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.                            | 500.0           | Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо, шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн тоо   | Төсөл хэрэгжиж байгаа  | Сургалтыг удирдах сувилагч-сургагч багш 50-аас доошгүй бэлтгэгдсэн байна. Сургалтын 2-3 хөтөлбөр шинэчлэгдсэн байна. | ТЗУГ          | Сувилахуйн эмнэл зүйн сургагч багш бэлтгэх 5 удаагийн сургалтад эрүүл мэндийн 11 байгууллагаас (УНТЭ, УХТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ, ГҮТ, Орхон аймгийн БОЭТ, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, СХДНЭ, ТТАХНЭ) нийт 120 сувилагчийг хамруулж сургалт удирдах багшаар бэлтгэсэн. Сургалтад хамрагдсан 120 сувилагчийн 24-ийг нь улсын төсвийн санхүүжилтээр сургасан. Бусад 96 сувилагчийг эрүүл мэндийн байгууллагын хүсэлтийн дагуу тухайн байгууллагын санхүүжилтээр сургалтад хамруулсан. Настны сувилахуй, насанд хүрэгсдийн сувилахуй төрөлжсөн мэргэшлийн сургалтын 2 хөтөлбөрийг шинээр боловсуулж Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 4-р хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн. Эмнэл зүйн сургагч багшаар 2023 онд нийт 120 сувилагч, 70 эх баригч бэлтгэгдсэн байна. | 100            |
| 101. | ЗГҮАХ 2.1.9.7 Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2021-2024 оны чиглэлийг батлан хэрэгжүүлнэ.                               | 600.0           | Богино хугацааны гадаад сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/185 дугаар тушаалаар гадаад сургалтын тэргүүлэх чиглэл батлагдсан. | 100-аас доошгүй эмнэлгийн мэргэжилтэн богино хугацааны гадаад сургалтад хамрагдсан байна.                            | ТЗУГ          | Гадаад сургалтын тэргүүлэх чиглэлээр болон Монгол улсад эмчлэгдэх боломжгүй өвчний чиглэлээр зочин профессорын багуудыг урьж ажлын байрны 6 удаагийн сургалт зохион байгуулж нийт 853 эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. Үүнээс тэргүүлэх чиглэлийн хүрээнд 493, МУ-д эмчлэгдэх боломжгүй өвчний эмчилгээг нутагшуулахаар 360 эмнэлгийн мэргэжилтэн танхимийн сургалтад хамрагдсан. Тэргүүлэх чиглэлийн хүрээнд БНХАУ, БНСУ, БНТУ, БНЭУ, Австри улсад нийт 20 эмнэлгийн мэргэжилтэн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан. Мөн бүх шатны эрүүл мэндийн байгууллагын 200 сувилагч, эх баригчийг БНСУ, БНХАУ-д, 84 багийн бага эмчийг БНХАУ-д мэргэжил дээшлүүлж гадаад сургалтад хамруулсан.   | 100            |
| 102. | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2026 он хүртэлх төлөвлөлтийг тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээнд тулгуурлан хийнэ. | -               | Хүний нөөцийн 2026 он хүртэлх батлагдсан төлөвлөлт                      | Өмнө гаргасан хүний нөөцийн урт хугацааны тооцоо, төлөвлөлт 2020 онд дуусгавар болсон.             | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2026 он хүртэлх хэрэгцээний тооцоо, төлөвлөлт хийгдсэн байна.                   | БТГ-СУХ       | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн дэлгэрэнгүй судалгааг ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн. Судалгааны төслийг яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн боловч хэлэлцэх асуудлуудын хугацаа багтаагүйтэй холбоотой хойшилсон. Судалгааны дүнд үндэслэн Хүний нөөцийн 2026 он хүртэлх төлөвлөлтийн төсөл өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартын хүрээнд хийгдсэн.   | 30             |
| 103. | Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2023-2024 оны элсэлтийн хяналтын тоог чиглэл                            | -               | Хяналтын тоо баталсан тушаал  | Жил бүр Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулдаг.   | 2022-2023 оны хичээлийн жилийн төгсөлтийн дараах сургалтын   | ТЗУГ          | Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/103 дугаар тушаалаар Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын 2023-2024 оны элсэлтийн хяналтын тоог чиглэл бүрээр батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.  | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин  | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|--|---|--|---------------|--|----------------|
|      | бүрээр тодорхойлж, хянаж батлуулна.   |                 |  |   | хяналтын тоо, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна.   |               |  |                |
| 104. | “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | -               | Батлагдсан тушаал  | 2017 оны тушаалаар зохицуулж байна.   | Журмыг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна.   | ТЗУГ          | “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ыг шинэчлэн боловсруулж бүх газар, хэлтсийн дарга нарт танилцуулагдан Эрүүл мэндийн сайд руу оруулахад бэлэн болгосон боловч ЭМХТ-өөс журмын төслийг дахин шинэчлэх саналыг 2023 оны 8 дугаар сард ирүүлсэн. Энэ дагуу журмын төслийг дахин шинээр боловсруулаад байна.  | 50             |
| 105. | ЗГҮАХ 2.1.11.2 Ховд аймгийн БОЭТ-ийн барилгын өргөтгөл барина.  | 5,137.5         | Барилгын өргөтгөлийн ажлын гүйцэтгэлийн хувь   | -   | Барилгын өргөтгөлийн ажлын гүйцэтгэл 30 хувь байна.  | СЭЗГ-ХОХ      | Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл хийгдэнэ. Уг төсөл нь 2 үе шаттай бөгөөд I үе шатны хүрээнд “Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл”-ийн зургийн зөвлөх компани “Татах хүч” ХХК шалгарч, эхний ээлжинд Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн зураг төсвийг боловсруулж, хүлээлгэн өгсөн. “International Medical Center” ХХК Олон улсын зөвлөх фирм Хүн амын Эрүүл мэндийн хэрэгцээ, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, БОЭТ-ийн нөхцөл байдлын үнэлгээ, шинэ өргөтгөлийн төлөвлөлт хийгдсэн.  | 0              |
| 106. | ЗГҮАХ 2.1.12.2 Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжүүлэх.   | 27.0            | Шинээр аудит эрсдлийн үнэлгээ хийсэн байгууллагын тоо, ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулсан байгууллагын тоо | 11 ус хангагч байгууллагын УАБТ-д хөндлөнгийн аудит хийж УАБТ боловсруулах сургалт зохион байгуулсан. | 2 аймагт аудит, 4 жижиг суурин газарт УАБТ-г боловсруулах, УАБТ-ний хэрэгжилт 50 хувиас доош байгаа 2 хангагч байгууллагад талбарын сургалт, усны чанар, аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийсэн байна. | НЭМГ-УСХЗХ    | Усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит хийх, сонгогдсон сумын ус хангамжийн тогтолцоонд эрсдэлийн үнэлгээ хийх, төлөвлөгөөний төслийг боловсруулах, ус хангагч байгууллагын ажилчдад сургалт зохион байгуулах үйл ажиллагааг ДЭМБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс 09 дүгээр сарын 08-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө сум, Өвөрхангай аймгийн Уянга, Хархорин суманд зохион байгуулж, усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хөндлөнгийн аудитыг хийж тайланг эцэслэн Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулан ДЭМБ-д хүргүүлсэн. 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1а/5562 тоот албан бичгээр Өвөрхангай аймгийн Засаг дарга, тус аймгийн Онги ус суваг ОНӨААТҮГ болон Сэлэнгэ аймгийн Засаг дарга, Сэлэнгэ цэнгэг ус ОНӨААТҮГ-д аудитын тайлан, зөвлөмжийг тус тус хүргүүлсэн. | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин  | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|--|---|--|---------------|---|----------------|
| 107. | ЗГҮАХ 2.1.13.1<br>Өрхийн эрүүл мэндийн төвийн эрх зүйн баримт бичигт шинэчлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг туршиж, оновчтой хэлбэрүүдийг сонгон нэвтрүүлнэ. | -               | Өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбар турших шийдвэр        | 2017, 2019 онд батлагдсан эрх зүйн баримт бичгийг мөрдөж байна. | Өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбарыг туршиж эхэлсэн байна.                             | БТГ-СУХ       | ӨЭМТ-ийн эрхзүйн баримт бичгийг боловсронгуй болгох чиглэлээр ажлын хэсэгт хамтран ажиллаж Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/283 дугаар тушаалаар:<br>- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам,<br>- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт<br>- Анхан шатны тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тус тус баталсан.<br>ӨЭМТ-ийн дүрэм, гурвалсан гэрээ байгуулах журам, гэрээний загвар, шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулан санал авах шатанд байна.  | 50             |
| 108. | Эрүүл мэндийн технологи-Олон улсын экспо -2023 үзэсгэлэн зохион байгуулна.   | -               | Зохион байгуулагдсан үзэсгэлэн                             | Ерөнхий сайдын албан даалгавар гарсан                           | Үзэсгэлэн зохион байгуулсан байна.   | БТГ-СУХ       | МУ-ын Засгийн газраас 2023-2024 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Монгол Улсыг гадаадад сурталчлан таниулах, аялал жуулчлалын салбарын үйл ажиллагааг сэргээх, эдийн засгийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн 22 арга хэмжээг зохион байгуулах нэгдсэн хуанлийг “WELCOME TO MONGOLIA-EVENT 2023” баталсан. Энэхүү хуанлид эрүүл мэндийн салбараас “Эрүүл мэндийн технологи” Олон улсын экспо-2023-ыг зохион байгуулахаар туссан.<br>“Эрүүл мэндийн технологи” Олон улсын экспог 2023 оны 09 дүгээр 22-24-ны өдрүүдэд “Мишээл экспо” Олон улсын худалдааны төвд амжилттай зохион байгуулсан бөгөөд 30 улс, орны төлөөлөгчийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 19 ханган нийлүүлэх байгууллага, Монгол Улсын төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүд 16, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж ханган нийлүүлэх байгууллага 49 тус тус оролцож өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ таниулсан арга хэмжээ болсон. Экспогийн үеэр ойролцоогоор 1,2 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдэж, 100 гаруй гэрээ хэлцэл хийгдэж, 500 орчим бизнес уулзалт зохион байгуулагдаж, 12,000 орчим иргэд үзэж сонирхсон байна. “Эрүүл мэндийн технологи” Олон улсын экспо-2023-ын тайланг Эрүүл мэндийн дэд сайдын 2023.11.23-ны өдрийн 16/5275 тоот албан бичгээр Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн. | 100            |
| 109. | Төр хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэл боловсруулна.  | -               | Батлагдсан төр хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэл | Тэргүүлэх чиглэлийн хугацаа 2020 онд дууссан.                   | Төр хувийн хэвшлийн тэргүүлэх чиглэлийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | БТГ-СУХ       | Эрүүл мэндийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/222 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн салбарт 2023-2026 онд хэрэгжүүлэх төр,хувийн хэвшлийн түншлэлийн тэргүүлэх чиглэл”-ийг батлуулан веб сайтад байршуулсан.   | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж               | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин  | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|--|---|---|---------------|--|----------------|
| 110. | ЭМЯ-ны албан хаагчдын нийгмийн хамгааллын хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлнэ.                           | -               | Батлагдсан төлөвлөгөө<br><br>2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн хувь | -   | Хөтөлбөр батлагдаж, 2023 онд төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжсэн байна.          | ТЗУГ          | ЭМЯ-ны албан хаагчдын "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг боловсруулж, яамны аппаратын хурлаар төслийг хэлэлцүүлэн, сургалтын хэрэгцээ, ажлын байрны нөхцөл, хангамж, албан хаагчдын хүүхдийн судалгаа, орон байрны судалгаа авсан. Хөтөлбөрийг ТНБД-ын 2023 оны А/121 дүгээр тушаалаар батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний биелэлт 95% байна.<br>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд:<br>-2023 оны эхний хагас жил, 2023 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээний дүнд төрийн захиргааны албан хаагчдад 60-100% урамшуулал олгосон.<br>-2023 оны Засгийн газрын "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган, тцалин шинэчлэх тушаал гарган, ХНУМС-д нийт албан хаагчдын мэдээллийг шинэчилсэн.<br>-Төрийн үйлчилгээний албан хаагчдын улирлын тайлангийн үнэлгээний мөнгөн урамшуулал олгож байна.<br>-Албан хаагчдын албан тушаалын зэрэг дэвийг нэмэгдлийг 2 удаа салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, ЭМ-ийн сайдын тушаал гаргаж, ХНУМТ системд оруулсан.<br>-Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг 15 хувиар нэмэгдүүлсэн.<br>-Хөдөлмөрийн тухай хууль, дотоод журмын дагуу ажлын богиносгосон цагаар болон зайнаас ажиллах албан хаагчдын нэрс, хуваарийг батлах тушаал гаргав. | 90             |
| 111. | Салбарын 3 талт хэлэлцээрийн хэрэгжилтийг дүгнэж шинэчлэн батална.                                  | -               | Хэлэлцээрийн хэрэгжилтийн тайлан<br><br>Шинээр батлагдсан 3 талт хэлэлцээр         | 2021-2023 оны хэлэлцээр хэрэгжиж байна                                  | Хэлэлцээрийг дүгнэж, шинэчлэн баталсан байна.                                 | ТЗУГ          | Хэлэлцээрийн 2022 оны хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулан, биелэлтийг 77.4 хувиар 3 тал тогтож дүгнэсэн. МЭМАҮЭХ-оос 2023 оны хэлэлцээрт 4 асуудлаар нэмэлт, өөрлөлт оруулах саналыг ирүүлсэнийг 3 тал зөвшилцөн эцэслэж 2023 оны 6 дугаар сарын 26-ны өдөр баталгаажуулан НХХЯ-нд бүртгүүлсэн.   | 100            |
| 112. | МУХТЖҮЧ-2.2.1 БЗДХ, ХДХВ, ДОХ-ын тусламж үйлчилгээг зохион байгуулах журмыг боловсруулж, батлуулах. | -               | Эрүүл мэндийн сайдын тушаал  | 2017 онд Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан журмыг мөрдөж байна. | Журмыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | НЭМГ-ХӨХ      | Эрүүл мэндийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн А/133 дугаар тушаалаар "БЗДХ, ХДХВ, ДОХ-ын халдвараас сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах журам, заавар"-ыг батлуулсан.   | 100            |
| 113. | МУХТЖҮЧ-2.2.1 ЭМССТ 1.16 Шуурхай удирдлагын нэгж байгуулах.   | -               | Байгуулагдсан шуурхай удирдлагын нэгжийн тоо                                       | 4 аймаг, 4 байгууллагад Шуурхай удирдлагын нэгж байгуулсан.             | Шуурхай удирдлагын 14 нэгжийг байгуулсан байна.                               | НЭМГ-ХӨХ      | ДЭМБ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчийн газраас Үндэсний төвүүдийн Шуурхай удирдлагын нэгжийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бэхжүүлэх зорилгоор шинээр Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Сүхбаатар, Увс гэсэн 13 аймагт Шуурхай удирдлагын нэгж байгуулахад шаардлагатай SMART интерактив дэлгэц, суурин болон зөөврийн компьютер, хувилагч, хэвлэгч машин, зургийн аппарат, Өвөрхангай, Ховд аймгийн бүх сумдад суурин болон зөөврийн компьютер зэрэг 18 нэр төрлийн  | 90             |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин  | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|--|---|---|---------------|---|----------------|
|      |  |                 |  |   |   |               | 217 ширхэг 915,700,500 сая төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/60 дугаар тушаалаар хуваарилж, Шуурхай удирдлагын нэгжийн үйл ажиллагааг явуулж байна.  |                |
| 114. | МУХТЖҮЧ-2.2.2 Амаржих газар, төрөх тасгуудад гэр бүлд түшиглэсэн "Имж эх" асаргааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана                         | -               | Батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу бэлтгэгдсэн сургагч багшийн тоо                             | -   | Үндэсний төв, Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн төрөх тасгийн эмч, эх баригч нарт сургалт зохион байгуулж, сургагч багш бэлтгэгдсэн байна. | НЭМГ-ХБӨХ     | Үндэсний хэмжээнд "Имж эх" асаргааг хэрэгжүүлэх зорилгоор 2017 онд бэлтгэгдсэн үндэсний сургагч багш нар мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Өргөө, Хүрээ, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн нийт 10 нярайн эмч, сувилагчийг үндэсний сургагч багшаар 2023 оны 05 дугаар сард дутуу болон бага жинтэй төрсөн нярайн тусламжид "Имж эх" асаргааг өргөжүүлэхээр бэлтгэсэн. Аймгуудын нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмч, сувилагч нарыг "Имж эх" асаргааны аргад сургахаар ДЭМБ-ын санхүүжилтэйгээр ЭХЭМҮТ-тэй хамтран удирдамж батлуулсан. Удирдамжийн дагуу 12 дугаар сард сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажил хангагдсан. | 100            |
| 115. | МУХТЖҮЧ 2.2.2 Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, халдвараас сэргийлэх үйл ажиллагааны нэгдсэн удирдамж боловсруулах. | -               | Батлагдсан удирдамж  |   | Удирдамж Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан байна.   | НЭМГ-УСХЗХ    | Нүүр амны тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, халдвараас сэргийлэх үйл ажиллагааны нэгдсэн удирдамж"-ийн төслийг боловсруулж, төслийн хэлэлцүүлгийг нийслэлд 1 удаа, орон нутагт 3 удаа зохион байгуулж шүдний эмч, мэргэжилтнүүдэд танилцуулж, санал авч тусгасан. Төслийг эцэслэн боловсруулж, ЭМЯ-ны удирдлагуудад тойрох хуудсаар танилцуулж, санал авч байна.   | 50             |
| 116. | ЗГҮАХ 2.1.14.1, МУТЖҮЧ-2.2 Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно.                            | 5,000.0         | Шинээр орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болсон сумын эрүүл мэндийн төвийн тоо | 3 аймгийн нийт 15 сумын эрүүл мэндийн төв сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон. | 60 сумын эрүүл мэндийн төвийг орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна.                                     | СЭЗГ-ХОХ      | Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгох ажлын хүрээнд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд Улаанбаатар хотод 5 өрхийн эрүүл мэндийн төв, орон нутагт 55 сумын эрүүл мэндийн төвийн хөрөнгө оруулалт тусгагдсан. Үүнээс 4 өрхийн эрүүл мэндийн төв, 33 сумын эрүүл мэндийн төв орчин үеийн ариун цэврийн байгууламжтайгаар ашиглалтад орсон. Үлдсэн ажлуудын хөрөнгө нь он дамжин тавигдсан тул 2024 онд ашиглалтад орно.   | 30             |
| 117. | Хүний эрхийн асуудлаар Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулна.  | -               | Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүний эрхийн чиглэлээр туссан заалт       | -   | Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүний эрхийн заалт орсон байна.  | ТЗУГ          | Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Хүний эрхийн үндэсний форум болон Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл, Хүний эрхийн Үндэсний комитсоос эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээ, судалгааны баримт бичгүүдэд тусгасан зөвлөмжүүдэд үндэслэн салбарын хүний эрхийн асуудлыг тус хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгахаар судалж байна.  | 0              |
| 118. | МУТЖҮЧ-2.2.3 УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоол Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийг боловсруулна.                              | -               | ЗГ-ын хуралдааны шийдвэр   | -   | Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.  | ЭТҮГ-АЛШТХ    | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/113 дугаар тушаалаар ерөнхий ажлын хэсэг, Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/37 дугаар тушаалаар дэд ажлын хэсэг тус тус байгуулагдан хуулийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлон, уг хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулан, ажлын хэсгийн саналыг тусган, эцэслэн боловсруулж, газар, хэлтсийн дарга нараас санал авахад бэлэн болсон.  | 50             |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|--|--------------|--|---------------|--|----------------|
|      |   |                 |  |              |  |               | УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгийн “Чиглэл хүргүүлэх тухай” 2023.11.28-ны өдрийн УИХ-03/9581 тоот албан бичгийн хүрээнд хуулийн төслийг УИХ-ын гишүүний бүрэн эрхийн дагуу бие даан санаачлан боловсруулж батлуулна.   |                |
| 119. | УИХ-ын 2021 оны 12 дугаар тогтоол Цусны донорын тухай хуулийн төслийг боловсруулна.   | -               | ЗГ-ын хуралдааны шийдвэр   | -            | Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.                                       | ЭТҮГ-ЭТЧАБХ   | УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгийн “Чиглэл хүргүүлэх тухай” 2023.11.28-ны өдрийн УИХ-03/9581 тоот албан бичгийн хүрээнд хуулийн төслийг УИХ-ын гишүүний бүрэн эрхийн дагуу бие даан санаачлан боловсруулж батлуулна.   | 0              |
| 120. | МУТЖҮЧ 2.2.2 Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн арга хэмжээний төлөвлөгөө (2023-2026) боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна. | -               | Батлагдсан төлөвлөгөө<br><br>2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн хувь | -            | Арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж, 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | ЭТҮГ-АЛШТХ    | Эрүүл мэндийн яамны 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн Удирдлагын зөвлөлийн хуралд Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламжийн арга хэмжээний төлөвлөгөө (2023-2026)- г хэлэлцүүлж, удирдлагын зөвлөлөөс “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн арга хэмжээний төлөвлөгөө 2021-2024”-нд нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний талаар дэлгэрэнгүй тусгагдсан тул уг төлөвлөгөөг батлах шаардлагагүй гэсэн шийдвэр гарсан.   | 50             |
| 121. | Сувилахуйн тусламж, үйлчилгээний арга хэмжээний төлөвлөгөө (2023-2026) боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна.                          | -               | Батлагдсан төлөвлөгөө<br><br>2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн хувь | -            | Арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж, 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | ЭТҮГ-АЛШТХ    | “Сувилагчаа сонсоё” арга хэмжээн дээр гарсан санал, хүсэлтийг үндэслэн нэг жилийн төлөвлөгөө болгон батлуулах чиглэлийн дагуу “2023-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”- г Эрүүл мэндийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/230 дугаар тушаалар 17 арга хэмжээг батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 80.0 хувь. (100 хувь -9, 90 хувь -2, 70 хувь -4, эхлээгүй -2 ажил байна).  | 70             |
| 122. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартуудыг шинэчлэн боловсруулж, батлуулна.  | -               | Шинэчлэн батлагдсан стандартын тоо   | -            | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шаардлагатай стандартуудыг шинэчлэн боловсруулна.        | ЭТҮГ-АЛШТХ    | Стандарт, хэмжил зүйн газрын Эрүүл мэнд, эмнэлгийн стандартчиллын техникийн хорооны 2023.06.14-ний өдрийн хурлаар 3 стандартын төслийг хэлэлцүүлэн батлуулсан.Үүнд:<br>1.Титэм судасны компьютерт томографийн оношилгооны стандарт 7016:2023<br>2.Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага 7014:2023<br>3.Эмгэг судлалын түгээмэл үйлдлийн стандарт 7015:2023.<br>“Эх барих, эмэгтэйчүүд судлал”-ын 47 түгээмэл үйлдлийн стандартын төслийг боловсруулж, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 5/5532 дугаар албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт батлуулахаар хүргүүлээд байна.                            | 100            |
| 123. | Эмчилгээ, оношилгооны эмнэлзүйн зааврыг боловсруулан батлуулна.   | -               | Шинээр болон шинэчлэн батлагдсан эмнэлзүйн зааврын тоо                             | -            | Шаардлагатай эмнэлзүйн заавруудыг шинээр болон шинэчлэн боловсруулж батлуулсан байна.        | ЭТҮГ-АЛШТХ    | Нийт 7 эмнэлзүйн зааврыг боловсруулж Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулан, эрүүл мэндийн яамны цахим хуудсанд байршуулсан болно. Үүнд:<br>- Зүрхний архаг дутмагшлын оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн заавар, Эрүүл мэндийн сайдын А/192 дугаар тушаал;<br>- Гол судасны хавхлагын дутагдал, нарийслын оношилгоо, эмчилгээний заавар, Эрүүл мэндийн сайдын А/193 дугаар;<br>- Хоёр хавтаст хавхлагын дутагдал, нарийслын оношилгоо, эмчилгээний заавар, Эрүүл мэндийн сайдын А/194 дүгээр тушаал<br>- Нярайн шарлалтын үеийн оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн заавар, Эрүүл мэндийн сайдын А/93 дугаар тушаал; | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                        | Суурь түвшин                                    | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|---|---|---|---------------|---|----------------|
|      |   |                 |   |   |   |               | Тууралтат халдварт өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн бүлэг заавар Эрүүл мэндийн сайдын А/445 дугаар тушаал.   |                |
| 124. | Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний соёлтой холбоотой заавар/ удирдамжийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна. | -               | Батлагдсан заавар/ удирдамж             | -   | Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний соёлтой холбоотой заавар/ удирдамжийг батлуулж, хэрэгжилтийг арга зүйгээр хангасан байна. | ЭТҮГ          | Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын гадна, дотно орчин, хаягжилт, үйлчлүүлэгчийг дэмжих нэгж, ажиллах албан хаагчдад тавигдах шаардлага, харилцаа хандлагын зарчмыг тусгасан “Эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 үндэсний стандартыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн С/31 дугаар тушаалаар батлуулсан. Стандартыг эрүүл мэндийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх 90 сургагч багш бэлтгэсэн. Сургагч багш нар нь стандартын хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах, эрүүл мэндийн ажилтнуудад танилцуулах, сурталчлах, сургалт зохион байгуулахаас гадна харьяа аймаг, дүүрэг, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанд холбогдох мэргэжлийн нийгэмлэг, холбоотой хамтран сургалт зохион байгуулсан. | 100            |
| 125. | Эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх журмыг шинэчлэн батлуулна.                                  | -               | Шинэчлэгдэн батлагдсан журам            | -   | Журам шинэчлэгдэн батлагдаж, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.  | ЭТҮГ-ЭТЧАБХ   | ЭМС-ын 2021 оны “Журам батлах тухай” А/813 дугаар тушаалыг шинэчлэх ажлын хүрээнд ЭМЯ-ны удирдлагууд болон мэргэжлийн салбар зөвлөл, харьяа эрүүл мэндийн байгууллагуудтай 4-5 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Мэргэжлийн салбар зөвлөл, төрөлжсөн мэргэшлийн төв, аймаг нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудад албан тоот хүргүүлэн саналыг авч нэгтгэж, тушаалыг эцэслэн боловсруулсан. Дотоод журмын дагуу газрын дарга нараас санал авч байна.  | 30             |
| 126. | Төрийн сангийн үйл ажиллагаанд зарлагын модулыг цахимжуулах бэлтгэл ажлыг ханган үе шаттайгаар нэвтрүүлнэ.                          | -               | Цахимаар хийгдсэн гүйлгээний эзлэх хувь | Цалингийн гүйлгээ цахим болсон байна.           | Төрийн сангийн зарлагын гүйлгээ цахим болсон байна.   | СЭЗГ-СДХ      | Төрийн сангийн удирдлагын цахим систем нэвтрүүлэх үйл ажиллагааны Эрхийн бүртгэлийн сан системд Эрүүл мэндийн яам болон харьяа 24 байгууллагыг бүртгэн, үндсэн болон нэмэлт санхүүжилтийн дансуудыг холбож, байгууллагын удирдах эрх бүхий албан тушаалтнуудад портал системд зарлагын гүйлгээ хийх эрхийг олгож, зарлагын модуль цахимжих бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилласан. Цахим Монгол Улс бодлогын хүрээнд Төрийн сангийн үйл ажиллагааг цахимжуулах зорилтын хүрээнд уламжлалт цаасаар хийгдэж байсан зарлагын гүйлгээг 2023.04.24-ний өдрөөс эхлэн цахимжуулж эхэлсэн. Эрүүл мэндийн яам болон харьяа 24 байгууллага, Эрүүл мэндийг дэмжих сан бүрэн цахим системд нэвтэрсэн. Эрүүл мэндийн даатгалын сан 12 сарын 01-ний өдрөөс эхлэн цахим системд нэвтэрч эхэлсэн. Нийт цахимаар 44086 гүйлгээ хийсэн байна.   | 100            |
| 127. | Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн сангийн программыг ашиглаж яамны удирдлагыг тогтмол   | -               | Цалингийн нэгдсэн сангийн тайлан        | Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн сангийн | Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн сангийн программын ашиглалт   | СЭЗГ-СДХ      | 1. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/77 дугаар тушаалаар ХНХЯ-тай хамтарсан ажлын хэсгийн хүрээнд Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн сангийн программаас 2022 оны бүтэн жил, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 443 анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын цалингийн дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж, Засгийн газрын  | 100            |



| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин              | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|---|---------------------------|---|---------------|--|----------------|
|      | мэдээллээр ханган ажиллана.  |                 |   | программ бүрэн нэвтэрсэн. | сайжирсан байна.  |               | 107 болон 488 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнд дүнд шинжилгээ хийж газар, хэлтсийн дарга нар болон БТГ-ын дарга, холбогдох мэргэжилтнийг мэдээллээр хангаж хамтран ажилласан бөгөөд Засгийн газрын 2023 оны үндсэн цалин шинэчлэн тогтоох тухай 241 дүгээр тогтоол гарсан.<br>2. ТАЦНС программын хэрэгжилтийг хангуулахаар ЭМБ-уудад 7/3549 дүгээр албан бичгээр чиглэл өгч алдаатай оруулсан мэдээлэлд тухай бүр засвар оруулах ажлыг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажилласан.<br>3. Мөн 2024 онд ЭМД-аас санхүүжих тусламж үйлчилгээний тариф шинэчлэх, мөн 2024 оны 04 дүгээр сараас ТҮ-зэрэглэлийн цалин 20%, ТҮЭМ зэрэглэлийн цалин 10%, нэмэгдүүлэх мөн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж буй эмч, сувилагч, тусгай мэргэжилтэнд олгодог байсан нэг удаагийн тэтгэмжийг суманд ТҮ, ТҮЭМ зэрэглэл харгалзахгүй 40%, аймагт 20%, олгох тооцооллыг хийж газар хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтнүүдийг мэдээллээр хангаж хамтран ажилласан. |                |
| 128. | ЗГҮАХ 2.1.13.3 Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгоно. | 500.0           | ТББ-аас эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид хийсэн үнэлгээний тайлан | -                         | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хөндлөнгийн төрийн бус байгууллагаар үнэлгээ хийгдсэн байна. | ЭТҮГ-АЛШТХ    | Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгох зорилгоор ЭМ-ийн сайдын 2023 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн А/283 тушаалын хяналт, үнэлгээ хэсэгт "6.1.1-д Мэдээллийн ил тод байдал, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн opendata.1313.mn цахим хуудсанд байршуулсан мэдээлэл"-д тусгасан.<br>Одоо тус програмд 224 ӨЭМТ, 337 СЭМТ, тосгоны ЭМТ-ийн хүний нөөц, санхүүгийн мэдээллийг ил тод байршуулж, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг хөндлөнгөөс үнэлэх боломжийг бүрдүүлсэн.  | 100            |
| 129. | МУХТЖҮЧ 2.2.7 Уламжлалт анагаах ухааны эмийн бүртгэлийн эрхзүйн орчинг шинэчилнэ.  | -               | Шинэчлэгдэн батлагдсан журам  | -                         | Уламжлалт анагаах ухааны эмийн бүртгэлийн журам шинэчлэгдэн батлагдсан байна.                   | ЭТҮГ-УАУХ     | Эмийн бүртгэлийн журмыг шинэчлэх ажлын хэсэгт ажиллаж, уламжлалт эмийн бүртгэлийн зохицуулалт хэсгийг боловсруулан 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 5-3/2038 дугаар албан бичгээр ЭЭХХЗГ-т хүргүүлсэн.  | 30             |
| 130. | Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх арга хэмжээний (2023-2026) төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна.  | -               | Батлагдсан төлөвлөгөө<br><br>2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн хувь                    | -                         | Арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж, 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.    | ЭТҮГ-УАУХ     | Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх арга хэмжээний /2023-2026/ төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн удирдамж батлан нөхцөл байдлын үнэлгээ хийж, төлөвлөгөөнд тусгах зорилго, үйл ажиллагааг тодорхойлоход чиглэн Увс, Хэнтий, Өмнөговь аймгуудад зохион байгуулагдсан баруун, зүүн болон говийн бүсийн чуулга, уулзалтад хэлэлцүүлж санал авч төслийг боловсруулж байна.   | 0              |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|--|--------------|--|---------------|--|----------------|
| 131. | Өлсгөлөн зарлахад харшлах өвчний жагсаалт, өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зааврыг боловсруулж батлуулна.                        | -               | Батлагдсан тушаал  | -            | Зааврыг боловсруулж батлуулсан байна.  | ЭТҮГ-АЛШТХ    | “Өлсгөлөн зарлахад харшлах өвчний жагсаалт, өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх заавар”-ын төсөл боловсруулж, албан бичгээр холбогдох салбар зөвлөлүүд, аймаг, нийслэлийн ЭМГ-аас саналыг авч, нэгтгэн, газрын дарга нараас санал авч байна.   | 30             |
| 132. | ЭМССТ 3.3 Хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг бууруулж, чанар, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангана. | -               | Батлагдсан төлөвлөгөө<br>2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн хувь | -            | Арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж, 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | ЭТҮГ-АЛШТХ    | Хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг бууруулж, чанар, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөөний төслийг боловсруулж байна.  | 0              |
| 133. | Эрүүл насжилтыг дэмжих арга хэмжээний (2023-2026) төлөвлөгөөг боловсруулж батлуулна.   | -               | Батлагдсан төлөвлөгөө<br>2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн хувь | -            | Арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж, 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | ЭТҮГ-АЛШТХ    | Эрүүл насжилтын үйл ажиллагааны 2024-2028 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, Эмнэлгийн урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар боловсруулах ажлын хэсгийг байгуулж, мэдээлэл солилцох уулзалт, хурлыг ЭМЯ, ЭМХТ, ЭМДЕГ болон харьяа эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн салбар зөвлөл, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбооны төлөөллийг оролцуулан 5 удаа зохион байгуулж төлөвлөгөөний төслийг хэлэлцсэн. Эрүүл мэнд, Хөдөлмөр нийгмийн хамгаалал, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар ажиллаж байна. | 0              |
| 134. | Донороос эс эд, эрхтэн шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна.                                  | -               | ЗГ-ын тогтоолоор батлагдсан журам  | -            | Журмыг шинэчлэн боловсруулж, ЗГ-ын тогтоолоор батлуулсан байна.                              | ЭТҮГ-АЛШТХ    | Донороос эс, эд, эрхтэн шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/198 дугаар тушаалаар батлуулан, ЭМБ-дад хүргүүлсэн. Нэмэлт өөрчлөлт оруулахаар боловсруулж байна.  | 100            |
| 135. | Донорт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлттэй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журмыг шинэчилнэ.                        | -               | Шинэчлэн батлагдсан журам  | -            | Журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна.  | ЭТҮГ-ЭТЧАБХ   | Донорт эмнэлгийн тусламж, үйлчилгээг хөнгөлттэй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журмын төслийг шинэчлэн боловсруулж, батлуулахаар ЭМЯ-ны газар, хэлтэс /Хуулийн хэлтэс/-ээс санал авч байна.   | 30             |
| 136. | Эрүүл мэндийн яамны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан батлуулна.   | -               | Батлагдсан төлөвлөгөө  | -            | Эрүүл мэндийн яамны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан                              | ЭТҮГ-АЛШТХ    | Эрүүл мэндийн яамны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан, Төрийн нарийн бичгийн даргаар 2023 оны 01 сарын 13-ны өдөр батлуулсан.  | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                  | Суурь түвшин                    | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|--|--|-----------------|-----------------------------------|---------------------------------|--|---------------|---|----------------|
|  |  |                 |                                   |                                 | батлуулсан байна.  |               |   |                |
| 2.3. Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ. |  |                 |                                   |                                 |  |               |   |                |
| 137.   | ЗГҮАХ 2.3.1.1 Яслийн үйлчилгээ нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлэхэд БШУЯ-тай хамтран ажиллах.                  | -               | Хүргүүлсэн санал                  | Төсөлд 1 удаа санал хүргүүлсэн. | Холбогдох чиглэлээр гарсан эрх зүйн баримт бичгүүдэд санал хүргүүлсэн байна.   | НЭМГ-УСХЗХ    | Яслийн үндэсний тогтолцоо, хүүхэд харах үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд энэ асуудлыг тусган баталж, хуулийн төсөлд эдгээр үйлчилгээнд хамрагдах нас болон бусад зохицуулалтыг тусган боловсруулсан. Яслийн нэг бүлэгт 1-2 насны 15 хүүхэд, 1 багш, 2 туслах багш ажиллуулахаар тооцсон бөгөөд цаашид яслийн орчин, хүний нөөцөд тавигдах нийтлэг шаардлагыг хангасан төрийн бус өмчийн цэцэрлэгт нэг хичээлийн жилд хамгийн багадаа яслийн насны 8000 хүүхэд хүлээн авч, ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй эхчүүдэд энэ үйлчилгээг сонгон хүүхдээ хамруулах боломж бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгохоор төлөвлөн ажиллаж байна.<br>“Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөө батлах тухай” бодлогын баримт бичгийг БШУЯ, ХНХЯ-тай хамтран боловсруулж, тус тушаалын төсөлд 05 дугаар сарын 16-ны өдөр цахимаар санал хүргүүлэн хамтран ажиллаж, улмаар 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн БШУС, ЭМС, ХНХС-ын А/236, А/189, А/80 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан. | 100            |
| 138.   | Донороос эс эд, эрхтэн шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулна.<br><b>134-тэй давхардсан</b> | -               | ЗГ-ын тогтоолоор батлагдсан журам | -                               | Донороос эс эд, эрхтэн шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулсан байна. | ЭТҮГ-АЛШТХ    | Донороос эс, эд, эрхтэн шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/198 дугаар тушаалаар батлуулан, ЭМБ-уудад албан бичгээр хүргүүлсэн. Нэмэлт өөрчлөлт оруулахаар боловсруулж байна.   | 100            |
| 139.   | ЗГҮАХ 2.3.2.6 Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, салбар дунд хамтын ажиллагааг бэхжүүлэх.              | -               | Хүргүүлсэн санал                  | -                               | Үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал хүргүүлсэн байна.   | НЭМГ-УСХЗХ    | “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөө батлах тухай” бодлогын баримт бичгийг БШУЯ, ХНХЯ-тай хамтран боловсруулж тус тушаалын төсөлд 5 дугаар сарын 16-ны өдөр цахимаар санал хүргүүлэн хамтран ажиллаж улмаар 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн БШУ, ЭМ, ХНХС-ын сайдын А/236, А/189, А/80 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан. Энэхүү бодлогын баримт бичгийг танилцуулах, бусад салбарын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Бага насны хүүхдийн цогц хөгжил: Олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт үндэсний чуулганыг БШУЯ манлайлан ЭМЯ, ХНХЯ хамтран 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Тус чуулганаар бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих чухал асуудлуудыг хэлэлцэж, бага насны хүүхдийн хөгжилд хамтран ажиллах “Бага насны хүүхдийн хөгжлийн сүлжээ”-нд төрийн болон   | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|---|--|--|---------------|--|----------------|
|      |   |                 |   |  |  |               | төрийн бус байгууллага, холбоо нийгэмлэг зэрэг 25 байгууллага нэгдэж тус сүлжээний гишүүнчлэлийг албан ёсоор батлав.   |                |
| 140. | ЗГҮАХ 2.3.4.6<br>МУХТ 2.3.7<br>Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох. | -               | Хүргүүлсэн санал  | Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах журам батлагдсан. | Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд холбогдох чиг үүргийн дагуу оролцсон байна.   | НЭМГ-УСХЗХ    | Хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх туршилтын үйл ажиллагааг зохион байгуулах, эдгээр хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд нөхөн сэргээх, сэргээн засах сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, БШУЯ, ЭМЯ, ХНХЯ-ны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлаарх хамтарсан уулзалтуудыг улирал бүр зохион байгуулан ажилласан.<br>- Эрүүл мэндийн салбарт хөгжлийн бэрхшээлийн талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, ЭМС, ХНХС-ын А/807, 216 дугаар хамтарсан тушаал болон ХНХС, ЭМС, БШУС-ын А/220,475,812 дугаар хамтарсан тушаалын хэрэгжилт, анхаарах асуудал, цаашдын зорилтын талаар 21 аймаг 9 дүүргийн салбар комиссын гишүүдэд ЭТҮГ-тай хамтран илтгэл хэлэлцүүлсэн. Холбогдох мэдээллийг өгч хамтран ажилласан.   | 100            |
| 141. | ЗГҮАХ 2.3.8.5<br>Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлэх.   | 20.0            | Хамтран зохион байгуулсан сургалтын тоо   | 1 удаагийн сургалтаар 150 багшийг бэлтгэсэн.   | Сургалт зохион байгуулахад хамтран оролцсон байна.   | НЭМГ-УСХЗХ    | БШУЯ, Азийн хөгжлийн банкны хамтран хэрэгжүүлж буй "Тэгш хамран сургах боловсролыг дэмжих төсөл"-ийн хүрээнд төслийн зорилтот аймгууд болох Дархан-Уул, Дундговь, Дорнод аймгийн 437 багш, 46 цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтанд тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр сургалт зохион байгуулсан.<br>2023 оны 9 сард СЭМҮТ, ХНХЯ-ны харьяа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвтэй хамтран Баянгол дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн 123 нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарт "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйгээр хангах, чадавхжуулах" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах ажлын хүрээнд хувь хүний хөгжил, сэтгэл зүйн мэргэшүүлэх чиглэлээр 5 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 300 гаруй ажилтан, албан хаагчдыг хамруулсан.   | 100            |
| 142. | ЗГҮАХ 2.3.10.1<br>МУХТЖҮЧ-2.1.9<br>МУХТ 1.1.7<br>Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартыг баталж, мөрдүүлэх.             | -               | Стандартын шаардлагад нийцсэн хоолны газартай ерөнхий боловсролын сургуулийн эзлэх хувь | Стандартын төсөлд хамтран ажилласан.   | Ерөнхий боловсролын сургуулийн хоолны газрыг 50 хувь стандартын шаардлагад нийцүүлсэн байна. | НЭМГ-УСХЗХ    | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартын төслийг холбогдох газруудтай хамтран боловсруулж, БШУЯ тэргүүлэн тус стандартын төсөлд хэрэгжилтийн гарааны нөхцөлийн үнэлгээ хийж, төслийг эцэслэн 2023 оны 03 дугаар сард Стандарт хэмжил зүйн газарт батлуулахаар хүргүүлсэн. Улмаар Стандарт хэмжил зүйн газрын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн "MNS 7005: 2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага" стандарт шинээр батлагдсан ба 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөнө.<br>Төлөвлөгөөт шалгалтыг 2023 онд нийт 188 ерөнхий боловсролын сургууль, төлөвлөгөөт бус шалгалтыг 18 сургуульд хийсэн байна. Хяналт шалгалтаар сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд урьдчилсан хяналт шалгалтад хамрагдаж дүгнэлт гаргуулсан байх шаардлагын хэрэгжилт 25.7 хувь, хүнсний түүхийг | 70             |

| Д/д   | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                              | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|---|---|-----------------|---|--|--|---------------|--|----------------|
|   |   |                 |   |  |  |               | эд, бүтээгдэхүүн нь эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлуулсан шинжилгээний дүнтэй, шаардлага хангасан байх шаардлагын хэрэгжилт 62.78%, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, сав, баглаа боодол, хаяг шошго нь стандартын шаардлага хангасан байх шаардлагын хэрэгжилт 80.0%, үдийн хоол нь хоол хүнсээр авбал зохих илчлэг, шимт бодисын хэмжээг хангаж буй эсэхийг тооцож үнэлэлт дүгнэлт өгдөг байх шаардлагын хэрэгжилт 59.78%, үдийн хоолыг батлагдсан цэсийн дагуу хийх, хоол хүнсний дээжийг авч бүртгэл хөтөлдөг байх шаардлагын хэрэгжилт 81.5%, сурагчдын гар угаах нөхцөл боломж бүрдүүлсэн байх шаардлагын хэрэгжилт 79.31%, сургууль өөрсдийн үйл ажиллагаандаа дотоод хяналтыг хэрэгжүүлж, дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байх шаардлагын хэрэгжилт 68.9%-тай байна. |                |
| <b>ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>  |   |                 |   |  |  |               |  |                |
| 4.2. Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно. |   |                 |   |  |  |               |  |                |
| 143.  | ЗГҮАХ 4.2.5.3 Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | -               | Зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо | Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмээр зохицуулагдаж байгаа. | Сургалт, сурталчилгаа явуулж, үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайлыг хангаснаар ёс зүйн зөрчил буурсан байна. | ТЗУГ ЭТҮГ     | Улсын Их Хурлын 2023 оны "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн яамны Ёс зүйн дэд хороог яамны албан хаагчдын санал хураалтын дүнг үндэслэн 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, "Харилцаанд тулгуурласан манлайлал" сэдвээр сургалтууд зохион байгуулсан. Төрийн албаны тухай хууль, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийн талаар яамны шинэ албан хаагчдад сургалт зохион байгуулсан.  | 90             |
| 144.  | ЭМЯ-ны зарим АТТ-ыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулна.   | -               | ТАЗ-өөр хянагдаж, баталгаажсан АТТ-ын тоо     | Салбарын хяналтын газар шинээр байгуулагдсан.  | ЭМЯ-ны АТТ-ыг ТАЗ-өөр батлуулсан байна.  | ТЗУГ          | СХГ-ын гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг төслийг шинэчлэн боловсруулаад байгаа бөгөөд одоо хэрэгжүүлж байгаа чиг үүргийн давхцалыг гаргасан. Төрийн үйлчилгээний 7 албан хаагчийн АТТ-ын төслийг боловсруулж батлуулахад бэлэн болгосон. ЭМЯ-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг ЗГ-ын тогтоолоор шинэчлэн батлуулсаны дараа баталгаажуулахаар хүлээгдэж байна.   | 50             |
| 145.  | Яамны дэргэдэх ТАЗСЗ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллана.  | -               | ТАЗСЗ-ийн тайлан                              | ТАЗСЗ-ийн үйл ажиллагаа тогтмолжсон.   | ТАЗСЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг ТАЗ-д   | ТЗУГ          | Салбар зөвлөлийн 2022 оны тайланг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 2/89 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлсэн.   | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                             | Суурь түвшин   | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|--|--|-----------------|--|--|---|---------------|---|----------------|
|  |  |                 |  |  | хүргүүлсэн байна.   |               | 2023 оны жилийн эцсийн тайланг 2024 оны 1 дүгээр сарын 10-ны өдөрт багтаан хүргүүлнэ.   |                |
| 146.   | Төрийн албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын тусгай шалгалт зохион байгуулна.                                       | -               | Сонгон шалгаруулалтын тоо                    | ТАЗСЗ-өөс 2022 онд 101 сул албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. | Сонгон шалгаруулалт хууль, журмын дагуу явагдсан байна.   | ТЗУГ          | -2023 онд нийт 151 сул орон тооны ажлын байранд бүртгүүлсэн 298 иргэний мэдээллийг хянаж, системд баталгаажуулсан.<br>-Төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын тусгай шалгалтыг 6 удаа, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах шалгалтыг 1 удаа зохион байгуулсан.<br>-ТАЗ-ийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам, загвар батлах тухай", 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-ын дагуу ЭМЯ, ЗГХА-ЭМДЕГ, ЗГХА-ЭЭХХЗГ-ын удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсан шалтгаан, үндэслэлийг гаргаж ТАЗ-д захиалгыг хүргүүлсэн.<br>-2023 оны байдлаар сул орон тооны тусгай шалгалтын зохион байгуулах комиссын хурлыг 6 удаа, салбар зөвлөлийн 7 удаагийн хуралдаан зохион байгуулж, нэр дэвшүүлэхтэй холбоотой 21 тогтоол батлагдсан.<br>-ТАЗ-ийн 2023 оны 25 дугаар тогтоолын дагуу нийтийн телеграм групп болон able програм, ТАЗ болон яамны цахим хуудсанд 9 удаа 20 ажлын байрны мэдээллийг байршуулан ил тод, нээлттэй байдлыг хангаж албан хаагчдад мэдээлэл хүргэсэн. Журмын дагуу 2 албан тушаалын нөхөлт хийгдсэн. Нээлттэй сонгон шалгаруулалтаар 12 албан тушаалыг нөхсөн. | 100            |
| ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО   |  |                 |  |  |   |               |   |                |
| 5.1 Ногоон хөгжил. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройлтыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. |  |                 |  |  |   |               |   |                |
| 147.   | ЗГҮАХ 5.1.4.2 Аялал жуулчлалын бааз болон худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангуулах. | 80.0            | Шинээр гаргасан МСС-ны материалын төрөл, тоо | Стандартын шаардлага хангаагүй ариун цэврийн байгуулам-жийг 2018 онд хориглосон.   | Ариун цэврийн байгууламжийг сайжруулах, хөрсний бохирдлоос сэргийлэх талаар зөвлөмж, гарын авлага, инфографик, видео шторк боловсруулсан байна. | НЭМГ-УСХЗХ    | 2023 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр Европын Холбооны санхүүжилттэйгээр Монгол Улсад "Бохирдлыг бууруулах замаар эрүүл мэнд, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг сайжруулах нь" төслийн хүрээнд "Орчны бохирдлыг бууруулах" аян зохион байгуулж, стандартын бус нүхэн жорлонгоос үүдэлтэй хөрсний бохирдлоос сэргийлэх чиглэлээр 5 төрлийн инфографик, 1 баримтат видео боловсруулан олон нийтэд түгээн ажилласан. 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр БОАЖЯ-наас зохион байгуулсан "Жорлон" үндэсний чуулганд Эрүүл мэндийн яамнаас "Стандартын бус нүхэн жорлон хөрсний бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл" сэдвээр илтгэл хэлэлцүүлж оролцсон. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор "2023-2025 оныг Монголд Зочлох жил" болгон зарласантай   | 100            |

| Д/д   | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж              | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                    | Суурь түвшин                     | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|---|--|-----------------|-------------------------------------|----------------------------------|---|---------------|--|----------------|
|   |  |                 |                                     |                                  |   |               | холбогдуулан 02, 03, 04 дугаартай “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин” бүрдүүлэх арга хэмжээний тухай албан даалгавар гарсан. Уг албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд ЭМЯ-аас “Чиглэл хүргүүлэх тухай” 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 6/1631 тоот албан бичгийг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношилгоо эмчилгээний төвд хүргүүлж ажилласан.   |                |
| 6.Сайд, дэд сайд, удирдлага болон яамны аппаратын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлэх |  |                 |                                     |                                  |   |               |  |                |
| 148.  | Эрүүл мэндийн сайдтай Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2023 онд хамтран ажиллах гэрээг байгуулна. | -               | Гарын үсэг зурж, баталгаажсан гэрээ | Гэрээг жил бүр байгуулдаг.       | Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2023 онд хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. | БТГ-СУХ       | Эрүүл мэндийн сайд аймаг, нийслэлийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээний төсөлд ЭМЯ-ны газар, хэлтэс, аймаг, нийслэлийн Засаг дарга болон эрүүл мэндийн газраас ирүүлсэн саналыг тусган Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон бодлогын бусад баримт бичигтэй уялдуулан боловсруулж, 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр талууд гэрээг байгуулсан.   | 100            |
| 149.  | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг ЗГ-т хүргүүлнэ.  | -               | ЗГ-т хүргүүлсэн тайлан              | Тайланг улирал тутам хүргүүлдэг. | ЗГ-т тайланг улирал тутам хүргүүлсэн байна.   | ТЗУГ-ХХ       | Эрүүл мэндийн яам болон харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвд 2023 оны эхний 3 дугаар улиралд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын тайланг нэгтгэж 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр 1а/4464 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. 2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 3544 өргөдөл гомдол хүлээн авч, 3132 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн бөгөөд шийдвэрлэлтийн хувь 88.3%-тай байна. 2023 оны жилийн эцсийн тайланг 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн дотор ЗГХЭГ-т хүргүүлнэ.<br>2023 оны эхний хагас жилийн байдлаар Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд иргэд, байгууллагаас Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагуудад нийт 1034 санал, хүсэлт, гомдол хүлээн авснаас 919 буюу 88.8%-ийг шийдвэрлэсэн байна.<br>2023 онд шинээр яамны харьяа 3 эрүүл мэндийн байгууллагыг Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн программд холбосноор 14 байгууллагыг одоогийн байдлаар холбосон байна.<br>Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах зорилгоор 2023 оны 10 дугаар сараас өргөдөл, гомдлыг бичиг хэргийн Эйбл программаар хүлээн авч эхэлсэн. | 100            |
| 150.  | Салбарын хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргана.                        | -               | ХШҮДАГ-т хүлээлгэн өгсөн тайлан     | Тайланг сар тутам гаргадаг       | ХШҮДАГ-т тайланг сар тутам хугацаанд нь хүргүүлсэн байна.                           | ТЗУГ-ХХ       | Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн ХШҮДАГ-т тогтоосон хугацаанд хүргүүлсэн.<br>Жилийн эцсийн тайланг нэгтгэн гаргах хугацаа болоогүй байгаа байна.   | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|---|--|--|---------------|---|----------------|
| 151. | Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хагас бүтэн жилээр биелэлтийг гаргана.                            | -               | Батлагдсан төлөвлөгөө, хагас бүтэн жилээр гаргасан биелэлтийн тайлан    | Журмын дагуу боловсруулж батлуулдаг.   | Төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна. Хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр гаргасан байна.                | ТЗУГ          | Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, ЭМЯ-аас 2023 онд УИХ, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын чиглэлтэй уялдуулан боловсруулж, яамны газар хэлтсүүдийн саналыг нэмэлтээр тусган ТБНД, Эрүүл мэндийн сайдаар 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр баталгаажуулсан. Батлагдсан төлөвлөгөөг газрын дарга нарт цахимаар хүргүүлсэн. Яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн 6 дугаар сарын 19-ний өдөр ХШҮДАГ-т хүлээлгэн өгсөн бөгөөд жилийн эцсийн байдлаар нэгтгэн 12 дугаар сарын 11-нд тус газарт өгнө.  | 100            |
| 152. | ЭМЯ-ны харьяа байгууллагуудын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж баталгаажуулах ажлыг нэгдсэн арга зүйгээр хангана.                        |                 | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталгаажуулсан ЭМЯ-ны харьяа байгууллагын тоо | ЭМЯ-ны харьяа байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж Эрүүл мэндийн сайдаар батлуулдаг. | ЭМЯ-ны харьяа байгууллагуудын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж Эрүүл мэндийн сайдаар баталгаажуулсан байна. | ТЗУГ          | ЭМЯ-ны харьяа 27 байгууллагын холбогдох мэргэжилтнүүдтэй тус бүр 3-5 удаа уулзаж арга зүйн зөвлөгөө өгч, шаардлагатай засварыг хийж, бүх байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023 оны 2 дугаар сард багтаан Эрүүл мэндийн сайдаар баталгаажуулсан   | 100            |
| 153. | Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн асуудлаар төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн байгууллагуудыг арга зүйгээр ханган ажиллана. | -               | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь                             | Тусдаа төлөвлөгөө байдаггүй.   | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.  | ТЗУГ-ХХ       | Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл, зөвлөмжийг үндэслэн “Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх 2023 оны төлөвлөгөө”-г боловсруулан 2023 оны 05 дугаар сард батлуулсан. Төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж, гүйцэтгээд байна. 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт 75%-тай байна. Үүнд:<br>- “Монголын ардын ухаан, арга билгийн төв” ТББ-тай хамтран эрүүл мэндийн байгууллагуудад хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, гарсан дүгнэлт, санал зөвлөмжийг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн “Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах тухай” А/261 дүгээр тушаалыг батлуулж бүх эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн.<br>- 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн болон хуулийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар сургалт зохион байгуулсан.<br>- Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран Эрүүл мэндийн яамны албан хаагчдад зориулан “Ажлын байрны дарамт хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.<br>- Эрүүл мэндийн яамны цахим хуудаст “Хүний эрх” гэсэн дэд цэс үүсгэж Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан 30 эрхийн талаарх постерыг байршуулсан. | 70             |



| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                                      | Суурь түвшин                             | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|---|--|--|---------------|---|----------------|
| 154. | ЭМЯ, түүний харьяа байгууллагын Авлигаас урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн байгууллагуудыг арга зүйгээр ханган ажиллана. | -               | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь           | Жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг.  | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.  | ТЗУГ-ХХ       | 2023 онд төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн. Үүнд: Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран боловсруулж, 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдөр батлуулж, батлагдсан төлөвлөгөөг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 2/878 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг Эрүүл мэндийн яам болон харьяа эрүүл мэндийн байгууллагуудын хэмжээнд нэгтгэн khutulbur.iaac.mn цахим систем 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдөр тайлагнасан. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний жилийн эцсийн тайланг khutulbur.iaac.mn цахим системд 2023 оны 12 дугаар сарын 15-нд нээгдэхэд тайлагнана.<br>Эрүүл мэндийн яамны Авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөг 2023 оны 08 дугаар сарын 02-ны өдөр батлуулж, нийт газар хэлтсийн дарга нарт 2023 оны 08 дугаар сарын 02-ны 163 дугаар дотоод меморандумаар хүргүүлсэн. Тус төлөвлөгөөнд 5 зорилгын хүрээнд 12 арга хэмжээ төлөвлөсөн бөгөөд төлөвлөгөөний биелэлтийг салбарын тайланд нэгтгэн 2023 оны 12 дугаар сарын 15-нд khutulbur.iaac.mn цахим систем нээгдэхэд тайлагнана. | 100            |
| 155. | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишигийг тогтоосон журмыг батлуулна.   | -               | Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал   |  | Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар төлбөрийн хэмжээ, зардлын жишиг батлагдсан байна. | ТЗУГ          | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой зардлын жишигийг батлах тухай Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын төсөл, тушаалын төслийн нөлөөллийн шинжилгээ, танилцуулгыг боловсруулж, Сангийн яамнаас санал авахаар 2023 оны 11-р сарын 16-ны өдрийн 1а/5160 албан бичгээр хүргүүлсэн.   | 70             |
| 156. | “Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишиг”-ийг шинэчлэн батлуулна.   | -               | Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал   | 2013 оны журмаар зохицуулагдаж байгаа.   | Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар төлбөрийн хэмжээ, зардлын жишиг батлагдсан байна. | ТЗУГ          | Эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгохтой холбоотой зардлын жишигийг батлах тухай Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын төсөл, тушаалын төслийн нөлөөллийн шинжилгээ, танилцуулгыг боловсруулж, Сангийн яамнаас санал авахаар 2023 оны 11-р сарын 16-ны өдрийн 1а/5160 албан бичгээр хүргүүлсэн.   | 70             |
| 157. | Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл   | -               | Тэргүүлэх чиглэл баталсан эрүүл мэндийн сайдын тушаал | 2018 оны тушаалаар зохицуулагдаж байгаа. | Тэргүүлэх чиглэл шинэчлэгдэн батлагдсан байна.   | ТЗУГ          | Монгол Улсын хүн амын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан 2024-2027 онд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хязгаарлах, олгохгүй чиглэлийг батлах тухай Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулж Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд 2023 оны 12-р сарын 1-ний өдөр хүртэл санал авахаар байршуулсан болно.  | 50             |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин  | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|--|---|--|---------------|--|----------------|
|      | олгох тэргүүлэх чиглэлийг батлуулна.   |                 |  |   |  |               |  |                |
| 158. | Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлуулна.  | -               | Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны журам баталсан Эрүүл мэндийн сайдын тушаал                         | 2013 оны журмаар зохицуулагдаж байгаа.  | Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны журам шинэчлэгдэн батлагдсан байна.                        | ТЗУГ          | “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны 10-р сарын 10-ны өдрийн А/359-р тушаалаар батлуулан мөрдөж ажиллаж байна. Тушаалыг Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд байршуулсан болно.   | 100            |
| 159. | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлагыг шинэчлэн батлуулна. | -               | Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлагыг баталсан Эрүүл мэндийн сайдын тушаал | 2013 оны журмаар зохицуулагдаж байгаа.  | Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага шинэчлэгдэн батлагдсан байна. | ТЗУГ          | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлагыг шинэчлэн батлуулж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 100 дугаар тушаалаар батлуулж, Хууль зүйн яамнаас “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэл”-д бүртгүүлэн мөрдөж ажиллаж байна.  | 100            |
| 160. | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс болон шинжээч нарын ажиллах журмыг шинэчлэн батлуулна.    | -               | Тусгай зөвшөөрөл олгох комисс болон шинжээч нарын ажиллах журмыг баталсан Эрүүл мэндийн сайдын тушаал    | 2021 оны журмаар зохицуулагдаж байгаа.  | Тусгай зөвшөөрөл олгох комисс болон шинжээч нарын ажиллах журам шинэчлэгдэн батлагдсан байна.    | ТЗУГ          | “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын бүрэлдэхүүн, ажиллах журам”-ыг шинэчлэн Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/383 дугаар тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. Тусгай зөвшөөрөл шинээр бүрдүүлэх сунгалттай холбоотой мэдээллийг шинэчлэн Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд байршуулсан.<br>“Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах, шинжээчийн ажиллах журам батлах тухай” журмыг шинэчлэн Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/402 дугаар тушаалаар батлуулсан. Тушаалыг Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд байршуулсан.  | 100            |
| 161. | Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн 76 дугаар чуулганд оролцох  |                 | Батлагдсан арга хэмжээний төлөвлөгөө   | Жил бүр чуулгаанд оролцож, хэлэлцэх асуудлаар Засгийн газрын байр суурийг илэрхийлдэг | Хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байна.                        | ТЗУГ-ГХХ      | Дэлхийн эрүүл мэндийн ассамблейн 76 дугаар чуулганд оролцохтой холбоотойгоор төлөөлөгчдийн Ажлын удирдамж, танилцуулга, Эрхийн үнэмлэхний төсөл зэргийг боловсруулж, чуулганы дэлгэрэнгүй хөтөлбөрийн хамт 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 2/2093 дугаар албан бичгээр ГХЯ-нд хүргүүлж тус яамны саналыг авсан. ГХЯ-ны саналыг тусгаж, ажлын удирдамжийг батлуулсан ба Чуулганд оролцох төлөөлөгчдөд ГХ-ны Сайдын гарын үсэг бүхий Эрхийн үнэмлэхийг гаргуулж, цахим бүртгэлийг гүйцэтгэсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанд Төрийн нарийн бичгийн даргын хэлэх үгийн төслийг англи хэлээр боловсруулж бэлтгэсэн ба ДЭМБ-ын холбогдох газарт мөн эх бичвэрийг журмын дагуу хүргүүлсэн. Чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлж үг хэлж оролцсон. Ажлын удирдамжид заасны дагуу Чуулганы А хорооны хуралдаанаар авч хэлэлцсэн асуудлуудаас | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж                                | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт         | Суурь түвшин | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|--------------------------|--------------|--|---------------|--|----------------|
|      |  |                 |                          |              |  |               | 2 асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлсэн.<br>Чуулганд оролцсон дүнгийн тухай илтгэх хуудсыг 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 3/2499 дугаар бүхий албан бичгээр ГХЯ-нд хүргүүлэв.<br>Чуулганы мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг зуруулан холбогдох газар, хэлтсийн дарга нарт 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр хүргүүлэв.  |                |
| 162. | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн хорооны Тусгай чуулганы хоёрдугаар хуралдаанд оролцох |                 | Чуулганд оролцсон тайлан |              | Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”-д заасны дагуу бэлтгэл ажлыг хангаж, чуулганд оролцсон байна. | ТЗУГ-ГХХ      | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн хорооны хоёрдугаар Тусгай чуулган 2023 оны 02 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Филиппин Улсын Манила хотноо хуралдав. Тусгай чуулганд эрхийн бичгийн дагуу Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд, Эрүүл мэндийн яамны Гадаад харилцааны хэлтсийн дарга Б.Янжмаа нар оролцов. Тусгай чуулганд хэлэлцсэн асуудлаар Засгийн газрын байр суурийг илэрхийлсэн бөгөөд чуулганд оролцсон дүнгийн тухай илтгэх хуудсыг Гадаад харилцааны яамны Олон талт хамтын ажиллагааны газар болон НҮБ-ын Женев дэх төв болон бусад олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газарт 2023 оны 3 дугаар сарын 7-ны өдөр тус тус хүргүүлсэн.  | 100            |
| 163. | Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн хорооны 74 дугаар чуулганд оролцоно.                  |                 | Чуулганд оролцсон тайлан |              | Чуулганд оролцож, хэлэлцэх асуудлаар Монгол Улсын Засгийн газрын байр суурийг илэрхийлсэн байна.   | ТЗУГ-ГХХ      | Чуулган 2023 оны 10 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Филиппин Улсын Манила хотноо зохион байгуулагдсан. Чуулганд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн оролцох төлөөлөгчдийн баримтлах ажлын удирдамжийг боловсруулан, ГХЯ-нд албан бичгээр хүргүүлж саналыг авсан. Ажлын удирдамжийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан. Чуулганд оролцох төлөөлөгчдийн Эрхийн бичгийг Гадаад харилцааны яамнаас холбогдох журамд заасны дагуу авч, ДЭМБ-д хүргүүлсэн. Чуулганд батлагдсан удирдамжийн дагуу амжилттай оролцсон. Монгол Улс энэ удаагийн чуулганы Дэд даргаар сонгогдон ажилласан ба энэ үүрэгт ажлыг ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Төгсдэлгэр амжилттай гүйцэтгэсэн. Чуулганы хуралдаануудаар хэлэлцсэн бодлогын 4 баримт бичгийн төслийг батлах хэлэлцүүлэгт оролцож, Засгийн газрын байр суурийг асуудал тус бүрээр илэрхийлсэн.<br>Мөн чуулганы үеэр Бүсийн захирлын сонгууль болохтой холбогдуулан 5 нэр дэвшигчийн талаар нэг бүрчлэн дэлгэрэнгүй танилцуулгыг бэлтгэж, тэдгээрийн олон улсын эрүүл мэндийн чиглэлээрх ажлын туршлага, олон улсад танигдсан байдал, санал өгөх саналаа “нууц”-ын зэрэглэлтэй албан бичгээр ГХЯ-нд | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                                      | Суурь түвшин | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|---|--------------|---|---------------|--|----------------|
|      |   |                 |   |              |   |               | хүргүүлж, тус яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу сонгуулийн санал хураалтад оролцсон. Чуулганд оролцсон дүнгийн тухай илтгэх хуудас, хуралдаанд хэлсэн үг зэргийг хавсаргаж, ажлын 3 хоногт багтаан 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 2/4825, Бүсийн захирлын сонгуулийн үр дүнгийн талаарх илтгэх хуудсыг 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн “нууц” албан бичгээр тус тус ГХЯ-нд хүргүүлсэн.  |                |
| 164. | Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд гадаад улс орон, олон улсын байгууллагын техникийн туслалцааны шинэ төслийн санал боловсруулж, шийдвэрлүүлэх  |                 | Батлагдаж хэрэгжсэн төслийн тоо, санхүүжилтийн хэмжээ |              | Шинээр хэрэгжүүлэх төсөл батлуулсан байна.                                | ТЗУГ-ГХХ      | <ul style="list-style-type: none"> <li>- Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан 2023-2027 онд хэрэгжих “Монгол Улсад хэрхийн шалтгаант хүүхдийн зүрхний өвчнөөс сэргийлэх, түүнийг бууруулах нь” 5 сая ам.долларын төслийг батлуулан 2023 оны 3 дугаар сараас эхлүүлсэн.</li> <li>- Унгар Улсын Засгийн газрын Олон улсын хамтын ажиллагааны газарт Сумын эрүүл мэндийн төвд цэвэр ус, ариун цэврийн байгууламж байгуулах 1,67 сая ам.долларын төслийн саналыг уламжлуулахаар Эдийн засаг, хөгжлийн яаманд 2023 оны 6 дугаар 8-ны өдөр албан бичгээр хүргүүлэв.</li> <li>- НҮБ-ын Олон улсын атомын энергийн агентлагтай Улс орныг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх “Монгол Улсад хорт хавдрын менежментийг сайжруулах” техникийн туслалцааны төслийн саналыг боловсруулж, ОУАЭА батлан хэрэгжүүлж эхэлсэн.</li> </ul> | 100            |
| 165. | Монгол Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны ЗГ хоорондын комиссын ээлжит 12 дугаар хуралдааныг зохион байгуулна. |                 | Батлагдсан арга хэмжээний төлөвлөгөө                  |              | Хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байна. | ТЗУГ-ГХХ      | Монгол-Лаосын Засгийн газар хоорондын комиссын 12 дугаар хуралдааныг Комиссын монголын хэсгийн дарга, Эрүүл мэндийн сайд С.Чинзориггоор даргалуулан 2023 оны сүүлийн хагаст буюу 12 дугаар сард зохион байгуулах талаар айлын талд дипломат шугамаар уламжлуулсан. Үүний дагуу хуралдааныг 2023 оны 12 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд зохион байгуулахаар харилцан тохиролцож, бэлтгэл ажлыг хангасан боловч Комиссын Монголын хэсгийн дарга, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг 2024 оны 1 дүгээр улирал болгон хойшлуулах хүсэлтийг ГХЯ-аар дамжуулж айлын талд санал хүргүүлсэн. Үүний мөрөөр БНАЛАУ-ын ГХЯ-наас 11 дүгээр сарын 27-ны өдрийн 416 дугаар бүхий ноот бичгээр комиссын хуралдааныг 2024 оны 12 дугаар сард зохион байгуулах  | 70             |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж       | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                     | Суурь түвшин | Зорилтот түвшин                     | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|--------------------------------------|--------------|-------------------------------------|---------------|---|----------------|
|      |   |                 |                                      |              |                                     |               | саналтай байгаагаа илэрхийлсэн хариу ирүүлсэн тул ГХЯ-аас Комиссын хуралдааныг 2024 оны 4 дүгээр улиралд зохион байгуулах төлөвлөгөөнд оруулсан.<br>Манай талаас Комиссын хуралдааныг зохион байгуулахтай холбогдуулан яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж, бэлтгэл ажлыг бүрэн хангасан. Мөн ЗГХК-ийн хуралдааны мөрөөр байгуулах Протоколын төслийг монгол, англи хэлээр бэлтгэж, айлын талтай цахим шуудангаар харилцаж эцэслэн тохиролцсон. БНАЛАУ-ын ЭМЯ-тай байгуулах шинэчилсэн Санамж бичгийн төслийг монгол, англи хэлээр боловсруулан, эцэслэж, ГХЯ-наас байгууллага хоорондын гэрээ байгуулах зөвшөөрлийг авч, айлын талтай тохиролцсон.   |                |
| 166. | Монгол Улсын Эрүүл мэндийн сайдыг БНСУ-д айлчлуулах асуудлыг шийдвэрлүүлж, зохион байгуулах |                 | Батлагдсан арга хэмжээний төлөвлөгөө |              | Айлчлал зохион байгуулагдсан байна. | ТЗУГ-ГХХ      | Эрүүл мэндийн Дэд сайд С.Энхболд Монгол Улсын Ерөнхий сайд. Л.Оюун-Эрдэнийн Бүгд Найрамдах Солонгос Улсад хийсэн албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд орж 2023 оны 2 дугаар сарын 13-наас 17-ны өдрүүдэд тус улсад айлчилсан. Айлчлалын мөрөөр тус улсын тодорхой нэр бүхий эмнэлгүүдэд монголын сувилагч нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулахаар тохиролцож, 2023 оны 12 дугаар сарын байдлаар 100 гаран сувилагчийг сургалтад хамруулаад байна.<br>Мөн Монгол Улсын ЭМЯ, БНСУ-ын Өвчний хяналтын агентлагтай хамтран ажиллах Санамж бичиг байгуулахаар тохиролцсоны дагуу санамж бичгийн төслийг монгол, англи хэлээр боловсруулж, айлын талд хүргүүлсэн. Айлын талаас санал ирмэгц эцэслэсэн эх бичвэрийг ГХЯ-ны Олон улсын гэрээ эрх зүйн газарт хүргүүлж, байгууллага хоорондын гэрээ байгуулах албан ёсны зөвшөөрлийг авна. Санамж бичгийг цахимаар харилцан зурж, солилцох тухайгаа БНСУ-ын Өвчний хяналтын агентлагтай тохиролцсон болно. | 100            |
| 167. | Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын Япон Улсад хийх ажлын айлчлалыг зохион байгуулах          |                 | Батлагдсан арга хэмжээний төлөвлөгөө |              | Айлчлал зохион байгуулагдсан байна. | ТЗУГ-ГХХ      | Эрүүл мэндийн Дэд сайд С.Энхболд 2023 оны 3 дугаар сарын 24-нөөс 28-ны өдрүүдэд Япон Улсад ажлын айлчлал хийв. Айлчлалын үеэр Япон Улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, халамжийн сайд Кацунобу Като сайдтай албан уулзалт хийж, 2 улсын Эрүүл мэндийн яамд хоорондын 2018 онд байгуулсан Хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийг хангах, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хүрээн дэх хоёр талын хамтын ажиллагааг улам эрчимжүүлэх зэрэг чиглэлээр тусгайлан ярилцаж, санал солилцсон. Энэ үеэр ЭМЯ-ны хүний нөөцийг бэхжүүлэхэд чиглэлээр хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа манай талаас илэрхийлсний дагуу тус улсын Олон улсын эрүүл мэнд, халамжийн их сургуулиас манай яамны залуу албан хаагчийг жил бүр магистрын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулахаар шийдвэрлэсэн тухай энэ оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн албан   | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|---|--|--|---------------|--|----------------|
|      |  |                 |   |  |  |               | бичгээр Эрүүл мэндийн сайдад хандан албан бичгээр ирүүлсэн. Түүнчлэн энэ арга хэмжээг албажуулж тогтмолжуулах зорилгоор Харилцан эрмэлзлэлийн захидалд гарын үсэг зурахаар тохиролцсон ба уг захидалд 2024 оны эхний улиралд багтаан гарын үсэг зурахаар ажиллаж байна.  |                |
| 168. | Гадаад хамтын ажиллагааны 2022 оны бичмэл тайланг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байх |                 | Хугацаанд нь хүргүүлсэн тайлан  |  | Эрүүл мэндийн салбарын 2022 оны гадаад хамтын ажиллагааны тайланг ГХЯ-нд хүргүүлсэн байна. | ТЗУГ-ГХХ      | 2023 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 2/24 дугаар бүхий албан бичгээр Эрүүл мэндийн салбарын 2022 оны Гадаад хамтын ажиллагааны бичмэл тайланг хүргүүлсэн болно.   | 100            |
| 169. | Яамны төрийн нууцтай холбоотой үйл ажиллагааг хууль журмын хүрээнд зохион байгуулна.   | -               | Нууцын үйл ажиллагаатай холбоотой зөрчил гараагүй байна.                                | Хууль, журмын хүрээнд нууцын үйл ажиллагааг зохион байгуулдаг. | Нууцтай холбоотой үйл ажиллагаа хууль, журмын дагуу явагдсан байна.                        | ТЗУГ-ХХ       | Нууцын журмаар ирсэн, явсан албан бичгийн бүртгэлийг хөтөлж, холбогдох албан тушаалтанд танилцуулах, бүртгэлийн дугаар олгох, холбогдох байгууллагад хүргэж өгөх ажлыг хийж гүйцэтгэсэн. Ирсэн нууц, маш нууц албан бичгүүдийн шийдвэрлэлтийн хугацаанд хяналт тавьж ажилласан ба 100 % шийдвэрлэгдэж хариу өгөгдсөн. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Эрүүл мэндийн яамны 2022 онд хийсэн ажлын тайланг Тагнуулын Ерөнхий газарт нууцын журмаар албан бичгээр хүргүүлсэн. ЭМЯ-ны харьяа төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд бүгд нууц хамгаалах ажилтантай болсон. Нийт 10 хүний шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг ТЕГ-рт 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 2/1662, 11 дүгээр сарын 07-ны өдрийн 2/4089 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. Дээрх үйл ажиллагаануудыг хэрэгжүүлснээр төрийн болон албаны нууцыг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлсэн нь Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж хэрэгжих нөхцөл боломж бий болсон. | 100            |
| 170. | Яамны болон харьяа байгууллагуудын албан хаагчдын 2021 оны Хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах үйл ажиллагаанд                        | -               | Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж өгөх ёстой төрийн албан хаагчдын мэдүүлэг гаргасан хувь | Хуульд заасан хугацаанд холбогдох албан тушаалтнуудын хөрөнгө  | Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж өгөх ёстой төрийн албан хаагчид                            | ТЗУГ-ХХ       | Эрүүл мэндийн яам болон харьяа байгууллагын ХАСХОМ мэдүүлэх албан тушаалын жагсаалтыг Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан нийтийн албан тушаалтны жагсаалттай нийцүүлэн нийт 713 албан тушаалын жагсаалт болон ХАСХОМ  | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                                   | Суурь түвшин  | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|--|---|--|---------------|---|----------------|
|      | хяналт тавьж, тайлан гаргана.   |                 |  | орлогын мэдүүлгийг хянаж хүлээн авдаг.                      | 100 хувь хуулийн хугацаанд мэдүүлэг гаргасан байна.                      |               | мэдүүлэх үүрэгтэй 672 албан тушаалтны нэрсийг Авлигатай тэмцэх газарт 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлсэн. Эрүүл мэндийн яам болон харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх үүрэгтэй нийт 696 албан тушаалтан 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор meduuleg.iaac.mn хуудсанд ХАСХОМ бүрэн мэдүүлсэн. Энэ хугацаанд албан хаагчдад арга зүйн дэмжлэг үзүүлэн хугацаанд нь баталгаажуулахад дэмжлэг үзүүлж Авлигатай тэмцэх газартай хамтран цахим сургалт зохион байгуулж ажилласан. Нийт 696 албан тушаалтны ХАСХОМ-ыг системд баталгаажуулж, хугацаанд нь илгээсэн.  |                |
| 171. | Эрх зүйн маргаанд Эрүүл мэндийн яамыг төлөөлж оролцсон байна.                         | -               | Шүүхээр бүрэн шийдвэрлүүлсэн эрх зүйн маргааны тоо | ЭМЯ-тай холбоотой эрх зүйн маргааныг яамыг төлөөлж оролцдог | ЭМЯ-тай холбоотой эрх зүйн маргааныг хуулийн дагуу шийдвэрлүүлсэн байна. | ТЗУГ-ХХ       | 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 28 хэргээс Захиргааны 16, Иргэний 12 хэрэг маргаанд Эрүүл мэндийн яам оролцсон. 28 хэргээс 14 хэрэг 2023 онд эцэслэн шийдвэрлэгдэж, 14 хэрэг шүүхийн шатанд байна.   | 100            |
| 172. | Архивын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг зохион байгуулж, үзлэгт хамрагдана.              | -               | Улсын үзлэгийн дүн                                 |   | Улсын үзлэгт хамрагдах бэлтгэл ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.     | ТЗУГ          | "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг" нь 4 жил тутамд зохион байгуулагддаг ба хамгийн сүүлд 2019 оны 4 дүгээр улиралд зохион байгуулагдсан. 2023 онд улсын үзлэг зохион байгуулагдахгүй тухай Архивын ерөнхий газраас мэдэгдсэн болно. Өмнөх улсын үзлэгээр байгууллагын зохион байгуулалт, албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаа гэсэн 3 чиглэлээр 10 зөвлөмжийг өгсөн бөгөөд эдгээр арга хэмжээний хэрэгжилт 94.8% байна.   | 100            |
| 173. | Тоон гарын үсэг нэвтрүүлнэ.   | -               | Тоон гарын үсэг хэрэглэж буй албан хаагчийн тоо    |   | Албан бичиг шийдвэрлэлтэд тоон гарын үсэг ашигладаг болсон байна.        | БТГ ТЗУГ      | 2023 оны 8 дугаар сараас тоон гарын үсгийг нэвтрүүлж эхэлсэн. ТНБД, газар, хэлтсийн дарга нар тоон гарын үсгээр 101 албан бичиг баталгаажуулсан байна. Архивын ерөнхий газрын дарга С.Энхбаатараас цаасан хэлбэрээр давхар хадгалах цахим баримт бичгийн нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалт батлагдсан эсэх мөн тоон гарын үсгээр баталгаажсан албан бичгийн хувийг архивын нэгж үүсгэн хадгалахад уламжлалт аргаар буюу гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулах талаар чиглэл авах тухай 3/4013 албан бичгээр хүргүүлсэн. Хүсэлтийн дагуу АЕГ-ын даргын 2023.09.29-ний өдрийн 01/539 дугаар албан бичигт Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн болон салбарын жагсаалтыг холбогдох хууль эрх зүйн актыг үндэслэн боловсруулж байгаа талаар хариу ирсэний дагуу тоон болон уламжлалт байдлаар албан бичгийг зэрэгцүүлэн явуулж байна. УБЕГ-т 2023.03.07-ны өдрийн 4/968 тоот албан бичгээр ЭМЯ-ны албан хаагчдыг цахим гарын үсэгжүүлэх хүсэлтийг илгээн, 88 албан хаагчид цахим гарын үсэг олгосон. | 50             |

| Д/д   | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин                                  | Зорилтот түвшин                                | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|---|---|-----------------|-------------------|---|--|---------------|--|----------------|
|   |   |                 |                   |   |  |               | Эрүүл мэндийн байгууллагуудад эмнэлгийн мэргэжилтнийг 2023.05.01-ны дотор цахим гарын үсэгтэй болгох тухай 2023.02.20-ны 2/769 тоот албан бичгийг, Эмнэлгийн мэдээллийн систем хөгжүүлэгч аж ахуй нэж байгууллагуудад 2023.02.20-ны 2/767 тоот албан бичгийг тус тус хүргүүлж, хөгжүүлэлтийг хийснээр E-Health эмнэлгийн програм хангамж ашигладаг 48 эмнэлгийн 17.385 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тоон гарын үсэг ашиглаж байна.   |                |
| 7. Салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийн зарцуулалтад хяналт, шалгалт, дотоод аудит хийх. |   |                 |                   |   |  |               |  |                |
| 174.  | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.  | -               | Үнэлгээний тайлан | Жил бүр үнэлгээ хийж ЭЗХЯ-нд хүргүүлдэг.      | Тайланг ЭЗХЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна. | ХШҮДАГ        | Монгол Улсыг 2021-2025 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд газар, хэлтсүүдээс тайлан авах 2023.12.06-ны өдрийн Дотоод меморандум №264 боловсруулж, дарга нарт өгсөн. Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд ХШҮ хийж, дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Үнэлгээ ..... хувьтай байна. Дүнг 1а/..... дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан new.unelgee.gov.mn-д 2023 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталгаажуулсан.  | 100            |
| 175.  | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд сар бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | -               | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлдэг. | Тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | ХШҮДАГ        | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд баталгаажуулсан. Үүнд:<br>-2 сарын үнэлгээний дүн 39.51 хувь. (Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн үнэлгээтэй 7, 30 хувийн үнэлгээтэй 24, Үр дүнгүй буюу 0 хувийн үнэлгээтэй 27 арга хэмжээ).<br>-3 сарын үнэлгээний дүн 42.85 хувь, өмнөх сараас 3.34 хувиар өссөн. (Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн үнэлгээтэй 8, 30 хувийн үнэлгээтэй 26, Үр дүнгүй буюу 0 хувийн үнэлгээтэй 21 арга хэмжээ)<br>-4 сарын үнэлгээний дүн 43.08 хувь, өмнөх сараас 0.23-аар өссөн. (Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн үнэлгээтэй 8, 30 хувийн үнэлгээтэй 26, Үр дүнгүй буюу 0 хувийн үнэлгээтэй 21 арга хэмжээ) | 100            |



| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж                       | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин                             | Зорилтот түвшин                                | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|-------------------|--|--|---------------|---|----------------|
|      |   |                 |                   |  |  |               | <p>-5 сарын үнэлгээний дүн 47.63 хувь, өмнөх сараас 4.55-аар өссөн. (Эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувийн үнэлгээтэй 8, 30 хувийн үнэлгээтэй 26, Үр дүнгүй буюу 0 хувийн үнэлгээтэй 21 арга хэмжээ)</p> <p>-2023 оны эхний хагас жилийн байдлаар үнэлгээний дүн 51.2 хувь, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн үнэлгээ 49.3%, үнэлгээний зөрүү 1.9%. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 1а/3101 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>-7 сарын үнэлгээний дүн 51.29%.</p> <p>-8 сарын үнэлгээний дүн 52.18%.</p> <p>-9 сарын үнэлгээний дүн 53.93%.</p> <p>-10 сарын үнэлгээний дүн 55.61%., ЗГХХГ-ын үнэлгээ ижил, үнэлгээний хувийн зөрүү гараагүй.</p> <p>-11 сарын үнэлгээний дүн 61.8 хувь.</p>   |                |
| 176. | Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх        | -               | Үнэлгээний тайлан | Жил бүр үнэлгээ хийж ЭЗХЯ-нд хүргүүлдэг. | Тайланг ЭЗХЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна. | ХШҮДАГ        | Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан Эрүүл мэндийн салбарын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022.12.26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, үнэлгээний тайланг, холбогдох шийдвэрийн хамт Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлнэ.  | 100            |
| 177. | Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд сар бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.           | -               | Үнэлгээний тайлан | Сар бүр үнэлгээ хийж ЭЗХЯ-нд хүргүүлдэг. | Тайланг ЭЗХЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна. | ХШҮДАГ        | <p>1. Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Үнэлгээний хувь 45.93, "Эрчимжүүлэх шаардлагатай" гэсэн үнэлгээтэй байна. Тайланг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 1а/2808 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хугацаанд (2023.06.15) нь хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан.</p> <p>2. Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг 2023 оны 07 дугаар сараас эхлэн сар бүр хийж, дараа сарын 10-ны дотор тайланг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд оруулсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- 7 сарын үнэлгээний дүн 42.63%;</li> <li>- 8 сарын үнэлгээний дүн 42.63%;</li> <li>- 9 сарын үнэлгээний дүн 45.13%;</li> <li>- 10 сарын үнэлгээний дүн 44.97%;</li> <li>- 11 сарын үнэлгээний дүн 45.98%</li> </ul> | 100            |
| 178. | Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | -               | Үнэлгээний тайлан | Жил бүр үнэлгээ хийж СЯ-нд хүргүүлдэг.   | Тайланг СЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна.   | ХШҮДАГ        | Эрүүл мэндийн салбарт 2022 онд гадаадын зээл, тусламжаар 68 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн ба хэрэгжилтийн дундаж 81.6 хувьтай байна. Төсөл, арга хэмжээний үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Үнэлгээний дүнг Сангийн яаманд 2023 оны 1а/853 дугаар албан бичгээр хүргүүлсэн.   | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж                | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|-------------------|--|---|---------------|--|----------------|
| 179. | Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтийн үйл явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.                     |                 | Үнэлгээний тайлан | Жил бүр үнэлгээ хийж ЭЗХЯ-нд хүргүүлдэг.                     | Тайланг ЭЗХЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна.                | ХШҮДАГ        | 1. Шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээ хийж, дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2023.06.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Эрүүл мэндийн салбар дахь шинэ сэргэлтийн бодлогын хэрэгжилт 80.7% буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдэв. Үнэлгээний дүн, тайланг 2023.06.16-ны өдрийн 1а/2808 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэв<br>Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийсэн ба үнэлгээгээр хэрэгжилт 86.7% буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдэв. Үнэлгээний тайланг 2023.11.30-ны өдрийн 1а/5449 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.  | 100            |
| 181. | Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. |                 | Үнэлгээний тайлан | Жил бүр үнэлгээ хийж ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулдаг. | Үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулсан байна. | ХШҮДАГ        | 1. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журмын дагуу Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт хагас жилийн байдлаар 57.4% буюу "эрчимжүүлэх шаардлагатай" гэж үнэлэгдсэн. Үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн 2023.06.30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, 0-30% хэрэгжилттэй 73 үйл ажиллагааг эрчимжүүлэхийг нэгжийн дарна нарт үүрэг болгосон шийдвэр хурлаас гарч, 2023.07.04-ны Дотоод меморандум №146-аар 6 газрын дарга нарт үнэлгээний дүн, холбогдох шийдвэрийг хүргүүлсэн.<br>2. Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу 12 дугаар сарын 15-ны дотор газар, хэлтсүүд тайланг ирүүлэх ба үнэлгээг хийж, Удирдлагын зөвлөлийн 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэх төлөвлөгөөтэй байна. | 100            |
| 182. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд сар бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.                | -               | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд ЗГХЭГ-т хүргүүлдэг.                | Тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.                | ХШҮДАГ        | 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний дүн 70.1 хувиар үнэлэгдсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Тайланг ЗГХЭГ-т 2023 оны 1а/827 дугаар албан бичгээр хүргүүлж, Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан <a href="https://new.unelgee.gov.mn">https://new.unelgee.gov.mn</a> -д оруулж баталгаажуулсан.<br>Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд (Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар) сар бүр үнэлгээ хийж, журамд заасан хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан <a href="https://new.unelgee.gov.mn">https://new.unelgee.gov.mn</a> -д оруулж, баталгаажуулсан. Үүнд:<br>- 3-р сард үнэлгээний 61.17 хувь (65 заалтын хүрээнд),<br>- 4 дүгээр сард 62.95 хувь (66 заалтын хүрээнд),   | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин                                  | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|-------------------|---|---|---------------|---|----------------|
|      |   |                 |                   |   |   |               | - 5 дугаар сард 65.41 хувь (66 заалтын хүрээнд), 6 дугаар сард 72.19 хувь (270 заалтын хүрээнд),<br>- 7 дугаар сард 66.81 хувь (106 заалтын хүрээнд), 8 дугаар сард (108 заалтын хүрээнд) 66.28 хувь, 9 дүгээр сард 67.48 хувь (120 заалтын хүрээнд),<br>- 10 дугаар сард 67.1 хувь (125 заалтын хүрээнд)   |                |
| 183. | Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд 2022 онд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | -               | Үнэлгээний тайлан | Тайланг тогтсон хугацаанд ЗГХЭГ-г хүргүүлдэг. | Тайланг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.                | ХШҮДАГ        | 1. Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022.03.01-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг дарга нарын 2022 онд хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийн дундаж 80.7% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдэв. Үнэлгээний тайлан, зөвлөмжийг 2022.03.03-ны өдрийн 1а/895 дугаар албан бичгээр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Үнэлгээний дүнг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан <a href="http://www.new.unelgee.gov.mn">www.new.unelgee.gov.mn</a> -д 86 үзүүлэлтээр, аймаг тус бүрээр оруулсан ба нэгдсэн танилцуулга, дүнг 2023.03.01-ны өдрийн 1а/852 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.<br>Эрүүл мэндийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хооронд 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилийн байдлаар ХШҮ хийсэн. Үнэлгээгээр гэрээний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 71.6% буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн. Үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн 2023.07.06-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, тайлан, зөвлөмжийг 2023.07.06-ны өдрийн 1а/895 дугаар албан бичгээр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн. | 100            |
| 184. | Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.  | -               | Үнэлгээний тайлан | -   | Үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулсан байна. | ХШҮДАГ        | Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотой Эрүүл мэндийн сайдын 2020, 2021 болон 2022 оны тушаалын давхардал, хийдэл, зөрчилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлан боловсруулсан. Үнэлгээний тайланг .... Дотоод меморандум №.... газар, хэлтсийн дарга нарт өгсөн.<br>Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд байгаа 85 шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Тайлан, цаашид авах арга хэмжээний саналыг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 1а/2245 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.  | 50             |
| 185. | Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.  | -               | Үнэлгээний тайлан | -   | Үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулсан байна. | ХШҮДАГ        | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажлын байр эзэнгүй байгаа тул арга хэмжээг хэрэгжүүлээгүй.   | 0              |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж                         | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                 | Суурь түвшин                                    | Зорилтот түвшин   | Хариуца х нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|----------------------------------|---|---|----------------|---|----------------|
| 186. | Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд улирал тугам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.   | -               | Үнэлгээний тайлан                | -   | Үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлд танилцуулсан байна.   | ХШҮДАГ         | Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2022 оны хурлын шийдвэрүүдийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийг 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр батлуулсан. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ажлын байр эзэнгүй байгаа тул арга хэмжээг хэрэгжүүлээгүй.   | 0              |
| 187. | Эрүүл мэндийн яамны байгууллагуудын 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.                 | -               | Үнэлгээний тайлан                | Жил бүр үнэлгээ хийж, санал, зөвлөмж гаргадаг.  | Тайланг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | ХШҮДАГ         | 1. Эрүүл мэндийн байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/14 дүгээр тушаалаар батлуулсан. Ажлын хэсэг үнэлгээг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан гүйцэтгэсэн ба ЭМЯ-ны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ-үүд 79.6%-ийн гүйцэтгэлтэй, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газрууд 74.9%-ийн гүйцэтгэлтэй, салбарын хэмжээнд 2022 оны гүйцэтгэл 77.2% буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн. Үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн 2023.04.04-ны өдрийн өргөтгөсөн хурлаар танилцуулсан. Тайлан, зөвлөмжийг харьяа байгууллага, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, БОЭТ-үүдэд 2023.04.06-ны өдрийн 1а/1494, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газарт 2023.03.31-ны өдрийн 1а/1368 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагуудын 2023 оны эхний хагас жилийн чанарын үзүүлэлтийн биелэлтэд гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж гүйцэтгэсэн. Үнэлгээгээр эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт эхний хагас жилийн байдлаар 78.3% буюу "тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдсэн. Үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн 2023.07.06-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Тайлан, зөвлөмжийг харьяа байгууллага, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газарт 2023.07.07-ны өдрийн 2/3239 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100            |
| 188. | Эрүүл мэндийн яамны 2022 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.                         | -               | Үнэлгээний тайлан                | Жил бүр үнэлгээ хийж, санал, зөвлөмж гаргадаг.  | Тайланг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | ХШҮДАГ         | Эрүүл мэндийн яамны 2022 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний дүнг 75.9 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн. Үнэлгээний дүнг ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Тайланг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 1а/852 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд Мэдээллийн ил тод, нээлттэй байдал, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнг оруулж баталгаажуулсан.   | 100            |
| 189. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 5 дугаар зарлигийн дагуу ҮАБЗ-ийг холбогдох мэдээ, мэдээллийг хүргүүлнэ. | -               | Хүргүүлсэн мэдээллийн төрөл, тоо | Мэдээллийг тогтсон хугацаанд ҮАБЗ-д хүргүүлдэг. | Мэдээллийг ҮАБЗ-д хугацаанд нь хүргүүлсэн байна.                | ХШҮДАГ         | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигийн дагуу Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг эрүүл мэндийн холбогдох мэдээллээр хангах ажлын хүрээнд 2023 оны эхний хагас жилийн байдлаар Хүн амын өвчлөл, эндэгдлийн мэдээ; Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалт, хянах, эмчлэх үйл ажиллагаа, үзүүлэлтийн тухай мэдээ, тайлан; Эрүүл мэндийн салбарт шинээр болон шинэчилсэн стандартуудын тухай танилцуулах мэдээ; Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн үйл  | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт                                 | Суурь түвшин                                   | Зорилтот түвшин                                      | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|--|--|--|---------------|--|----------------|
|      |  |                 |  |  |  |               | ажиллагаа, эрсдэлийн мэдээ; Зүрх, мэдрэлийн төвийн үйл ажиллагаа, эрсдэлийн мэдээ зэрэг 5 төрлийн танилцуулах мэдээг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 2/3245 дугаар албан бичгээр УАБЗ-ийн Нарийн бичгийн даргад хүргүүлсэн. 2023 оны сүүлийн хагас жилийн байдлаар Хүн амын өвчлөл, эндэгдлийн мэдээ; Халдварт бус өвчний эрт илрүүлгийн хамрагдалт, хянах, эмчлэх үйл ажиллагаа, үзүүлэлтийн тухай мэдээ, тайлан; Эрүүл мэндийн салбарт шинээр болон шинэчилсэн стандартуудын тухай танилцуулах мэдээ; Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн үйл ажиллагаа, эрсдэлийн мэдээ; Зүрх, мэдрэлийн төвийн үйл ажиллагаа, эрсдэлийн мэдээ зэрэг 5 төрлийн мэдээ; 2023 оны жилийн эцсийн байдлаар Төрөлт ойртолт, түүний хүн амд эзлэх зохистой харьцааны алдагдал, архи, мансууруулах болон сэтгэцэд хүчтэй нөлөөлөх бодис хэрэглэх, донтох эмгэг, сэтгэцийн эмгэг зан үйл, оюуны хомсдолтой хүмүүсийн мэдээ, судалгаа; Шинэ болон сэргэн тархаж буй халдварын болзошгүй аюулаас сэргийлэх бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ, халдвар, хордлогын өвчлөл, эрсдэлийн тухай; Товлолын болон тархвар зүйн вакцин, биобэлдмэлийн нөөцийн хүрэлцээ, хангамж, устгалын тухай; Эмнэлзүйн лабораторийн гадаад, дотоод чанарын хяналтын тухай; Цэргийн насны иргэдийн эрүүл мэндийн төлөв байдлын тухай мэдээ зэрэг 5 төрлийн танилцуулах мэдээ, нийт 10 төрлийн мэдээ, тайланг ЭЭХХЗГ, ЭМХТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ, ЭХЭМҮТ, СЭМҮТ, УГТЭ-ээс тус тус авахаар 2/5328-2/5333 дугаар албан бичгээр, ЭМЯ-ны газруудаас Дотоод меморандум №.....-аар авахаар хүргүүлсэн. 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 2/..... дугаар албан бичгээр УАБЗ-ийн Нарийн бичгийн даргад хүргүүлсэн. |                |
| 190. | Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан Дотоод аудитын 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийнэ. | -               | Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан | Тайланг дотоод аудитын хороогоор хэлэлцүүлдэг. | Тайланг дотоод аудитын хороогоор хэлэлцүүлсэн байна. | ХШҮДАГ        | Дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөнд нийт 18 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан. Үүнээс - Дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөнд 2023 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн хяналт шалгалт хийх 14 арга хэмжээ тусгаснаас 14 байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийж, тайлан боловсруулсан. Төлөвлөгөөний биелэлт 80.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:<br>1. Эмгэг судлалын үндэсний төвийн 2022 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт (90.0%);<br>2. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн сангуудад олгосон санхүүжилтэд дотоод аудит (100.0%);<br>3. Өмнөговь аймаг дахь БОЭТ-ийн 2022 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт (90.0%);<br>4. Сэлэнгэ аймгийн ЭМГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагааны хяналт шалгалт (90.0%);<br>5. ЭМЯ-ны аппаратын 2022, 2023 оны 1 дүгээр улиралд олгосон албан хаагчдын цалин, хөлс, урамшууллын дотоод аудит (100.0%);<br>6. УНТЭ-ийн гүйцэтгэлийн санхүүжилт, худалдан авах ажиллагаа, цалин хөлс, урамшууллын дотоод аудит (70.0%);<br>7. Нийслэлийн эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагааны хяналт шалгалт (50.0%);   | 90             |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин                           | Зорилтот түвшин                              | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|------------------|--|--|---------------|--|----------------|
|      |  |                 |                  |  |  |               | <p>8. Архангай аймгийн эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт (90.0%);</p> <p>9. Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II-ын гүйцэтгэлийн санхүүжилт, цалин хөлс, урамшууллын дотоод аудит (30.0%);</p> <p>10. Орхон аймгийн БОЭТ-ийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагааны хяналт шалгалт (80.0%);</p> <p>11. Эрүүл мэндийн байгууллагуудын мөнгөн тэтгэмжийн дотоод аудит (70.0%);</p> <p>12. Эрүүл мэндийн тухай хуульд заасан мөнгөн тусламжийн дотоод аудит (90.0%);</p> <p>13. Хандив, тусламжийн зарцуулалтад гүйцэтгэлийн аудит (90.0%);</p> <p>14. Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагаа, санхүүжилтийн дотоод аудит (90.0%).</p> <p>- Дотоод аудитын 2023 оны төлөвлөгөөнд жилийн эцсийн байдлаар дотоод аудит хийх 4 арга хэмжээ тусгаснаас 4 төслийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, тайлан боловсруулсан. Төлөвлөгөөний биелэлт 80.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:</p> <p>1. Эрүүл мэндийн сайдын баталсан удирдамжийн дагуу Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах” төслийн 2022 оны оны төлөвлөлт, үйл ажиллагаа, төлөвлөгөө, зорилго, зорилтын хэрэгжилт, санхүүжилт, худалдан авалт, зарцуулалт зэрэг асуудлыг хамарсан үнэлгээ, дотоод аудит (100.0%);</p> <p>2. Цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээ авах, эрүүл мэндийн тогтоолцооны чадавхийг бэхжүүлэх төслийн (MON-9218) хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ, дотоод аудит (100.0%);</p> <p>3. КОВИД-19-ын эсрэг вакцинжуулалтын арга хэмжээг дэмжих төсөл (L4068-MON, L4069-MON, L8399), Азийн хөгжлийн банк (70.0%);</p> <p>4. Орон нутагт явуулын эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай тоноглолгдсон автомашин ханган нийлүүлэх төсөл, Бүгд Найрамдах Польш Улс (50.0%)</p> <p>Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайланг Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлээгүй байна.</p> |                |
| 191. | Засгийн газрын 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн дагуу Дотоод аудитын 2022, 2023 оны үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана. | -               | Тайлан           | Тайланг СЯ-нд хугацаанд нь хүргүүлдэг. | Тайланг СЯ-нд хугацаанд нь хүргүүлсэн байна. | ХШҮДАГ        | <p>Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн дагуу Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжийн 2022 оны үйл ажиллагааны тайланг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 8/120 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын нэгжийн 2023 оны эхний хагас жилд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэн боловсруулж, 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 8/4463 дугаар албан бичгээр Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн.</p>   | 90             |

| Д/д   | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|---|--|-----------------|---|--|--|---------------|--|----------------|
| 192.  | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудын болон төсөл, хөтөлбөрийн 2023 оны Шилэн дансны хөтлөлт, хуулийн хэрэгжилтэд улирал тутам хяналт тавина.   | -               | Цахим санд байршуулсан шилэн дансны мэдээллүүд            | СЯ-ны <a href="https://shilendan.s.gov.mn.reportor">https://shilendan.s.gov.mn.reportor</a> цахим санд мэдээллийг байршуулдаг. | Сангийн яамны <a href="https://shilendan.s.gov.mn.reportor">https://shilendan.s.gov.mn.reportor</a> цахим санд мэдээлэл шинэчлэгдэн орсон байна. | ХШҮДАГ        | Шилэн дансны цахим мэдээлэл шинэчлэгдсэнээр Шилэн дансны нэгдсэн портал систем, Эрүүл мэндийн яамны цахим хуудсанд мэдээлэл байршуулах журмыг Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/32 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай 2023 оны 2/848 дугаар албан бичиг хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. 2023 оны 12 дугаар сарын 04-ний байдлаар 280 мэдээлэл байршуулахаас 260 мэдээлэл хуулийн хугацаанд байршуулж, 20 мэдээлэл хугацаа хоцроосон байна. 2023 оны 1, 2 дугаар улирлын шилэн дансны тайланг Сангийн яамны <a href="http://info.shilendans.gov.mn/">/info.shilendans.gov.mn/</a> цахим санд 5 дугаар сарын 05, 09 дүгээр сарын 18-ны өдөр хүргүүлсэн. Цахим санд байршуулаагүй мэдээллийг Дотоод меморандум № 89, 108 болон 221-аар Санхүү, эдийн засгийн газарт тус тус хүргүүлж, мэдээллийг нөхөн байршуулуулсан байна. | 100            |
| 193.  | Үндэсний аудитын газраас Эрүүл мэндийн яам, Сайдын багцын эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөрт хийгдсэн аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд явцын хяналт тавьж, биелэлтийг хангуулна. |                 | Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн тайлан. | Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг хүргүүлдэг.  | Аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг хүргүүлсэн байна.  | ХШҮДАГ        | Үндэсний аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитын системд “Санхүүгийн тайлангийн аудит”-аар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг эрүүл мэндийн байгууллага бүрээр нэгтгэн <a href="https://fas.audit.mn">https://fas.audit.mn</a> цахим санд баталгаажуулан бүртгүүлсэн. Мэдээллийг Үндэсний аудитын газрын аудитор Ц.Сугармаа хянаж, аудитор В.Эрдэнэцогт баталгаажуулсан болно. Эрүүл мэндийн сайдын багцын 2022 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн биелэлтийг 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 1а/3972 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.   | 100            |
| 8. Салбарын хяналтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан хүний эрүүл, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулна. |  |                 |   |  |  |               |  |                |
| 194.  | Эрүүл ахуйн тухай хуулийн 7.2 “Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж батлуулна.  | -               | Батлагдсан дүрмийн тоо                                    | МХЕГ-ын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалаар батлагдсан 7 үлгэрчилсэн дүрэм мөрдөгдөж байна.                                 | Дүрмүүдийг шинэчлэн батлуулсан байна.  | СХГ           | Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн 2 дүрмийг шинээр, 6 дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн “Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм батлах тухай” А/406 дугаар тушаалаар батлуулсан. “Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм батлах тухай” Эрүүл мэндийн сайдын тушаалын төсөлд хийсэн нөлөөллийн шинжилгээ, танилцуулгыг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр 2023.11.28-ны өдрийн 3/5377 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газарт хүргүүлээд байна.  | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт              | Суурь түвшин   | Зорилтот түвшин                             | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|-------------------------------|--|---|---------------|--|----------------|
| 195. | Тамхины хяналтын тухай хуулийн 6.1 "Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам"-ыг шинэчлэн боловсруулж батлуулна.  | -               | Батлагдсан журам              | ЗГ-ын 2013 оны 191 тогтоолоор батлагдсан журмыг төрдөж байна.  | Журмыг шинэчлэн батлуулсан байна.           | СХГ           | "Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа үйлчилгээнд хяналт тавих журам"-ын 4 бүлгийн 5 заалтад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан. Тамхины хяналтын тухай хууль шинэчлэн батлагдсаны дараа шийдвэрлэхээр хүлээгдэж байна.   | 30             |
| 196. | Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 18.2 "Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн шийдвэр болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх журам"-ыг шинэчлэн боловсруулна   | -               | Батлагдсан журам              | Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны 86/А/400 тушаалаар батлагдсан журам  | Журмыг шинэчлэн батлуулсан байна.           | СХГ           | Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 4 дэх, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.6.3, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.2 дахь заалтад оруулсан нэмэлт өөрчлөлтийг үндэслэн "Эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх журам" батлах тухай хамтарсан тушаалын төслийг боловсруулан, холбогдох газруудаас ирүүлсэн саналыг нэгтгэн ажиллаж байна.  | 30             |
| 197. | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.2, 12.2; ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн 10.2.5 Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой журам, зааврыг шинэчлэн боловсруулна. | -               | Батлагдсан журам, зааврын тоо | Хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын хамтран баталсан журам, заавар-3 | 3 журам, зааврыг шинэчлэн батлуулсан байна. | СХГ           | 1.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.2-д заасан "Хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар"-ыг шинэчлэн боловсруулах 3 удаагийн хэлэлцүүлэгт оролцож зөвлөмжийн бүлэг, дэд сэдэв, агуулгад санал өгч хэлэлцүүлсэн.<br>"Гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохистой дадал"-ыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар"-ын төсөлд нэмэх 1, хасах 2, өөрчлөх 12 санал боловсруулан Нийтийн эрүүл мэндийн газарт хүргүүлж нэгтгэн ХХААХҮЯ-нд цахимаар хүргүүлсэн.<br>2.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.2-д заасан Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын 2013 оны хамтран баталсан "Зайлшгүй сав, баглаа боодол болон шошго хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний төрлийг тодорхойлох, шошголох журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж (өөрчлөн найруулах 2 бүлэг 10 заалт) ХХААХҮЯ-нд 2023.06.02-ны өдрийн 9/2530 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>3. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн 10.2.5-д заасан "Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам"-ыг шинэчлэн боловсруулах санал боловсруулан(журмын төсөлд нэмж тусгах 6, өөрчлөн найруулах 7, хасах 1 санал), дотоод сүлжээгээр газруудаас санал авч, БШҮЯ-д Салбарын хяналтын газрын | 50             |



| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин  | Зорилтот түвшин   | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|---|---|---|---------------|--|----------------|
|      |   |                 |   |   |   |               | даргын 2023.04.05-ны өдрийн 9/1466 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>БШУЯ-аас журамд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн 2023.10.04-ний өдрийн 1а/4633 дугаар албан бичгээр ирүүлсэнтэй танилцан 6 санал боловруулж дахин хүргүүлсэн ба батлагдах шатандаа байна.   |                |
| 198  | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.2.3 Хууль, тогтоомж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын хэрэгжилтийн хяналт шалгалтын дүнг үндэслэн санал боловсруулна    |                 | Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь   |   | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ЗГ-ын хуралдаанд танилцуулсан байна.                                     | СХГ           | Хууль, тогтоомж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын хэрэгжилтийн хяналт шалгалтын дүнг үндэслэн нийслэл, орон нутгийн Эрүүл мэндийн газрын Хяналт шалгалтын хэлтсүүдээс салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг загвар хүснэгтийн дагуу авч, саналыг нэгтгэж, дүн шинжилгээ хийсэн. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээг үндэслэн санал боловсруулж, Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.  | 0              |
| 199. | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 <sup>1</sup> .1 Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгуулна. | -               | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь   | -   | Төлөвлөгөө батлагдаж хэрэгжсэн байна.   | СХГ           | Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 79 дүгээр тогтоолоор Салбарын хяналт шалгалтын нийтлэг төлөвлөгөө, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/126 дугаартай тушаалаар “2023 онд хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт”-ыг батлуулсан. Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтууд 100 хувь бүрэн хэрэгжиж, төлөвлөгөөт шалгалтаар объектын хамралт 86.52 хувьтай байна  | 90             |
| 200. | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.2.1 Объектийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулан, эрсдэлийн үнэлгээ хийнэ.                   | -               | Батлагдсан шалгуур үзүүлэлтийн тоо<br><br>Эрсдэлийн үнэлгээ хийсэн объектын тоо | Батлагдсан шалгуур үзүүлэлт-13<br><br>Эрсдэлийн үнэлгээ хийсэн объектын тоо-35338 | Шалгуур үзүүлэлтүүд шинэчлэн баталж, үйл ажиллагаа явуулж буй объектыг 100% үнэлгээнд хамруулсан байна. | СХГ           | Объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах 16 шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, тогтоолын төсөлд бусад яам, газраас ирүүлсэн саналыг тусган ЗГХЭГ-т хүргүүлж, 2023.05.24-ний өдрийн 195 дугаар тогтоолоор батлагдсан. Салбарын хяналтын чиглэлээр 2023 оны объектын эрсдэлийн үнэлгээгээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 3352 объектод төлөвлөгөөт шалгалт хийхээр төлөвлөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн, Засгийн газрын 2023 оны 03 сарын 01-ний өдрийн 79 дүгээр тогтоолоор батлагдсан. 2023 оны 11 сард объектын эрсдэлийн үнэлгээ хийж их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 2208 объектод төлөвлөгөөт шалгалт хийхээр төлөвлөн ЗГХЭГ-т, 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. | 70             |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт   | Суурь түвшин   | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|--|--|--|---------------|---|----------------|
| 201. | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.2.1 Хяналтын хуудсыг хяналтын чиглэл бүрээр боловсруулж, батлуулна.  | -               | Шинэчлэгдэн батлагдсан хяналтын хуудасны тоо   | Батлагдсан хяналтын хуудасны тоо-64  | 64 хяналтын хуудсыг шинэчлэн баталсан байна.   | СХГ           | Салбарын хяналтын чиглэлийн нийт 65 хяналтын хуудсыг шинэчлэн, 1 хяналтын хуудсыг шинээр боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/78 дугаар тушаалаар батлуулан хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.  | 100            |
| 202. | Орчны эрүүл мэнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.4 Хот суурин газрын хүн амын ундны усны чанар, аюулгүй байдалд эрсдэлд суурилсан хяналт хийнэ. |                 | Хамрагдсан объектын тоо<br><br>Шинжилсэн дээжийн тоо<br><br>Шаардлага хангаагүй дээжийн эзлэх хувь | Хамрагдсан объектын тоо 1563<br><br>Шинжилсэн дээжийн тоо 2965<br><br>Шаардлага хангаагүй дээжийн хувь 8.6 | Хамрагдсан объектын тоог өмнөх оныхоос 10 хувиар нэмэгдүүлсэн байна.<br>Шаардлага хангаагүй дээжийн эзлэх хувийг 8 хувь хүртэл бууруулсан байна. | СХГ           | Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх шалгалтад нийслэл, аймаг, сумдын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн 114 гүний худаг, 16 насос станц, 5 хлоржуулах станц, 141 зөөврийн ус түгээх байр, 124 шугамаар ус түгээх байр, сумдын болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэний 704 худаг, төвлөрсөн бус ус хангамжтай 65 хэрэглэгч, ус хангамжийн төвлөрсөн сүлжээний хэрэглэгч 524, ус зөөврийн машин 3, гадаргын ус 7 нийт 1703 объектыг хамруулан нийт 2951 усны дээж авч, ХАБҮЛЛ, Стандарт, хэмжилзүйн газрын Нийслэлийн лаборатори, аймгууд дахь Стандарт, хэмжилзүйн хэлтсийн харьяа лабораторид нян судлал, химийн үзүүлэлтээр шинжлүүлэн үнэлгээ өгөв.<br>Шинжлэгдсэн нийт дээжийн 4.3% нь нян судлалын үзүүлэлтээр, 12.4% нь химийн үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй дүнтэй байв. Хяналт шалгалтын явцад унд ахуйн усны чанар, аюулгүй байдалд хийсэн шинжилгээний дүнг үндэслэн улсын байцаагчийн 269 дүгнэлт гаргаж шалгагдсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хүргүүлсэн.<br>Шалгалтаар илрүүлсэн зөрчлийг арилгуулахаар улсын байцаагчийн 1277 заалттай 123 албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, Зөрчлийн тухай хуулийн дагуу 3 аж ахуйн нэгжид 6.0 сая.төг-ийн шийтгэврийн арга хэмжээ ногдуулсан. Хяналт шалгалтын явцад авсан усны дээжийн шинжилгээний дүнгээр стандартын шаардлага хангаагүй нийслэлийн 68 аж ахуйн нэгжийн шугам сүлжээ, усны нөөцийн саванд угаалга, халдваргүйжүүлэлтийг хийлгэн, усны шинжилгээг давтан хийлгэж, стандартын шаардлагад нийцүүлэн ажиллалаа. | 100            |
| 203. | Орчны эрүүл мэнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.2.7 Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшинд хяналт хийнэ.             |                 | Хамрагдсан объектын тоо  | Хамрагдсан объектын тоо 102  | Хамрагдсан объектын тоог өмнөх оныхоос 10 хувиар нэмэгдүүлсэн байна.   | СХГ           | Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх удирдамжийн хүрээнд нийт 118 объектод хяналт шалгалт хийж, 35 ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжаас 65 хаягдал усны дээж, мах, махан бүтээгдэхүүний 19, гурилан бүтээгдэхүүний 11, архи спиртийн 8, сүү, сүүн бүтээгдэхүүний 7, ундаа жүүсний 3, өлөн боловсруулах 4, арьс шир боловсруулах 2, ноос ноолуурын 1 нийт 55 үйлдвэрээс ариутгах татуургын төвлөрсөн шугамд нийлүүлж буй хаягдал уснаас нийт 56 хаягдал усны дээж авч Стандарт, хэмжилзүйн газрын харьяа Нийслэл, аймгийн лабораторид шинжлүүлж, хаягдал усны шинжилгээний дүнд үндэслэн улсын байцаагчийн 49 дүгнэлт, 126 заалттай 42 албан шаардлагыг аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн.   | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж   | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин  | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)   | Гүйцэтгэл хувь |
|------|---|-----------------|---|---|--|---------------|---|----------------|
| 204. | Орчны эрүүл мэнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.2.5. Эрүүл ахуйн урьдчилсан хяналтын явцад дотоод орчны барилгын материалын аюулгүй байдалд хяналт хийж, мэдээллийн сантай болно. |                 | Хяналт хийсэн объектын тоо<br><br>Шинжилсэн сорьцын тоо | 31 объектын 325 сорьцонд дэгдэмхий органик нэгдэл тодорхойлох шинжилгээ хийсэн. | 50 объектод дэгдэмхий органик нэгдэл тодорхойлох шинжилгээ хийсэн байна. | СХГ           | 2023 онд барилгын дотоод орчны агаарт 140 сорьцонд хийсэн дэгдэмхий органик нэгдлийн шинжилгээний дүнг “Ногоон титэм” ХХК-ийн хөгжүүлсэн GREEN-GROWN LIMS системд оруулсан ба эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийдэг байцаагч нарт тус системд нэвтэрч шинжилгээний дүн, графикт тайлантай танилцах эрхтэй болсон. Салбарын хяналтын газрын даргын баталсан хөтөлбөрийн дагуу эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нарт LIMS системийг ашиглах талаар сургалт хийж тус лабораторийн үйл ажиллагаатай танилцах үйл ажиллагааг зохион байгуулсан. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисст ажиллах явцад итгэмжлэгдсэн лабораторид дотоод орчны барилгын материалаас ялгарах дэгдэмхий органик нэгдлийг тодорхойлох шинжилгээг 29 барилга байгууламжийн 140 сорьцонд хийлгэж үнэлгээ өгсөн.   | 50             |
| 205. | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.3 Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн нэгдсэн бүртгэлтэй болно.  |                 | Баяжилт хийсэн нэгдсэн бүртгэл                          | -   | Нэгдсэн бүртгэл үүсгэж, тогтмол баяжилт хийсэн байна.                    | СХГ           | Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас зөрчлийн бүртгэлийн мэдээ авах загвар хүснэгт боловсруулан хүргүүлж, мэдээг улирал тутам цахим хаягаар хүлээн авч, нэгтгэж байна. Тайлант хугацаанд нийт 175 зөрчлийн хэрэг бүртгэгдсэнээс Зөрчлийн хэрэг нээсэн 16 харъялалын дагуу шилжүүлсэн 1, хүлээн авахаас татгалзсан 1 хялбаршуулсан журмаар 157 зөрчлийн хэргийг шийдвэрлэж ажилласан. Нийслэлийн эрүүл мэндийн газарт 103, Баянхонгор аймгийн эрүүл мэндийн газарт 25 хэрэг бүртгэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлттэй дүн байна. Салбарын хяналтын газарт 3 зөрчил бүртгэгдэж, хялбаршуулсан журмаар 2 хэргийг шийдвэрлэж, 1 зөрчлийн хэргийн шалган шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна. Салбарын хяналтын газраас нийт улсын(ахлах) байцаагчдыг зөрчлийн хэрэг бүртгэлтийн талаар шаардлагатай мэдээ мэдээлэл, арга зүйгээр тогтмол хангаж, Нийслэлийн прокурорын газартай хамтран 2 удаагийн танхим, цахим хосолсон сургалтыг зохион байгуулсан. | 100            |

| Д/д  | Стратеги Төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж  | Төсөв (сая төг) | Шалгуур үзүүлэлт  | Суурь түвшин | Зорилтот түвшин  | Хариуцах нэгж | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)  | Гүйцэтгэл хувь |
|------|--|-----------------|---|--------------|--|---------------|--|----------------|
| 206. | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.14 Эрсдэлийн үнэлгээ, хяналтын хуудас, хяналт шалгалтын төлөвлөгөө, хэрэгжилтийн мэдээллийн сан бүрдүүлнэ. |                 | Тогтмол баяжилт хийсэн мэдээллийн сан                     | -            | Мэдээллийн сан байгуулж, тогтмол баяжилт хийсэн байна. | СХГ           | 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 79 дүгээр тогтоолоор бүртгэл, хяналтын удирдлагын нэгдсэн цахим системийг шинэчилж ажиллуулахыг Цахим хөгжлийн яаманд даалгасан боловч одоогоор хөгжүүлэлт хийгдээгүй, систем ажиллахгүй байна. Үүнтэй холбоотой ЦХХХ-ны яаманд 2023.07.24-ний өдрийн 9/3399, 2023.10.10-ны 9/4724 дугаар албан бичгээр "Хяналт шалгалтын, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан"-г яаралтай хэвийн үйл ажиллагаанд оруулж өгөхийг хүссэн албан тоот 2 удаа хүргүүлсэн.<br>Мөн тус яаманд 2023.09.11-ний өдрийн 9/4111 дугаартай албан бичгээр хяналт шалгалтын нэгдсэн системийн хөгжүүлэлт хийхэд шаардлагатай мэдээллийг хүргүүлэн ажиллалаа.<br>Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023.08.08-ны өдрийн 77 дугаар тушаалаар байгуулагдсан салбарын хяналт шалгалттай холбоотой уялдаа холбоог сайжруулах үүрэг бүхий ажлын хэсэгт Салбарын хяналтын газрын дарга С.Сүнчин ажиллаж байгаа бөгөөд тус ажлын хэсгийн санал, зөвлөмжийн дагуу цахим системийг яаралтай шинэчилж ажиллуулахыг Засгийн гарын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлээр Цахим хөгжил, харилцаа холбооны сайдад үүрэг өгөгдсөн.<br>- 2023 оны төлөвлөгөөт хяналт шалгалтыг 3310 объектыг хамруулахаар төлөвлөснөөс 2635 объект хамрагдсан ба хяналт шалгалтын мэдээллийг батлагдсан удирдамж бүрийн хүрээнд хяналтын хуудас тус бүрээр эксел програмаар нэгтгэж, сан бүрдүүлээд байна. | 30             |
| 207. | Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1.3 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын улсын байцаагчдын зөвлөгөөн зохион байгуулна.                                 |                 | Зохион байгуулсан зөвлөгөөний тоо<br>Хамрагдсан хүний тоо | -            | Зөвлөгөөн зохион байгуулсан байна.                     | СХГ           | Эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын чиг үүрэг салбарын яаманд шилжсэнтэй холбогдуулан шинээр гарсан эрх зүйн зохицуулалт, хяналт шалгалтын төлөвлөгөө түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр Аймаг, нийслэлийн ЭМГ-ын нийт 128 улсын байцаагчдад цахим сургалтыг 2023 оны 03 сард зохион байгуулж мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.<br>Нийтийн эрүүл мэндийн газартай хамтран хэрэгжүүлэх бөгөөд удирдлагын өгсөн чиглэлийн дагуу хугацааны хувьд хойшилсон.  | 0              |
| НИЙТ |  |                 |   |              |  |               |  | 71,7           |

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ШИЙДВЭР


2023 оны 12 дугаар сарын 26

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 71.7 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үзэх
2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 0-30 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн 45 үйл ажиллагааг Эрүүл мэндийн яамны 2024 оны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангахыг газар, хэлтсийн дарга нарт даалгах

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  С.ТӨГСДЭЛГЭР



ДОТООД МЕМОРАНДУМ № 01

---

Хэнд: Эрүүл мэндийн яамны газар, хэлтсийн дарга нарт  
Хэнээс: Төрийн нарийн бичгийн даргаас  
Утга: ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн шийдвэр хүргүүлэх тухай  
Огноо: 2024 оны 01 дүгээр сарын 02

Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 0-30% үнэлэгдсэн дараах 45 ажлыг 2024 оны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Удирдлагын зөвлөлийн хурлаар шийдвэрлэсэн ба хурлын шийдвэр болон холбогдох мэдээллийг хүргүүлж байна. Хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Жич: ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлын шийдвэр хуудас

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



С.ТӨГСДЭЛГЭР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ  
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ШИЙДВЭР


2023 оны 12 дугаар сарын 26

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 71.7 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэж үзэх
2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр 0-30 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн 45 үйл ажиллагааг Эрүүл мэндийн яамны 2024 оны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангахыг газар, хэлтсийн дарга нарт даалгах

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  С.ТӨГСДЭЛГЭР



**Эрүүл мэндийн яамны 2023 оны гүйцэтгэлийн  
төлөвлөгөөнд батлагдсан ч 0-30% хэрэгжилттэй ажлууд**

❖ 0 буюу хэрэгжээгүй 22 ажил:

ЭТҮГ:

1. Д вирустэй иргэдийг эмчилгээнд хамруулна
2. Цусны донорын тухай хуулийн төслийг боловсруулна.
3. Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх арга хэмжээний (2023-2026) төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулна.
4. Хавдрын тусламж, үйлчилгээний төвлөрлийг бууруулж, чанар, хүртээмжийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангана.
5. Эрүүл насжилтыг дэмжих арга хэмжээний (2023-2026) төлөвлөгөөг боловсруулж батлуулна.

НЭМГ:

1. Шаардлагатай аймгуудад ЗӨСТ, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулах
2. Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна.
3. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14.1 Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг батлуулах.
4. Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль 15.3 Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг боловсруулах.
5. Дархлаажуулал-тын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тушаал шинэчлэн батлуулна.
6. Эрүүл ахуйч, тархвар судлаачдын Үндэсний IV зөвлөгөөн зохион байгуулах.
7. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүрэм, стандартуудыг шинэчилнэ.

СХГ:

1. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.2.3 Хууль, тогтоомж, нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын хэрэгжилтийн хяналт шалгалтын дүнг үндэслэн санал боловсруулна
2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9.1.3 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын улсын байцаагчдын зөвлөгөөн зохион байгуулна.

СЭЗГ:

1. Сүрьеэгийн эмнэлэг барьж, ашиглалтад оруулна.
2. Ховд аймгийн БОЭТ-ийн барилгын өргөтгөл барина.

БТГ:

1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга (нэмэлт, өөрчлөлт)-ын төсөл боловсруулж батлуулна.
2. "Хүний генетикийн тухай хууль"-ийн төслийг боловсруулна
3. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ХШҮДАГ:

1. Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.
2. Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

ТЗУГ:

1. Хүний эрхийн асуудлаар Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулна.



- ❖ 30% буюу “тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа” 23 ажил:

#### ЭТҮГ:

1. Орон нутагт шаардлагатай газарт яаралтай тусламжийн цэг байгуулна.
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 11.2 Жолоочийн эрүүл мэндэд тавих шаардлага, жолоочийн эрүүл мэндийн үзлэг явуулах журам, үзлэгийн хуудасны загвар, үзлэг явуулах эрх бүхий эмнэлгийн байгууллагын жагсаалт, тээврийн хэрэгсэл жолоодоход харшлах эм, бэлдмэл, тээврийн хэрэгсэлд байх эмийн сангийн иж бүрдлийн жагсаалт, зам тээврийн осолд өртсөн хүнд эмнэлгийн тусламж үзүүлэх журам боловсруулж батлуулна.
3. Эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх журмыг шинэчлэн батлуулна.
4. Уламжлалт анагаах ухааны эмийн бүртгэлийн эрхзүйн орчинг шинэчилнэ.
5. Өлсгөлөн зарлахад харшлах өвчний жагсаалт, өлсгөлөн зарласан үед эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зааврыг боловсруулж батлуулна.
6. Донорт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөнгөлттэй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах журмыг шинэчилнэ.

#### НЭМГ:

1. Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулах замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх
2. Хүн амн хоол тэжээлийн VI судалгаа үндэсний түвшинд зохион байгуулах.
3. Төвлөлт дархлаажуулалтад хүний папиллома вирусийн эсрэг вакцин нэвтрүүлэх.
4. Хүүхдийг тамхины хор хөнөөлөөс сэргийлэх зарим арга хэмжээг хэрэгжүүлэх.
5. Эрүүл мэндийн салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх.

#### СХГ:

1. Тамхины хяналтын тухай хуулийн 6.1 “Тамхины үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулна.
2. Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 18.2 “Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжсэн шийдвэр болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх журам”-ыг шинэчлэн боловсруулна
3. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5.14 Эрсдэлийн үнэлгээ, хяналтын хуудас, хяналт шалгалтын төлөвлөгөө, хэрэгжилтийн мэдээллийн сан бүрдүүлнэ.

#### СЭЗГ:

1. Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна.
2. Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барьна.
3. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно.

#### БТГ:

1. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.
2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхыг нэмэгдүүлж, аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах.
3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай шинэчилсэн найруулга (нэмэлт, өөрчлөлт)-ын төсөл боловсруулж батлуулна.
4. Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж батлуулна.
5. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг даатгалын санхүүжилтийн 8 хувиар байгуулсан байна.
6. Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг нэвтрүүлнэ.